

ШИНЭ ҮЕИЙНХЭН АЙСУЙ

АГУУ ЗАХИРАМЖИЙГ БИЕЛҮҮЛЭХ ШИНЭ
ҮЕИЙН УДИРДАГЧДЫГ ӨСГӨХ НЬ





ШИНЭ ҮЕИЙНХЭН АЙСУЙ

АГУУ ЗАХИРАМЖИЙГ БИЕЛҮҮЛЭХ ШИНЭ ҮЕИЙН
УДИРДАГЧДЫГ ӨСГӨХ НЬ

ГЛОБАЛ АДВАНС ШИНЭ ҮЕ ГАРЫН АВЛАГА
БЭЛТГЭСЭН
КЭЙТ ВЭСТ

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	i
УДИРТГАЛ	a
2016 ГЛОБАЛ ХЭРЭГЦЭЭ СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ	i
ЗАРЧИМ 1: ОРОЛЦООГ ДЭМЖИГЧ УДИРДАГЧ.....	1
ЗАРЧИМ 2: ЗОРИЛГОТОЙ УДИРДАГЧ	10
ЗАРЧИМ 3: ХАРИЛЦААНЫ ЧАДВАРТАЙ УДИРДАГЧ.....	19
ЗАРЧИМ 4: ӨӨРЧЛӨЛТ АВЧИРДАГ УДИРДАГЧ	28
ЗАРЧИМ 5:СҮНСЛЭГ УДИРДАГЧ	35
ЗАРЧИМ 6: НИГҮҮЛСЭНГҮЙ УДИРДАГЧ.....	49
ЗАРЧИМ 7: ХҮЧИРХЭГЖҮҮЛДЭГ УДИРДАГЧ.....	58
ДҮГНЭЛТ.....	71
НОМ ЗҮЙ.....	73

ӨМНӨХ ҮГ

Бурхан олон үе дамнаж хараа зорилгоо хэрэгжүүлдэг. Хүн төрөлхтөн бид Бурханыг алдаршуулах түүхэн үйлст нэг үеэс нөгөө үед дамжин оролцсоор явна. Харин энэхүү түүхэн хэлхээг Христийн бие дотор үргэлжлүүлэхэд биднээс багагүй хүчин чармайлт шаарддаг билээ. Үеүдийн хооронд завсар зай гараагүй ч удирдагчдын хомсдол орон зай үүссэн гэж хэлэхүйц нөхцөл байдал дунд бид иржээ.

Глобал Адванс (Global Advance) байгууллага нь дэлхий даяар агуу захирамжид үйлчлэгч агуу удирдагчдыг бэлтгэж, тэдэнд үйлчилсээр ирсэн билээ. Хэдэн жилийн өмнө дэлхий даяар хамтран ажиллагч улсуудынхаа дунд судалгаа хийж эхэлсэн бөгөөд бид тэднээс хувь хүмүүс болон сүм чуулганы хувьд тулгардаг сорилт бэрхшээлүүдийг эрэмбэлэхийг хүссэн билээ. Бараг бүх тивийн удирдагчид шинэ үеийнхнийг агуу захирамжийг биелүүлэх үйлст гар бие оролцуулах нь хамгийн бэрхшээлтэй байгаа тухай бидэнд ярьсан юм.

Үүнээс улбаалаад бид шинэ үеийнхний оролцоог илүү нэмэгдүүлэхийг зорьж ажиллах болсон юм. Бид шинэ цаг үеийн залуусаа ойлгох, тэдний оролцоог нэмэгдүүлэхэд илүүтэй анхаарч ажиллахаас гадна суралцаж буй зүйлсээ ахмадуудад хуваалцан заахад нь тэднийг татан оролцуулах зорилго тавьсан юм. Бурхан Өөрийн Сүнсээ залуу хөгшин аль алиных нь дээр асган цутгахыг бид хүсэн тэмүүлж байна.

Бурхан энэ дэлхийн хүмүүст хэрэгтэй авъяас билэг, ур чадваруудыг шинэ залуу үеийнхэнд онцгойлон өгсөн гэдэгт Глобал Адванс байгууллага итгэдэг. Бид Бурханы агуу захирамжийг биелүүлэх, даяар чуулганыг хүчирхэгжүүлэх, нийгмийн талбар бүрт сайнмэдээг хүргэх дараачийн үеийг босгон байгуулахыг эрмэлздэг. Эдгээр зорилгуудаа бид үе дамжуулан хийхийг хүсч байна.

Глобал Адванс байгууллагын NextGen Engagement буюу ШинэҮе-Оролцоо хэмээх шинэ санаачилга төслийг бодохоор миний сэтгэл маш догдолж байна. Бид дараагийн үеийн удирдагчдад анхаарал тавьж ажиллах чин дуудлагатай. Туршлагатай удирдагчдыг шинэ үеийн удирдагчидтай ойр ажиллахыг мөн дэмжиж ажилладаг. Энэхүү сургалтын гарын авлага нь Глобал Адванс байгууллагын Шинэ Үеийн удирдагчдын оролцоог дэмжихэд чиглэсэн анхны арга хэрэгсэл болж байгаа юм. Энэхүү сургалт та бүхэнд ерөөл болно хэмээн найдаж байна.



АГУУ ЗАХИРАМЖИЙГ БИЕЛҮҮЛЭХ ШИНЭ ҮЕИЙН УДИРДАГЧДЫГ ӨСГӨХ НЬ

Бүгдээрээ хамтран ажиллацгаая. Бидний хамтын хүчээр ирээдүйн үеийнхэн Христийг таньж мэдэн, дэлхийд хүрч нөлөөлөх болно.

Захирамжид талархалтайгаар үйлчлэгч,

Жонатан Шөбли

Глобал Адванс байгууллагын ерөнхийлөгч

УДИРТГАЛ

“Харин та нар сонгогдсон угсаа, хаан тахилч, ариун үндэстэн, Бурханы эзэмшлийн ард түмэн юм. Ингэснээр харанхуйгаас та нарыг Өөрийн гайхамшигт гэрэл уруу дуудсан Түүний хүчирхэг үйлдлийг та нар тунхаглах юм.” 1Петр2:9

Үнэн, итгэл найдвар дэлхий ертөнцөд урьд хожид байгаагүй ихээр хэрэгтэй болсон мэт. Бидний гэр оронд амьдарч байгаа, коллеж их сургуульд сурч байгаа, ажлын газар, сүм чуулганд маань явж байгаа өнөөгийн залуучуудын үед сүнслэг харанхуй, сүнслэг асуудлууд урьд өмнөх үеүдийнхээс ч илүү их болсон гэмээр. Өнөө үе бол дийлэнх хүмүүс технологи болон социал медиа хэрэгслээр дамжуулан дэлхий нийттэй харилцах бололцоотой болсон үе билээ. Гэвч залуу үеийнхнийг удирдагчаар хөгжүүлэх төлөвлөгөөтэй бодлого стратеги тэдний явж буй сүм чуулган, боловсрол, бизнес орчинд дутагдаж байна. Тэд ирээдүйд нийгмийн олон талбарт Христийн элчин сайдууд, дагалдагч бэлтгэгчид болж нөлөө үзүүлж чадах хүмүүс билээ. Харин тэднийг тус үүрэгт нь бэлтгэж өгөх хүмүүс хэрэгтэй байна.

Хэдий энэ үүрэгт ажлууд сүрдэм санагдаж болох ч Христ Өөрийн Сүмдээ эргэн ирэхээс өмнө сайн мэдээ бүх дэлхийд тунхаглагдсан байх болно гэсэн амлалт бидэнд бий. Бурхан эцсийн ургацаа хураахаас өмнө бүх үндэстэн, хэлтэн, бүх хүмүүст сайн мэдээг сонсоод хариу үйлдэл үзүүлэх боломжийг олгоно гэсэн билээ.

Бурханы энэ дэлхийн төлөөх ажлыг нь үргэлжлүүлэх, Агуу захирамжийг биелүүлэх удирдагчдыг бэлтгэх нь Бурханы авралын төлөвлөгөөний нэг хэсэг юм. Шинэ үеийн удирдагчдыг урамшуулан, бойжуулан өсгөх нь сүм чуулган болон өмнөх үеийн сүнслэг удирдагчдын үүрэг гэдэгт Глобал Адванс байгууллага итгэдэг бөгөөд тийнхүү тэд улс үндэстэн, нийгэмдээ үйлчлэхээр хангалттай бэлтгэгдэж чадах юм.

Бурханы алдрыг тунхаглахын төлөө, сүнслэг харанхуйд орших дэлхийд сайн мэдээний гэрлийг түгээхийн тулд Бурханы сонгосон зэмсгүүд бол шинэ үеийн сүнслэг удирдагчид мөн гэдэгт Глобал Адванс итгэдэг.



АГУУ ЗАХИРАМЖИЙГ БИЕЛҮҮЛЭХ ШИНЭ ҮЕИЙН УДИРДАГЧДЫГ ӨСГӨХ НЬ

Бурханы алдрыг тунхаглахын төлөө, сүнслэг харанхуйд орших дэлхийд сайн мэдээний гэрлийг түгээхийн тулд Бурханы сонгосон зэмсгүүд бол шинэ үеийн сүнслэг удирдагчид мөн гэдэгт Глобал Адванс итгэдэг.

Шинэ Үеийн удирдагчдад нөлөө бүхий дөрвөн гол сэдвийн хүрээнд бид асуултуудыг боловсруулсан. Эхний хөндсөн сэдэв бол даяар чуулганд сүнслэг удирдагчид ховордсон талаарх асуудал байв. Хоёр дахь сэдвийн асуултуудаар залуу хүмүүс шинэлэг санаануудаа илэрхийлэх эрх чөлөөний түвшин, шинийг эрэлхийлэх орчин нөхцөл, бүтээлч байдлын талаар хөндсөн. Асуултуудаар хөндсөн гурав дахь сэдэв бол хойч үеийнхэн нийгэм, сүм чуулгандаа удирдагчийн үүргийг хүлээж авах шилжилтийг сүм чуулганууд анзаарч ач холбогдол өгч байна уу гэдгийг мэдэхийг зорьсон. Дөрөв дэх сэдэв бол сүм чуулганууд сайнмэдээг нийгэмдээ хэр зэрэг тодорхой ойлгомжтойгоор тунхаглан хүргэж байна вэ гэдгийг үнэлж дүгнэхийг хичээсэн. Мөн түүнчлэн залуу хүмүүсийн сайнмэдээ болон харилцааны ойлгомжтой байдлыг хувь хүнийхээ хувьд хэрхэн үнэлж дүгнэдгийг судлахыг хичээсэн.

Глобал Адвансын энэхүү судалгаагаар ажиглаж анзаарсан зүйлс дээр тулгуурлаж дэлхий даяарх туршлагатай удирдагчдад зориулсан сургалтын материал бэлдэх даалгаварыг надад хүлээлгэн өгсөн юм. Энэхүү удирдагчдыг хөгжүүлэх сургалтаар дамжуулан шинэ үеийн сүнслэг удирдагчдыг өсгөх, тэднийг улам хүчирхэгжүүлэх шаардлагатайг дэлхий дахинд фронтын шугамд үйлчилж байгаа удирдагчид болон нутгийн сүмийн удирдагч нарт сануулсан, урам зориг, арга хэрэгсэл болох болов уу гэж найднам.

Давид хаан Бурханы зорилго ирээдүйд хэрэгжихийн тулд сүнслэг шинэ удирдагчдийг босгох ёстойг ухаарсан байдаг. Давид хаан Бурханаас ирээдүй хойч үеийнхэндээ үзсэн сурсан зүйлсээ дамжуулахаас нааш энэ дэлхийгээс түүнийг бүү аваач гэж гуйсан байдаг. Сүнслэг удирдлагыг найдвартай итгэлтэй хүнд даалган

b

үлдээх хүсэл Давидад байсан. Мөн Давид хаан өөрийнхөө хувьд Бурханыг гүнзгий таньж дотно харилцдаг байсныг нь хойч үеийнхэн нь мөн эдлэж баяр хөөрийг амсаасай гэсэн хүсэл түүний дотор байсныг дараах дууллаас харж болно. “Бурхан, хөгширч бууралтах үед минь ч Намайг бүү орхиоч, Таны мутрыг би үе удамд, Таны хүчийг ирээдүйн бүх хүнд Тунхаглах хүртэл бүү орхиоч!” Дуулал71:18

“... Тэдгээрийг хүүхдүүдээс нь бид нуухгүй. Харин ирэх үеийнхэнд Эзэний магтаалыг, Түүний хүч чадал Үйлдсэн гайхамшигт ажлуудыг нь тунхаглан ярина.” Дуулал78:4

Төлөвшсөн удирдагчид эдгээр эшлэлийг уншиж тунгаавал энэхүү үүрэг хариуцлага нь дан ганц Давид болон түүний үеийнхэнд хамааралтай бус гэдэг нь тодорхой харагддаг. Энэ бол бүх үеүдийн удирдагчдад нэгэн адил үйлчлэх дуудлага билээ. Бид бүгд сүнсний удирдагчдын дараагийн үеийнхэндээ хөрөнгө оруулах үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бидний хийх ажил бол Эзэний хүч чадал, агуу үйлс болон магтагдвал зохих үйлсүүдийг тэдэнд хэлж ярих мөн Давидын ‘Миний Бурхан’ хэмээн дуудсан Тэрхүү Нэгэнийг хувьчлан дотноор таньж мэдэхийг ятган ухааруулах явдал юм.

Сүм чуулганууд, сүнсний удирдагчид Агуу Захирамжийг биелүүлэх учиртай шинэ үеийн удирдагчдыг хэрхэн бэлдэж зэхэж байна вэ? Глобал Адванс байгууллагатай адил туршлагатай үйлчлэлүүд фронтын шугамд үйлчилж буй удирдагчидтай хэрхэн нэг эгнээнд алхаж, тэднийг энэхүү үүрэг даалгаварыг амжилттай дамжуулахад нь хэрхэн туслаж байна вэ? Энэхүү сургалтын материалаар дамжуулан эдгээр асуултуудад хариу өгч чадна гэж найдаж байна. Мөн Ариун Сүнс эдгээр удирдлагын хөгжлийн зарчмуудыг ашиглан Шинэ Үеийн удирдагчдыг өсгөн гаргаж ирэх зөн харааг таныг зүрхэнд өгч, гарт тань зэвсэг болгон ашиглуулна гэж найдаж байна.

Удирдлагын талаар ярилцахдаа бид Шинэ Үе удирдлагын хөгжлийн моделийг жишиг болгохгүй, учир нь модел загварууд соёл, орчин бүрт тэр бүр шууд буулган ашиглахад тохиромжтой байдаггүй. Моделиуд цаг хугацааны явцад хуучирч мөн хоцрогдох боломжтой байдаг. Харин түүний оронд Шинэ Үе-ийн удирдагчдыг урамшуулан зоригжуулах, өсгөн бойжуулах, хүчирхэгжүүлэн батжуулахад шаардлагатай Библийн бодит зарчмуудыг санал болгохоор шийдсэн билээ.



АГУУ ЗАХИРАМЖИЙГ БИЕЛҮҮЛЭХ ШИНЭ ҮЕИЙН УДИРДАГЧДЫГ ӨСГӨХ НЬ

Эдгээр Библийн зарчмууд ямар ч нөхцөлд хэрэгжих боломжтой бөгөөд соёлын ялгааг гэтлэн давж чадах зарчмууд гэж бид итгэж байгаа юм. Энэхүү ном бид долоон зарчмыг сонгон авсан. Залхаах урт зүйлс бус харин Шинэ Үе-ийн удирдагчдыг үр дүнтэйгээр дагалдуулан бэлтгэхэд туслана гэж итгэж байгаа тодорхой цөөн зарчмууд дээр бид төвлөрсөн. Зарчим бүрийг тухайн зарчмын суурь илчлэл болсон Библийн хэсгүүдээр эхлэн танилцуулна. Библийн бүх хэсгүүдийг New International Version of the Holy Bible (Zondervan Publishing House, Grand Rapids Mich.2005) -аас эш татсан олно.

Ихэнх тохиолдолд бид Есүсийн жишээг ашиглах болно. Учир нь Есүс эдгээр зарчим бүрийг дагалдагчдаа сүнсээр өсгөж удирдахдаа ашигласан байдаг. Таны суралцах, тунгаан бодоход туслах зорилгоор Глобал Хэрэгцээ Судалгаанд оролцсон залуучуудын үзэл санаа, хэлсэн үгсээс эш татсан хэсгүүдийг нэмэлтээр оруулсан. Бүлэг бүрийн төгсгөлд эргэцүүлэн бодох асуултууд, богино залбирал, хүссэн үр дүндээ хүрэхийн тулд хийх алхмууд зэрэг хэсгүүдийг оруулж өглөө. ШинэҮе-ийн Оролцоог эхлүүлэх, хөдөлгөн стратегиа эхлүүлэхэд тань энэхүү гарын авлага тус нэмэр болно гэж найдаж байна.

Бурхан таныг ивээг.

Кейт Р. Вест, Магл

Глобал Хэрэгцээ- Судалгааны Хураангуй 2016

ШинэҮе Удирдлага Хөгжлийн Долоон Зарчмыг эхлэхийн өмнө та бүхэнтэй 2016 онд хийгдсэн Глобал Хэрэгцээ Судалгаанаас Глобал Адванс байгууллагын хувьд ажиглан тэмдэглэсэн зарим гол зүйлсээс хуваалцахыг хүсч байна.

ГЛОБАЛ ХАНДЛАГА

Глобал Хэрэгцээ онлайн судалгааг Глобал Адванс байгууллагын зүгээс 9 хэл рүү орчуулж вэбсайт дээр байруулсан. 5 сарын турш нээлттэй байх хугацаанд дараах газар зүйн бүсүүдийг төлөөлөх 24 орноос 438 хариу хандалтыг бид хүлээн авсан билээ. Судалгаанд оролцсон муж улсууд: Хойд ба Төв Америк, Өмнөд Америк, Карибын тэнгисийн улсууд, Зүүн Европ, Баруун Ази, Өмнөд Ази, Зүүн өмнөд Ази, Хойд, Баруун, Зүүн ба Өмнөд Африк болон Австрали.

Мөн түүнчлэн Хойд Америк, Эквадор, Панама, Чили, Өмнөд Судан, Камерун, Вьетнам, Хятад болон Непал зэрэг улсуудад Шинэ Үе үйл ажиллагаануудыг зохион байгуулахдаа Глобал Адванс байгууллагын зүгээс олон судалгаа хийсэн. Эдгээр үйл ажиллагааны үед Эквадор улсаас хамгийн идэвхтэй хариу үзүүлж байлаа.

Глобал Хэрэгцээ Судалгаанд оролцсон орнуудын оролцогчдыг тодруулбал АНУ-аас 91, Эквадор улсаас 75, Өмнөд Суданаас 43, Гайти улсаас 31 хүн тус тус оролцсон байна. Судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн оролцсон хувь эрэгтэйчүүдийнхээс 6 хувь илүү байсан. Нийт судалгаанд оролцогчдын тал хувь нь 18-25 насны залуучууд байсан бөгөөд, 24% нь 26-30 насны залуучууд эзэлж байв.

УДИРДЛАГЫН СОЁЛ

Дэлхий нийтийн сүм чуулганы удирдлагын соёлд үе хоорондын ялгаа зааг бий эсэхийг тодруулсан асуултад тийм гэж 48%, үгүй гэж 19% нь хариулсан.



АГУУ ЗАХИРАМЖИЙГ БИЕЛҮҮЛЭХ ШИНЭ ҮЕИЙН УДИРДАГЧДЫГ ӨСГӨХ НЬ

Үлдсэн 33% нь дундыг баримталсан хариу өгчээ.

Бид залуу насанд хүрэгчдээс тэдний удирдлагын талаарх ойлголтыг тэлэх зорилгоор хамгийн том бэрхшээлүүдийг нь асуусан юм. 31% буюу хамгийн том бэрхшээлтэй асуудал бол 'би хаана хамгийн том хувь нэмэр оруулахаа мэдэхийн тулд өөрийнхөө талаар хангалттай мэдэх' гэсэн хариулт байлаа. Энэхүү хариулт Румын болон Хятад оролцогчдын дунд хамгийн түгээмэл байв. Дараагийн хамгийн өндөр 28% хувиар давхцсан хариулт бол 'намайг дагалдуулах ментор буюу үлгэрлэгч олох' гэсэн байв. Энэхүү хариулт нь хойд Америк болон Вьетнам оролцогчдын дунд элбэг байв. Судалгаанд оролцогчдын 11% нь 'алдахаас айх' нь тэдний хувьд хамгийн том бэрхшээл байв. Тус хариултыг Хойд Америкчуудын дунд их байсан бол Ази болон Ойрх Дорнодын орнуудын хувьд маш бага байв.

Дараагийн үеийн удирдагчдыг удирдагч болоход тулгарч байгаа эдгээр бэрхшээлийг даван туулахад ямар нөөц бололцоо туслах бол гэсэн асуултад оролцогчдын 49% нь 'урьд үеийн удирдагчид бидний үеийг ойлгож, бидний хийдэг сонирхдог зүйлст оролцож туслаасай гэж хүсдэг' гэсэн хариултыг өгсөн байв. Хамгийн ихээр давхцсан хоёр дахь хариулт нь 'ямар боломжууд надад хамгийн сайн таарахыг ойлгоход минь туслах өөрийгөө үнэлэх багаж хэрэгслүүд' гэж оролцогчдын 41% нь хариулсан байна.

БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭ

'Бүтээлч санаагаа илэрхийлэх, аливаа зүйлсийг шинэ арга байдлаар хийх орчин эрх чөлөө надад байдаг' гэсэн өгүүлбэртэй санал нийлж буй эсэх асуултад 46% нь баттай санал нийлж байгаагаа илэрхийлсэн байна. Тус хариултын өндөр хувийг Англи ба Румын хэлээр ярьдаг оролцогчид эзэлсэн байна. Хамгийн бага хувиар хариулсан улсууд нь Орос оролцогчид байснаас 36% нь одоо байгаа нөхцөл нь тэдэнд бүтээлч байх эрх чөлөө боломж байхгүй гэж хариулсан байна. Испани хэлээр ярьдаг орны оролцогчид энэ тал дээр маш бага хувийн үнэлгээ өгсөн байна. Нийт оролцогчдын 19% нь дундыг баримталсан хариулт өгсөн. 'Ямар боломж бололцоо таныг өдөөж урам өгдөг вэ' гэсэн асуултад өгсөн хариултуудын 36% нь 'ямар нэг шинэ юмуу содон зүйл хийж бүтээх' гэсэн хариултыг сонгосон бөгөөд 29% нь ямар нэг эвдэрч хэмхэрсэн зүйлийг засч янзлах нь дээр гэж үзсэн байхад,

19% нь өмнө нь сайн ажиллаж байсан зүйлийг авч илүү сайжруулах нь дээр гэж үзжээ. 16% нь урьд өмнө нь болж байсан зүйлийг илүү үнэнчээр үргэлжлүүлэн хийхийг илүүд үзсэн байна.

Сонирхолтой нь байгууллагын ямар үүрэг роль таны оролцоог илүү урамшуулах вэ гэсэн асуултын хариуд 57% нь 'соёлыг бүтээх, өөрчлөхөд надтай хамтрах хүсэлтэй байгууллага' гэж хариулсан бөгөөд 43% нь 'оролцоог өсгөх олон хувилбартай байгууллага' гэсэн хариулт өгсөн байна.

ИРЭЭДҮЙН СҮМ ЧУУЛГАН

'Миний үед сүм чуулган өөр байх болно.' гэсэн өгүүлбэрийн хариуд оролцогчдын 61% нь маш ихээр болон ерөнхийдөө санал нийлж байна гэсэн бол зөвхөн 17% нь санал маш ихээр болон ерөнхийдөө зөрж байна гэсэн байна. Харин 22% нь дундыг баримталсан байна.

Оролцогчдоос сүм чуулган болон байгууллага нь Миллениалуудтай хэр холбогддог талаарх асуултын хариуд оролцогчдын 34% нь тэдэнд өөрийнхөө үеийнхэнд хүрч ажиллах санаа санаачилгыг гартаа авах үүрэг оноодог гэсэн бол 27% нь сүм чуулганууд шинэ үеийнхэнтэйгээ холбогдож харилцахдаа муу гэсэн хариу өгсөн байна. 21% нь удирдагчид нь Миллениалуудыг сонсдог, тэдний оролцоог дээшлүүлэхэд анхаардаг гэсэн хариу өгсөн байна.

Бид судалгаанд оролцогчдоосоо Шинэ Үеийнхний оролцоог дэмжихийн тулд сүм чуулган яг ямар байх ёстойг тодорхойлно уу гэсэн асуулт тавьсан. Нийт оролцогчдын хариулснаар бол сүм чуулган хамт олон хүмүүсийг чухалчилдаг мөн олон үндэстэн өөр байдлуудыг хүлээн зөвшөөрдөг, илүү нүдэнд үзэгдэхүйц, идэвхитэй харилцаатай, илүү сорьсон, хүчирхэгжүүлдэг байхаас гадна нийгмийн оролцоо идэвх илүү, нийгэмдээ сайн үйлс хийдэг байх гэж тус тус тодорхойлсон байна.

Сайн мэдээ

'Та сайн мэдээтэй ямар холбоо харилцаатай гэж өөрийгөө тодорхойлох вэ?' гэсэн асуултад оролцогчдын 56% нь сайн мэдээг сайтар ойлгож хүлээж авсан бөгөөд бусдад хангалттай тайлбарлаж чадна гэж хариулсан бол, 39% нь сайн мэдээг



АГУУ ЗАХИРАМЖИЙГ БИЕЛҮҮЛЭХ ШИНЭ ҮЕИЙН УДИРДАГЧДЫГ ӨСГӨХ НЬ

хангалттай ойлгосон ч бусдад тайлбарлахад хүндрэлтэй байдаг гэж хариулжээ.

Сайн мэдээний талаар сүм чуулганы удирдагчдад өгөх зөвлөгөө юу байна гэсэн асуултад оролцогчдын 40% нь 'бидэнд замчилж харуул. Сайн мэдээ төвтэйгээр энэ нийгэмд хэрхэн амьдрахыг бидэнд үлгэрлэн харуул.' хэмээн хариулсан бол 24% нь 'хэний ч хүрч чадахгүй байгаа хүмүүст хүрэх зөвшөөрлийг бидэнд өгч үүд хаалгыг нээнэ үү.' гэсэн хариулт өгсөн байна. 19% нь 'Гол асуудал руугаа ор. Сайн мэдээг улам бүр тунхагла, бусдад заа.' гэсэн бол үлдсэн 17% нь 'бидэнд дуу хоолойгоо илэрхийлэх боломж олго. Миллениал үеийнхэнд илүү үр дүнтэй хүрэх арга замуудыг ашиглан сайн мэдээг тараасаар байя.' гэжээ.

'Манай сүм чуулганд сайн мэдээ тодорхой ойлгомжтойгоор тараагддаг.' гэсэн өгүүлбэрт 53% нь санал маш ихээр нийлж байгаагаа илэрхийлсэн бол 23% нь үүнтэй санал ихээр зөрж байгаагаа илэрхийлсэн байна. Тус өгүүлбэрт 25% нь дундыг баримталсан хариу үзүүлжээ. Тус байдалтай санал нийлээгүй оролцогчдын дотор Вьетнам болон Ойрхи Дорнод болон Хойд Африкийн орнуудын оролцогчид нэлээд хувийг эзэлж байлаа.

ДҮГНЭЛТ

Шинэ Үеийн Хэрэгцээ юу байгааг тодорхойлох зорилготой тус судалгааг 2016 онд Миллениал үеийнхэний дунд Глобал Адванс байгууллагын зүгээс явуулсан бөгөөд дараах зүйлсийг судалгаанаас олж мэдлээ:

- Дэлхийн сүм чуулгануудын дунд удирдагчийн соёлд удирдагчийн хоосон орон зай үнэндээ байхгүй юм байна.
- Шинэ үеийнхний удирдагчид жинхэнэ үнэн, бүгдийг хамруулсан, харилцан хамааралтай, хүчирхэгжүүлж, үлгэрлэн дагуулдаг удирдагчдыг хамгийн ихээр биширдэг болохыг олж мэдлээ.
- Шинэ Үеийнхэнд бүтээлч санаагаа илэрхийлэх, өнөөгийн орчин нөхцөлд аливаа зүйлсийг шинэ арга барилаар хийх эрх чөлөө хангалттай байдаггүй.

IV Глобал Хэрэгцээ- Судалгааны Хураангуй 2016

- Шинэ үеийн удирдагчид өөрсдийгөө хаана байх ёстойгоо тодорхойлохын тулд өөрсдийгөө хангалттай мэдэх нь удирдагчийн хувьд тулгардаг хамгийн том сорил, бэрхшээл болдог гэж үзэж байна.
- Шинэ үеийн удирдагчдад тэднийг ойлгох, сүм чуулганы үйл ажиллагаанд илүү оролцоход нь урамшуулж зоригжуулагчид хэрэгтэй тэд өөрсдийгөө үнэлж дүгнэх боломжуудаар хангуулахыг хүсч байна.
- Шинэ үеийн удирдагчид туршлагатай мэргэжилтнүүдтэй менторын харилцаа үүсгэхийг хүсдэг. Бүтээлч байдлынхаа цангааг үе тэнгийнхэнтэйгээ хуваалцан хамтарч ажиллахыг хүсдэг.
- Шинэ Үеийнхэн дуу хоолойгоо сонсгож, өөрсдийн үеийхэнд зориулсан үйлчлэлд өөрсдийгөө хуваарилуулахыг хүсдэг.
- Соёлыг бүтээх, өөрчлөх байгууллагуудтай шинэ үеийн удирдагчид хамтрахыг хүсдэг бөгөөд олон улсын хүрээнд мөн харилцаа холбоотой байхыг хүсдэг.
- Ирээдүйд сүм чуулган нийгэм болон олон үндэстэнд анхаарлаа хандуулдаг байх ёстой бөгөөд илүү сорилтод дуудсан, хүчирхэгжүүлсэн, илүү нүдэнд харагдахуйц, илүү харилцаа холбоотой байх ёстой гэж үздэг.
- Шинэ үеийн удирдагчид сайн мэдээг сайтар ойлгосон бөгөөд бусадтай хуваалцахдаа цааргалдаггүй.
- Манай судалгаанд оролцогчдын сүм чуулганд сайн мэдээ тодорхой бөгөөд ойлгомжтой байдлаар тунхаглагддаг.
- Шинэ Үеийн удирдагчид Естер Санаачлага ба Глобал Адванс байгууллагын Marketplace Mission үйл ажиллагаануудыг илүүтэй сонирхдог.

СУДАЛГААНЫ ДҮНД

2016 онд залуучуудын дунд хийгдсэн тус судалгаанаас суралцсан зүйлсийн хариу арга хэмжээ болгож бид дараах долоон бүлэг бүхий гарын авлагыг боловсруулан гаргалаа. Бид шинэ үеийн удирдагчдын гол хэрэгцээ, тэдний зовнилуудыг шууд онцлож өмнөх үеийн туршлагатай удирдагчдад тэднийг илүү ойлгуулж, Агуу Захирамжийн Удирдагчдын шинэ үеийг өсгөн босгохын тулд та бүхний оролцоог чухалд авч үзэж байна. Тус гарын авлагад буй зарчим бүрийг залбирал дотор хүлээн авч, хуваалцсан Бичвэрийн үгс болон үзэл санааг тунгаан бодож, Шинэ Үеийн сүнслэг удирдагчдыг төрүүлэн гаргахад чин сэтгэлээсээ хичээл зүтгэл гарган оролцохын тулд зааварчилгаа, ятгалгыг өгөхийг Ариун Сүнснээс гуйн залбираарай.

Глобал Адванс таны төлөө болон Бурханы таны гарт итгэн даалгасан залуучуудын төлөө залбирч буйг санаарай. Одоо бүгдээрээ Шинэ Үеийн Удирдагчдын хөгжлийн хөрсийг бэлтгэхээр ханцуй шамлан орцгооё. Ирээдүйн ургацыг бэлтгэе. Мөнхийн үр дүнг Бурханд даатгая.

NEXTGEN RISING V

ЗАРЧИМ 1: ОРОЛЦООГ ДЭМЖИГЧ УДИРДАГЧ

“Бурхан айлдахдаа ‘Эцсийн өдрүүдэд би Сүнсээ Бүх махбод дээр цутгана. Хөвгүүд, охид чинь эш үзүүлж, Залуус чинь үзэгдэл үзэн, Хөгшчүүл чинь зүүд зүүдлэх болно. Эр, эм гэлтгүй боолуудынхаа дээр Тэр өдрүүдэд Би Сүнсээ цутгана. Тэд эш үзүүлэх болно.”
Үйлс2:16-18

“Харин Ариун Сүнс та нар дээр ирэхэд та нар хүчийг олж, тэгээд Иерусалим, бүх Иудей, Самари тэр байтугай дэлхийн хязгаар хүртэл Миний гэрч болно гэв.” Үйлс1:8

Үйлс номд Лукын дүрсэлсэн зүйлс Есүсийг нас барахын яг өмнөхөн мөн Түүнийг тэнгэрт хөөрөхийн өмнө биелэлээ олсон байдаг. Есүс дагалдагч нараа өнчин хүүхдүүд адил орхихгүй харин өөр нэгэн тайтгаруулагч буюу Ариун Сүнсийг бэлэг болгон илгээж, дэлхий дахинд Түүнийг гэрчлэх хүч дэм болгон илгээнэ гэж амласан.

Есүсийн дагалдагч нар Есүсийн тушаалд дуулгавартай байж, хамтдаа цуглан ариун сүнсийг хүлээх зуураа залбиралд өөрсдийгөө зориулсаар байсан юм. Есүс амласан ёсоороо Пентекостын өдөр Ариун Сүнсээр дагалдагч нартаа баптисм хүртээж, хожим нь Есүс Христийн Сүм хэмээн нэрлэгдэх дагалдагч нарт хүч ба эрх мэдлийг цутган өгсөн билээ.

Ариун Сүнсээр хүчирхэгжсэн элчүүдээрээ дамжуулан дэлхийн төгсгөл хүртэл сайн мэдээг хүргэх нь Есүсийн төлөвлөгөө байсан нь тодорхой. Сайн мэдээ тунхаглагдаж, сүм чуулганууд үндэстэн, хот, тосгон бүрт байгуулагдах нь Есүсийн зорилго төлөвлөгөө байсан. Энэхүү агуу зорилго хэрэгжихийн тулд сүнслэг удирдагчид дэлхий даяар босгон байгуулагдаж бэлтгэгдэх ёстой. Христ сүнслэг удирдагчдыг зөвхөн нэг үндэстний хүмүүс байхаар ялгаж онцолсонгүй, эсвэл зөвхөн



АГУУ ЗАХИРАМЖИЙГ БИЕЛҮҮЛЭХ ШИНЭ ҮЕИЙН УДИРДАГЧДЫГ ӨСГӨХ НЬ

цөөхөн хэдэн хүмүүст Ариун Сүнсээ цутгасангүй. Харин эш үзүүлэгч Иоелын тунхаглаж, элч Паулын хожмоо баталснаар үндэстнүүдийг ерөөж, аврахын тулд Түүний сүмүүд дээр Ариун Сүнсийг Есүс чөлөөтэйгээр цутгасан билээ.

“Эцсийн өдрүүдэд би Сүнсээ БҮХ МАХБОД дээр цутгана” гэсэн билээ.

Пентекостын тэрхүү өдөр тэднийг сүмд цуглан байх үед тэнгэрээс хүчтэй салхины дуу чимээ гарч тэдний цугласан өрөөг дүүргэдэг. Хэлүүд салгагдах мэт болж ‘хэл бүхэн’ чимээгүй болж тэд амлагдсан Ариун Сүнсний баптисмыг хүртсэн юм. Лукын бичиж үлдээснээр “тэд бүгд Ариун Сүнсээр дүүрч Ариун Сүнсний тэдэнд өгсөн хэлүүдээр ярьж эхэлсэн юм.” гэсэн байдаг. Хүн бүр, тэд бүгд гэсэн үгүүдээр Ариун Сүнс цутгагдаагүй хэн ч үлдээгүй гэдгийг илтгэж байгаа юм. Элч Паул Хуучин гэрээний эш үзүүлэгч Иоелын хэлсэн эш үзүүлэгийг эш татахдаа Түүний тослогдсон сүмд Ариун Сүнс “бүх хүмүүст” цутгагдах болно гэсэн билээ.

Лукын өгүүлснээр Ариун Сүнс итгэгчдийн дунд цутгагдан бууж ирснийг харсан, сонссон хүмүүсийн гэрчилснээр дор хаяж 15 хэлээр тэд ярьж байсан гэдэг. Петрийг сонсч зогссон үндэстэн хэлтнүүдийг төлөөлсөн болов уу гэж үздэг бөгөөд тэр цагаас хойш хүмүүс жил бүр Пентекостын баяраар Иерусалимд дэлхийн бүх хүмүүс цугладаг болсон түүхтэй. Өнөө цагт Түүний хүмүүсийн дотор оршигч Ариун Сүнсний хүч ба ерөөлийг илэрхийлсэн ямар гайхалтай цаг ба газарт сүм чуулган анх эхэлсэн юм бэ.

Олон үндэстнүүдэд зарим бүлэг хүмүүст нийгмийн эрх, эх сурвалжийг ашиглах боломж хязгаартай бөгөөд тэднийг ялгаварлан гадуурхдаг. Бурханы хаанчлалд тийм ялгаварлал байхгүй билээ. Элч Паул бага Азийн Ефес чуулганы итгэгчдэд хандан бичихдээ “Тийм бол та нар цаашид гадныхан болон ирмэл хүн бус, харин ариун хүмүүсийн адил нутгийн иргэд бөгөөд Бурханы гэр бүлийнх юм.” Ефес2:19 хэмээн бататган хэлсэн байдаг.


Колоссай 3:11-т Паул Колоссайн чуулганыханд хандаж "Энд Грек ба Иудей, хозлуулсан ба хозлуулаагүй, хэл харьтнууд, скутууд, боол ба чөлөөт гэж үгүй. Харин Христ бол бүгд бөгөөд бүгдийн дотор байна." гэжээ.

Танай сүм чуулган хүмүүсийг ялгаварлан гадуурхдаг юм биш биз? Өөрийн үндэс угсаа, гарлаасаа болж танай нийгэмд гадуурхагддаг хүмүүс байна уу? Сүнслэг удирдагч хүнийхээ үүднээс та Бурханы хаанчлалын үнэ цэнээр амьдарч, Бурханы үндэстнүүдийн төлөөх зүрх сэтгэлийг тээн амьдарч байгаа эсэхээ өөрөөсөө асуугаарай.

Бурхан таныг тав тухын бүсээсээ гарч өөр бусад чуулган болон танай нийгэмд өөр гэж үзэгддэг бүлэг хүмүүстэй харилцаа тогтоо хэмээн дуудаж байж болох юм. Танаас болон танай чуулганаас гарал үүсэл, соёлын хувьд ялгаатай Шинэ Үеийн удирдагчид болох боломжтой залуу үеийг олж таних, тэдний оролцоог дэмжиж, өсгөн бойжуулах үйлст Бурхан таныг дуудаж байж болох юм. Ариун Сүнс таныг нийгмийн гүүр баригч болгон хүчирхэгжүүлж, Христийн дотор нэг биеийн эрхтэн болох 'бүх хүмүүс'-ийг цуглуулахад ашиглах болтугай гэж бид залбирдаг.

ХӨВГҮҮД БА ОХИД

'Эцсийн тэрхүү өдрүүдэд хөвгүүд ба охид чинь эш үзүүлэх болно гэж Бурхан айлдаж байна.'




**Миний хамрагддаг
сүм шинэ бөгөөд
бүтээлч
хандлагатай. Бид
өмнөх үеийнхэнтэй
нэгдэн нийлж л
байгаа цагт бүтээлч
байдалд их анхаарна.**

**(Эрэгтэй, Нас 18-25,
РУМЕЙН УЛС)**



АГУУ ЗАХИРАМЖИЙГ БИЕЛҮҮЛЭХ ШИНЭ ҮЕИЙН УДИРДАГЧДЫГ ӨСГӨХ НЬ



***Би эргэн тойрныхондоо
насаар хамгийн бага нь.
Миний бодол хэнд ч
сонин биш болохоор би
хуваалцдаггүй.***

Хуучин ба Шинэ Гэрээнд залуу хүмүүст ач холбогдол өгсөн, нийгмийн чухал байр сууринд томилсон түүх бараг байдаггүй. Хүмүүс хүүхдүүдээ Есүс дээр авчран гар тавиулан залбируулахыг хүсэх үед дагалдагч нар хүртэл сандралдаж байсан түүхтэй. Тэр ч байтугай дагалдагч нар тэдгээр хүмүүсийг зэмлэж, Есүст хүрч очиход нь саад болж байсан ч тохиолдол бий. Дагалдагч нар Есүст тэднээс илүү анхаарах чухал ажлууд бий гэж бодсон байх. Есүс хариуд нь “Харин Есүс – Хүүхдүүдэд зөвшөөр. Тэднийг Над дээр ирэхийг нь бүү хоригло. Учир нь тэнгэрийн хаанчлал нь эдний адил хүмүүсийнх юм” Матай19:14 гэсэн.

Эндээс бид хаанчлалын үнэ цэнийг мэдэж авч болно. Нийгмийн хэм хэмжээгээр хамгийн дорд үзэгдэж байгаа хүмүүс Тэнгэрийн хаанчлалд хамгийн агуу нь болж харагдах боломжтой гэсэн үг. Элч Паул итгэлийн хөвгүүдийг өсгөн төлөвшүүлэх төлөвлөгөөтэй байсан. Тимоттой мэндчилсэн Паулын захидалд тэдний харилцааны шинж төрх, чанарыг харуулдаг. “Итгэл доторх миний жинхэнэ хүүхэд Тимотод, Эцэг Бурхан ба бидний Эзэн Христ Есүсээс нигүүлсэл, өршөөл, амар амгалан нь байг.” 1Тимот1:2. Паул Титийн талаар ч мөн адил сэтгэгдэлтэй байсныг Тит 1:4-т бичснээр буюу “Хамтын итгэлийн маань жинхэнэ хүүхэд болох Титэд Бурхан Эцэг ба бидний Аврагч Христ Есүсээс нигүүлсэл амар амгалан нь байх болтугай” -гэснээс харж болно.

4

ЗАРЧИМ 1: ОРОЛЦООГ ДЭМЖИГЧ УДИРДАГЧ

Үйлс 21-р бүлэгт Лук Иерусалимийн сүмийн анх сонгогдсон долоон ахлагчдын нэг сайн мэдээ тараагч Филиппийн талаар “тэр эш үзүүлдэг дөрвөн онгон охинто байв” гэж тэмдэглэсэн байдаг. Бурхан тэдэнд Кайсар хотод эш үзүүлэх үйлчлэлийг даатгасан бөгөөд тэд эцгийнхээ хамт үйлчилж байсан аж.

Танай сүм чуулган эсвэл ажлын газарт буй хөвгүүд болон охидуудын дунд ажиллаж буй Ариун Сүнстэй та хамтарч ажиллахын тулд хэр санаачилгатай төлөвлөгөөтэй хандаж байна вэ? Тэдгээр охид хөвгүүдийн удирдагчийн чадамж бололцоо, хаанчлалд үзүүлэх нөлөөлөлд та хэр үнэ цэнэ өгдөг вэ? Тэдний үзэл санаа танд хэр чухал вэ? эсвэл та үл тоодог уу? Хэрэв Бурхан тэдний үеийнхэнд эш үзүүлэлийн дуу хоолойг өгч байгаа бол яах вэ? Тэдний дуу хоолойг сонсгохын тулд, тэдний нөлөөг өргөтгөхийн тулд та хэрхэн туслаж болох вэ? Бурхан танд шинэ үеийн удирдагч болох чадамжтай залуусын сүнслэг ээж аав болох ачаа үүргийг өгөөсэй гэж бид найдан залбаирч байна.

ЗАЛУУС БА ХӨГШЧҮҮЛ

“Залуус үзэгдэл үзнэ. Хөгшчүүл зүүд зүүдлэнэ.”

Даяарчлалын нийгэмд залуусыг үргэлж л хөгшчүүлтэй харьцуулдаг. Зарим улс оронд ахмад үеийг дээдлэн хүндлэдэг бол зарим улсад тэднийг тэгж их хүндэлдэггүй нь ч бий. Хүмүүс хөгшрөх явцдаа нийгмийн шилжилтийг мэдэрч байдаг. Одоо цагт нөлөө бүхий түвшинд байгаа хүмүүс тэдний үзэл бодол, амьдралын туршлага, бодит ухааныг нь тэр бүр хайхрахаа больсон. Ахмад үеийнхэнд нийгэмдээ өгөх зүйл бага байдаг гэсэн буруу ойлголтод тэд итгэх болсон бөгөөд тэдний ухаан, авъяас бэлгээс суралцах нь улам бүр л багасч байна.

Удирдагчын бололцоо боломжийн тухайд залуу хүмүүсийг тэр бүр тоодоггүй. Залуучуудын бүтээлч байдал, шинэ санаа нь тоож авч үздэггүй. Ахмад үеийнхэн нь тэднийг дорд харж, удирдлагын соёлоос хасчихдаг талтай. Төлөвшсөн гишүүдтэй сүмийг удирдаж байсан залуу пастор Тимотыг сүмийнхэн нь тийм ч их тоодоггүй байсан тухай итгэлийн хүүдээ өгсөн Паулын заавраас харж болно “Хэн ч чамайг залуу гэж дорд бүү үзэг. Харин чи итгэгчдэд үг, зан байдал, хайр, итгэл хийгээд цэвэр ариунаараа үлгэр дуурайл бол.” 2Тимот4:12

Бидний Аврагч Христийн бие дотор бүх үеийнхнийг чухал гэж үнэлдэг. Тийм ч учраас Бурхан Ариун Сүнснийг хөгшин залуу гэлтгүй бүгдэд адил цутгасан билээ. Төлөвшсөн сүнслэг удирдагч нар Бурханы Сүнсээр Христийн бие доторх залуу хөгшин бүх хүмүүст илчилсэн зүйлст сонор соргог байх хэрэгтэй.

5

NEXTGEN RISING



АГУУ ЗАХИРАМЖИЙГ БИЕЛҮҮЛЭХ ШИНЭ ҮЕИЙН УДИРДАГЧДЫГ ӨСГӨХ НЬ

Өөрийн чуулганы төлөө Бурхан тэдэнд алсын хараа ба мөрөөдлийг өгдөг. Тэдний үзэл харааг үнэлж, зохих хүндэтгэлийг тэдэнд үзүүлэх хэрэгтэй. Бурхан эш үзүүллэгээр дамжуулан тэдэнд өгсөн үнэн ба ойлголтуудад итгэмжтэй сайн нярав бай. Учир нь та сүнслэг удирдагчийнхаа хувьд Бурханы өмнө хариуцлага хүлээх болно.

ЭРЧҮҮД БА ЭМЭТГЭЙЧҮҮД

"Эцсийн өдрүүдэд би Сүнсээ Бүх махбод дээр цутгана. Хөвгүүд, охид чинь эш үзүүлж, Залуус чинь үзэгдэл үзэн, Хөгшчүүл чинь зүүд зүүдлэх болно. Эр, эм гэлтгүй боолуудынхаа дээр Тэр өдрүүдэд Би Сүнсээ цутгана. Тэд эш үзүүлэх болно." Үйлс2:16-18

Есүс ирэхдээ өнөө цагийн нийгмийн соёлоос эрс тэс өөр зүйлсийг эрхэмлэн үнэлдэг Бурханы хаанчлалыг танилцуулсан. Есүс гинжийг тасалж, хоригдсон хүмүүсийг чөлөөлнө хэмээн тунхагласан. Есүсийн сургаалийг сонссон эмэгтэйчүүдийн хувьд тэрхүү мэдээ нь үнэхээр таатай бөгөөд эрх чөлөөг амлаж буй мэт сонсогдсон биз ээ. Тэрээр эмэгтэйчүүдэд нигүүлсэнгүй хандаж, тэдэнтэй хүндэтгэлтэй харьцаж байсан талаар Бичвэрт тодорхой тэмдэглэгдэн үлдсэн байдаг.

Лукын сайн мэдээний номоос үзвэл Есүс Бурханы хаанчлалын тухай сайн мэдээг тунхаглан явах зуур хэд хэдэн эмэгтэйчүүд Түүний их ажлын аянд нэгдсэн байдаг ба Лук 8:3-т "Херодын нярав болох Кузагийн эхнэр Ионна мөн Сузанна болон өөр олон хүн байж, өөрсдийнхөө өмч хөрөнгөөр тус нэмэр болж байлаа." хэмээн тэмдэглэгдсэн байдгаас харж болно. Энд дурдагдсан эмэгтэйчүүд Есүс болон дагалдагч нарт шаардлагатай байсан санхүүг хариуцаж, тэдний сайн мэдээ тараах, өвчтэй хүмүүсийг эдгээх үйлст хувьд нэмрээ оруулсан ажээ.

Есүс мөн Лазарын эгч Марийг Түүний хөлд суун сургаалийг нь сонс хэмээн дуудсан байдаг. Харин Марийн эгч Мартагийн бодлоор Марь 'илүү тохиромжтой' ажилд анхаарч, олны нүднээс далд ажлыг хийх нь дээр байж. Хэдийгээр тэдний хийхээр сонгосон ажлууд соёлын хувьд зөрчилтэй байсан ч Есүс Мартагаас илүүтэй Марийг сайшаасан. Энэ бол тухайн үед эмэгтэйчүүд нийгмийн үйл ажиллагаанд оролцдоггүй байсныг харуулаад зогсохгүй хаанчлалын хувьд харин ч тэдний оролцоог дэмжиж, тэдэнд үнэ цэнэ өгдөгийг харуулсан Есүсийн олон жишээний нэг байв. Элч Паул Ариун Сүнсээр онгод орон тунхаглаж байхдаа "Христэд баптисм хүртсэн та нар бүгдээрээ Христийг өмссөн юм.

Иудей ч, грек ч гэж байхгүй, боол ч, чөлөөт хүн ч гэж байхгүй, эр ч, эм ч гэж байхгүй. Учир нь та нар бүгд Христ Есүс дотор нэг болой.” Галат 3:27-28 гэсэн. Ефес номонд Паул тус хотын итгэгч нарыг Христийн дотор бие биедээ хүндэтгэлтэй хандахыг захисан байдаг. Тухайн цаг үеийн соёл нийгэмд энэхүү сургаалийг хэрэгжүүлэх нь тийм ч амар бус, газар авахааргүй байв. Тийм хэдий ч Паул Сүнсний удирдамж дор Бурхан Өөрийн чуулганыг ямар байгаасай гэж хүссэнийг, Бурханы үнэнүүдийг бичиж үлдээжээ. Тэд Бурханы Үгийг сонсч, дуулгавартай дагах ёстой байсан билээ. Хэдий тэдний соёл, ёс заншил, хувийн хүсэл сонирхолтой зөрчилдөх байсан ч гэлээ тэд дагах л ёстой байв.

Паул сайнмэдээний төлөө хамтарч, итгэлийн төлөө түүний хажууд зоригтой зогссон хэд хэдэн эмэгтэйчүүд ба итгэгчдийг Бичвэрт дурдсан байдаг. Паулын дотны анд Прискала болон түүний нөхөр Акул нар бол сүм эхлэн таригчид байсан төдийгүй Аполлосын адил өндөр чадамжтай сүнслэг дагалдуулагч менторууд байсныг дурдсан байдаг. Лидия гэгч эмэгтэй нь Бага Азийн гол нөлөө бүхий Филиппой хотод маш амжилттай бизнес эрхэлдэг хүн байжээ. Тэр бизнесийнхээ ачаар бусдын амьдралд нөлөөлөх боломжтой байсан юм. Бурхан Лидиягийн удирдлага, санхүүгийн нөөц бололцоо болон зочломтой зан чанаруудыг нь Филиппой хотын чуулганыг тарихад ашигласан.

Глобал Адванс дэлхийн олон урсгалын сүмүүдэд үйлчилдэг. Шинэ Гэрээний зарим эшлэлүүдээс харвал нутгийн сүмд эмэгтэйчүүдийг сургаал заах, номлох, удирдах албан тушаалд томилохыг хориглодог сүм чуулганууд байсныг харж болно. Зарим хүмүүс Паулын Коринт сүмийнхэнд өгсөн зааврыг тухайн цаг үед өгч байсан удирдамж болохоос бүх цаг үеийн турш бүх сүм чуулганд зөвлөсөн удирдамж гэж үздэггүй. Ингэж үздэг хүмүүс эмэгтэйчүүдийг пастор, сүмийн удирдах зөвлөлийн гишүүд, сүм таригчид болон олон урсгалт удирдагчидын нэгэн адил тэдний заах багшлах, удирдах бэлэг авъяасуудыг хөхиүлэн дэмждэг.

Танай сүм чуулган сүнслэг удирдлагын талаар ямар ч теологи баримталдаг байсан хамаагүй, удирдлагын орон зайд эмэгтэйчүүд байх ёстой бөгөөд сүмийн үйлчлэлүүдийн удирдлага, нийгмийн санаачилгатай ажлууд дээр бодлоготойгоор оролцуулан, тэднийг дэмжиж хүчирхэгжүүлэх нь зүйтэй. Ариун Сүнс эмэгтэйчүүдийн дээр ч асгагдсан бөгөөд чуулган ба нийгмийн төлөө хэнд ямар бэлэг авъяас олгох нь Бурханы сонголт билээ.

NEXTGEN RISING

7



АГУУ ЗАХИРАМЖИЙГ БИЕЛҮҮЛЭХ ШИНЭ ҮЕИЙН УДИРДАГЧДЫГ ӨСГӨХ НЬ

Танай чуулган эсвэл бизнес Христийн бие доторх эмэгтэйчүүдийг хаанчлалын зарчмын дагуу үнэ цэнэтэй гэж хардаг уу эсвэл нийгмийн тогтсон соёлын хэм хэмжүүрээр тэдэнд ханддаг уу? Сайн мэдээний ажилд эмэгтэйчүүдийг адил тэгш дэмжигчээр байлгах нь Бурханы зорилго бөгөөд тэднийг Бурханы өгсөн сүнслэг бэлэг авъяас болон талантуудаа зөв зохистой хэрэглэхэд нь зоригжуулан, тэдэнд хүндэтгэлтэй хандах ёстой юм. Та эмэгтэйчүүдийг сүнслэг талбарт удирдагчийн үүрэгт байхыг дэмждэг үү? Та бүхэн эмэгтэйчүүдийг удирдлагын талбарт хөгжиж дэвжих боломжоор хангадаг уу? Эмэгтэйчүүдийг чуулган, бизнес болон нийгэмд хүчирхэг болж ирэхэд танд төрдөг хамгийн том айдас юу вэ? Сүнслэг удирдагч байна гэдэг нь бусдыг оролцуулах явдал юм. Христ үүнийг дэлхийд ирээд хийсэн үйлчлэлээрээ үлгэрлэн харуулсан билээ. Ариун Сүнс Христийн бие доторх бүх хүмүүсийг хүчирхэгжүүлдэг. Христийн бие доторх бүх хүмүүс гэдэгт бүх үндэстний хүмүүс, тэдний охид хөвгүүд, хөгшид ба залуус, эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүд бүгд багтана. Хүмүүс бид удирдлагад зөвхөн цөөн хэдэн хүнийг сонгож үүнд хил хязгаар тогтоох гэсэн хандлагатай байдаг. Бурхан танд удирдлагын талаар өөрийн зүрх сэтгэлийг илчлэн ойлгуулах болтугай. Мөн таны нөлөөллийн хүрээнд Шинэ Үеийн удирдагч болох бололцоотой хүмүүсийг эрэлхийлэх явцыг тань Бурхан өргөтгөн тэлэх болтугай.

ЭРГЭЦҮҮЛЭМЖ

1. Сүүлийн гурван жил хөгжиж сайжирч ирсэн удирдагчдын талаар бодоод үзээрэй. Тус бүлэг хэр олон янзын хүмүүсээс бүрдэж байна? Шинэ удирдагчдыг оруулах орон зай боломж хаана байна вэ?
2. Энэхүү бүлэгт бидний үзснээр Есүс ба Паулын сургаалуудаас татсан жишээн дээр эмэгтэйчүүдийг удирдагч гэсэн өнцгөөс үнэлж харж байсантай танай нийгэм соёлын үнэ цэнэ хэр нийцэж байна вэ?
3. Танай байгууллагад удирдагчийн нөөц бололцоо нь илрээгүй байгаа гэж үзэж байгаа залуу хүмүүс байна уу? Та тэдний нөөц чадамжийг хэрхэн хөгжүүлж болох вэ?

ЗАЛБИРАЛ

Эзэн минь, Таны Хүү энэ дэлхийд ирээд бусдын оролцоог үнэлдэг удирдагч байсны адил миний зүрх сэтгэл ч мөн тийм удирдагч байхыг хүсч байна. Есүс Христ сүнслэг амьдралынхаа турш залуу хөгшин, эрэгтэй эмэгтэй, хөвгүүд охидууд ялгалгүй хүндэлж харилцдаг байсны адил би ч бас бусдыг адил нигүүлсэлээр хүлээн авч чадахад минь туслаач. Сүнслэг удирдлагын талбар дахь эмэгтэйчүүд, ахмад үеийхэн, болон залуусын талаарх хаанчлалын үнэ цэнийг барин амьдрахад минь туслаач. Нийгэм соёлын хэм хэмжээгээ мөн эргэн тойрны хүмүүсийн дарамт шахалтад орж тэднийг ялган харьцахгүй байхад минь туслаач. Таны таалсан хүмүүс хэдий надаас өөр ч гэлээ тэднийг энэрэн хайрлах, бусдад хөрөнгө оруулдаг Тантай адил удирдагч байхад минь туслаач. Энэ бүхнийг бүхний удирдагч Есүс Христийн нэр дээр залбиран гуйж байна.

Амэн.

ШААРДЛАГАТАЙ АРГА ХЭМЖЭЭ	ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

Танай байгууллагад удирдагч болон өсөх чадамжтай хүмүүсийг ямар арга замаар илүү оролцоотой болгож болох талаар хэдэн хором бодож үзнэ үү. Удирдлагын багтаа өөр хоорондоо ялгаатай хүмүүсийг илүү оролцуулахад тань шаардагдах зүйлсийг төлөвлөнө үү.



АГУУ ЗАХИРАМЖИЙГ БИЕЛҮҮЛЭХ ШИНЭ ҮЕИЙН УДИРДАГЧДЫГ ӨСГӨХ НЬ

ЗАРЧИМ 2: ЗОРИЛГОТОЙ УДИРДАГЧ

“Есүс тэдэнд- Намайг дага, Би та нарыг хүмүүсийн загасчид болгоно гэв.” Матай 4:19

“Есүс уул өөд гарч, хүссэн хүмүүсээ дуудахад тэд Түүн дээр иржээ. Есүс арван хоёрыг томилон элч хэмээсэн нь тэднийг Өөртэйгөө хамт байлгаж, тунхаглуулахаар илгээх, чөтгөрүүдийг зайлуулах эрх мэдэлтэй байлгахын тулд байлаа.” Марк 3:13-15

Есүс зорилготой удирдагч байсан. Түүний хийсэн бүх зүйлс тодорхой зорилготой байсан. Тэр дагалдагч нараа санамсаргүй тохиолдлоор сонгоогүй. Есүс багтаа яг хэнийг авахаа мэдэж байсан бөгөөд дэлхийг өөрчлөх удирдагчид болоход нь тэдэнд ямар тус дэм хэрэгтэйг ч мэддэг. Есүсийн стратеги бол энгийн бөгөөд туйлын амжилттай хэрэгждэг байв.

Есүс Өөрийг нь дагахыг урихдаа л хүссэн үр дүнгээ хэлдэг байсан. Тэр Намайг дага, Би та нарыг хүмүүсийн загасчид болгоно хэмээн шууд хэлсэн байдаг. Арван хоёр дагалдагчаас нь ганц хүн л энэхүү найдлагад нь хүрээгүй. Үлдсэн бүх дагалдагчид нь маш зоригтой, Есүсийн бэлдсэнчлэн өөрчлөгдсөн удирдагчид болсныг үзвэл Есүс зорилготой байсныг харуулдаг. Есүс удирдлагын хөгжлийн стратегидаа ямар алхмуудыг хийсэн бэ?

БУСАД ХҮМҮҮС ДАГАХУЙЦ ҮЛГЭР ЖИШЭЭГ ҮЗҮҮЛ

“Тэрбээр Түүнтэй хамт байж болзошгүй гэсэн арван хоёр дагалдагчаа тослов.”

Есүс дагалдагчдаа Өөртэйгөө ойр дотно байлгахыг хүссэн. Тэрбээр сүнслэг удирдагчийн төгс үлгэр жишээг харуулсан бөгөөд Өөрийн дуудсан хүмүүстэйгээ ойр зэргэлдээ амьдрахаас төвөгшөөгөөгүй билээ. Дагалдагч нар нь гурван жилийн турш бараг өдөр бүр Есүстэй хамт байсан бөгөөд Есүс тэдэнд сүнслэг удирдагчийн төгс жишээг харуулсаар байсан юм.

Есүс загалмайн үхлийнхээ өмнө дагалдагчдынхаа хөлийг угаасан нь ч зорилготой байв. Үүгээрээ дамжуулан Есүс зарц удирдагч байхын жишээг өөрийн биеэр үзүүлэх боломжийг ашигласан байдаг. Есүс энэхүү зарц барлагийн үйлчлэлийг хийж дуусгасан нь дагалдагч нартаа Өөрийн хайрыг илэрхийлэх хүслээ бодитоор илэрхийлсэн нь энэ байжээ. (шавь нарын хөл нь бохир угааж цэвэрлэх шаардлагатай байв).

Есүс дэлхий дээр байж үйлчлэх хугацаандаа Эцэгийнхээ жишээг дагаж байснаа илчлэн хэлсэн байдаг. Есүс Эцэгийн хийдэг зүйлийг би хийсэн гэж дагалдагч нартаа хэлсэн байдаг. Есүс Өөрийн Эцэгийг үргэлж ажилласаар байдаг бөгөөд Өөрөө Эцэгийнхээ ажлыг гүйцэлдүүлэхээр ирсэн гэдгээ хэлсэн байдаг. Есүс газар дэлхий дээрх амьдралынхаа туршид тэнгэрлэг Эцэгтээ бүрэн дүүрэн дуулгавартай байж бидэнд үлгэр жишээ үзүүлсэн. Бид харин Есүсийн бидэнд даалган үлдээсэн ажлыг гүйцээх ёстой бөгөөд бидний итгэлийн зохиогч, төгс биелүүлэгч болсон Есүсийн гишгэсэн мөрөөр явж тэрхүү үүргийг биелүүлэх юм.

“Би Христийг дуурайдаг шиг намайг дуурайгчид бай” 1Коринт 11:1

Элч Паул мөн адил даган дуурайхуйц үлгэр жишээг харуулсан байдаг. Паул би Христийг даган дуурайсны адил намайг дуурай хэмээн Коринт чуулганы итгэгчдийг жинхэнэ даруу байдлаар ятгаж чадсан байдаг. Энэхүү тунхагийг хэлэхүйц цөөхөн сүнслэг удирдагч байсан хэдий ч яг л энэ үгсийг бид Шинэ Үеийн удирдагч нарт хэлж дамжуулах ёстой юм. Бид бүгдээрээ төгс бус шавар савнууд боловч Бурханы нигүүлсэл ба Ариун Сүнсний хүчээр бид сүнслэг удирдагчийн үлгэр жишээг харуулж, Есүс Христийг дагадагийн адилаар жинхэнэ дагалдагчид байж чадна.

Шинэ Үеийн удирдагч нарт Христтэй адил үлгэр жишээ болохуйц удирдагчид маш хэрэгтэй. Тэд төгс төгөлдөр хүмүүсийг хайдаггүй, харин жинхэнэ үнэн, даруу, Сүнсээр дүүрсэн, харилцахад ойр дотно удирдагчдыг хайж байдаг билээ.



АГУУ ЗАХИРАМЖИЙГ БИЕЛҮҮЛЭХ ШИНЭ ҮЕИЙН УДИРДАГЧДЫГ ӨСГӨХ НЬ

БОЛОМЖ БОЛОЛЦООГОО АШИГЛА

Есүс үйлчлэлээ эхлэсэн даруйдаа янз бүрийн гарал, зан авиртай арван хоёр хүнийг Өөрийн дагалдагч болгон сонгодог билээ. Есүс мужааны ажлаа орхиод сайн мэдээг тунхаглахад, өвчтэй хүмүүсийг эдгээхэд, чөтгөрүүдийг зайлуулахад, дагалдагч нараа төлөвшсөн сүнслэг удирдагчид болгон хөгжүүлэхэд бүх цагаа зориулсан юм. Түүнээс хойших гурван жилийн турш эдгээр удирдагчид Есүстэй хамт амьдран сургагдсанаас гадна Түүний хаа явсан газар дагалдаж байв. Тэднийг Өөртэйгөө хамт байлгаж, өдөр тутам Өөртөй нь ойр байх, дагалдагчаар бэлтгэх нь Түүний нэн тэргүүний зорилго байсан нь тодорхой байна. Удирдагчийнхаа үүрэг хариуцлагаас гадна, Петр, Иаков болон Иохантай хамт зориуд тусгай цагуудыг гаргасан байдаг.

Есүс гайхалтай үйлчлэлийн боломжууд, олон хүмүүсийн дунд номлох боломжуудаас татгалзах тохиолдлууд байсан нь арван хоёр дагалдагчдаа цаг гаргахын тулд байсан юм. Олон хүмүүсийн дунд хийж, ярих зүйлсээс ч илүү бодсон төлөвлөсөн зүйл Есүст байжээ. Заримдаа сүнслэг болон бодит хэрэгцээгээ хангуулахаас татгалзан явсан хүмүүс ч байдаг. Есүс мэдрэмжгүй хайхрамжгүй эсвэл амин хувиа хичээсэндээ бус харин урт хугацааны турш эрүүл мэнд, сүнслэг өсөлт, үйлчлэлийн үр жимсийг зохистой эрүүл байлгахын чухлыг, үйлчлэлээ зохистой тэнцвэртэй байлгахын чухлыг үлгэрлэн харуулж байсан нь тэр байжээ. Есүс цаг хугацаа, эрч хүч, харилцаа ба нөлөөллийг хэрхэн бодлоготойгоор зохицуулж болдгийг бүх үеийнхэнд харуулахуйц үлгэр жишээг үзүүлсэн юм. Есүс эрүүл хил хязгаарыг тогтоож чадсан бөгөөд бусдын хүлээж найдсан зүйлсээс болоод Өөрийнх нь гүйцэлдүүлэхээр зорьж төлөвлөсөн зүйлс саатахыг зөвшөөрөөгүй юм. Дараагийн үеийн удирдагч нар мөн удирдлагынхаа бүрэн эрхийг зөв зохистой ашиглаж чадвал тийм байж чадна.

ТОЙРГОО ТОМСГО

Есүс хэдий гурван дагалдагчтайгаа маш ойр байж, арван хоёроороо хүрээлүүлж байсан ч Түүнийг дагалддаг байсан илүү том хүрээлэл ч үүссэн байв. Үйлчлэлээсээ эргэж ирэхдээ уулзаж яриа өрнүүлдэг олон дагагч байсаар байв. Сайн мэдээний аль номыг уншсанаас шалтгаалж түүний багт байсан хүмүүсийн тоо нэг бол дал эсвэл далан хоёр байсан гэж гардаг. Есүс зарим үед дотоод тойргоо томсгон Өөрийг нь үнэнчээр дагагч, ирээдүйд удирдагч болох бололцоотой хүмүүст цагаа зарцуулж тэдэнд Өөртэй нь харилцах боломж олгож байсан.

Та магадгүй цөөхөн хүмүүсийг дагалдуулан жижиг хэмжээний сүнслэг удирдагчийн хүрээлэлтэй болсон байж магадгүй юм. Магадгүй энэхүү дотно нөлөөллийн хүрээлэл тань арваас арван хоёр хүнтэй байж болох юм. Харин та цагаас цагт өөрийн нөлөөллийн тойргоо томсгон Шинэ Үеийн удирдагчид таны удирдлагаас суралцах боломж бололцоог гаргаж өгч байгаасай гэж уриалж байна. Тэдэнд удирдлагаасаа суралцах боломж олгож, асуултууд асуухыг зөвшөөр. Тэдний итгэл ба бүтээлч байдлыг өсгөн тэлэх үйлчлэлийн хувьд утга учиртай үүрэг даалгавруудыг өг. Эрүүл удирдлагын баг хэрхэн явагддагийг харуулж сургах үүднээс тэднээс нэг хоёр хүнийг удирдагчдын болон удирдах зөвлөлийн хуралд оруулж үз. Хурал уулзалтын дараа тэдэнд асуулт асуух, ажиглалтаас анзаарч сурсан зүйлсээ хуваалцах боломж олгон хэдэн хормыг зарцуулж бай. Эцэгтэй илүү гүнзгий байдлаар холбогдох сүнслэг өсөлтийн кемп семинар, конференцод цөөн тооны залуу удирдагчдыг дагуулж явж байж болно. Дотоод тойргоо өргөтгөхдөө одоогийн цагийн хуваариасаа гадна цаг, орон зай заавал гаргах гэсний хэрэггүй. Аль хэдийн төлөвлөсөн уулзалтууд, зорьсон төлөвлөсөн зүйлсээ хийхдээ л тэднийг урьж оролцуулж болно шүү дээ. Иймэрхүү зүйлст оролцох боломж залуучуудын хувьд их чухал бөгөөд удирдагчдаасаа илүү үнэ цэнэтэй зүйлсийг суралцахад нь тусладаг юм. Иймэрхүү мөчүүд таны тухайн долоо хоногийн онцлох үйл явдлууд ч болох боломжтой.

Хэдийгээр дотоод жижиг хүрээлэлд тань сүнслэг хөрөнгө оруулалтын тань ихэнх хэсэг зориулагдах ч Есүс зарим тохиолдолд хүрээллийг бусдад боломж олгон тэлдэг байсныг санаарай. Гайхалтай үйлчлэлд оролцох боломжийг дал гаруй хүнд олгон тэднийг сайн мэдээнд илгээж байсан жишээнээс харвал Есүс тэдэнд итгэж үүрэг даалгавар олгосоноор Бурханы ажил өөрсдөөр нь дамжин хийгдсэнийг тэд биеэр гэрчлэх завшаан гарсан хэрэг.

13

Зарим тохиолдолд тийнхүү тойргийг томсгосоноор хаанчлалд маш их үр жимсийг авчирдаг юм. Дараагийн үеийн удирдагч нарт оруулсан багахан цаг анхаарал үүнтэй төстэй үр жимсүүдийг гаргаж болох юм. Одоо ч гэсэн Бурхан таныг дотоод тойргоо томсгохыг ятгаж буй болов уу.



АГУУ ЗАХИРАМЖИЙГ БИЕЛҮҮЛЭХ ШИНЭ ҮЕИЙН УДИРДАГЧДЫГ ӨСГӨХ НЬ

Заримдаа болдог удирдагчдын сургалт семинарт шинэ үеийн удирдагчдыг хэрхэн оролцуулах талаар Есүсээс ганц хоёр үлгэр жишээ авсан гэж найдаж байна. Удирдамжийн төлөө залбирч, сайтар төлөвлөж, төлөвлөгөөгөө сайтар дагаарай. Шинэ удирдагчдыг төрүүлэн гаргахын тулд та тэдэнтэй харилцах, сүнслэг зүйлсийг өгөх нь маш их үнэ цэнэтэй болохыг сануулж байна.

УДИРДАГЧИЙГ ХӨГЖҮҮЛЭХ НӨӨЦ БОЛОЛЦООГ ХАЙ

Сүнслэг удирдагчдыг хөгжүүлэхийн тулд санхүүгийн нөөц бололцоог цуглуулах нь шаардлагатай байдаг. Энэ талаар ховорхон яригддаг. Есүс болон Түүний дагалдагч нарыг үйлчлэлээ хийн аялан явахад нь тэдний хэрэгцээт зүйлсийг хангаж өгч дэмжиж байсан бүлэг хүмүүс байжээ (Лук8:1-3). Эдгээр санхүүгийн эх сурвалжуудын зорилго нь Есүс болон төрж гарч ирж буй арван хоёр удирдагч өөрсдийн хүч бололцоо, эрч хүчээ үйлчлэл болон удирдагчийн хөгжилд бүрэн зарцуулаасай гэсэнд оршиж байсан юм. Энэ бол Бурханы хаанчлалын ажлыг дэмжиж байгаа тэдний арга зам байсан. Есүс тэднийг ийм байдлаар үйлчлээч гэж асуусан эсэх, эсвэл Ариун Сүнс санхүүгээр дэмжих энэхүү чухал үүргийг гүйцэлдүүл гэж удирдсан эсэх нь тодорхой бус. Ямартаа ч Есүс сүнслэг өсөлт хөгжилтөд анхаарлаа хандуулах боломжийг тэрхүү санхүүгийн бололцоо бүрдүүлж байсан.

Олон удирдагчид санхүүгийн нөөц бололцоо нэлээд хязгаартай нийгэм орчинд амьдардаг нь үнэн. Гэхдээ бидэнд урьдчилан төлөвлөх, алсын харааг тодорхой дамжуулах, Бурханы хүмүүсээр санхүүгийн амлалтууд өгүүлэх, Бурханы хангамжид итгэх, сүнслэг удирдагчдын өсөлт хөгжлийг бий болгох үйлчлэлийн санхүүг дээгүүрт тавих зэрэг чадварууд бий билээ. Сүнслэг удирдагчдын өсөлтийн хэрэгцээг дан дангаар бус сүм чуулганаараа нийлэн босгохыг уриалж болно. Ийнхүү нэгдэж зүтгэвэл Христийн биеийг зоригжуулахаас гадна Бурханаас өгөгдсөн үүргийг хамтдаа гүйцэтгэж чадах билээ.

АГУУ УДИРДАГЧ БАЙХЫГ ҮЛГЭРЛЭН ҮЗҮҮЛ

Есүс гайхалтай удирдагч байсан. Дагалдагч нарыг Түүнтэй байлгаж, гурван жилийн турш дагах гол шалтгаан энэ байв. Есүс дагалдагч нартаа нөлөөлж, тэднийг удирдагч болгон бэлтгэхийг ихэд хүсч байв. Дагалдагч нарт Есүсийн зааж сургаж байсныг өөрсдийн биеэр сонсч харах боломж маш их байсан. Дагалдагч нар Есүсийг хүмүүстэй яаж харьцаж байсныг, Түүний хувьд юу чухал болохыг, хоол хүнсний төлөө хэрхэн талархдагийг, завгүй үйлчлэлээс хэзээ өөрийгөө татаж Эцэгтэйгээ цаг өнгөрөөхийг, хэн ч холбогдохыг хүсдэггүй байсан хүмүүст хэрхэн хайрыг харуулж харьцдагийг дагалдагч нар дэргэдээс нь харж байсан. Есүс номхон даруу зангаар агуу байхыг, үйлчлэлээр хайрыг, зовлон хавчлагаар дамжуулан тэвчээрийг, өршөөл нигүүлслийг харуулдаг байсан билээ.

Танай сүм болон бизнест байгаа шинэ үеийн удирдагч нарт дагаж дуурайх агуу удирдагч нар хэрэгтэй. Мундаг удирдагчдыг үлгэрлэн харуулж, тэднийг удирдагч болон өсөхөд нь туслах тань шиг хүмүүс тэдэнд хэрэгтэй. Дахиад хэлэхэд мундаг гэдэг нь төгс гэсэн үг биш, харин Христийн адил, онц сайн гэсэн утгатай илүү дүйнэ. Та шинэ үеийн удирдагч нарт агуу удирдлагыг үлгэрлэн харуулж байна уу?

ЭРҮҮЛ УДИРДЛАГЫН СОЁЛЫГ УСЛАН БИЙ БОЛГО

Есүсийн сонгосон эрчүүд нийгэм эдийн засаг, шашны талаар өөрийн гэсэн итгэл үнэмшил, ажил мэргэжилтэй байсан. Есүс тэднийг төгс бус байгаа хэвээр нь л байлгаж, ялгаж гадуурхдаггүй, тэдэнд эргэлздэг ч үгүй байсан. Тэд өөр хоорондоо маргалддаг байсан ч нөхцөл болзолгүйгээр хайрлагдаж, гэм нүгэлтнүүд байх эрх чөлөөтэй байв. Тэд хэн нь хамгийн агуу байх, хэн нь хамгийн чухал байх талаар хоорондоо маргалдаж байсан тохиолдол ч бий. Есүс тэднийг сайнмэдээг дэлхийн хязгаар хүртэл хүргэх зоригт удирдагч нар болгон өөрчилж байсан ч энэ бол их цаг хугацаа орох суралцах, төлөвших үйл явц гэдгийг Есүс мэддэг байв. Есүс шавар чулуун дотроос алмаз эрдэнийг олж хардаг буюу сүнсээр төлөвшөөгүй байдлын цаана агуу удирдагчийн потенциал байдгийг хардаг байжээ.



АГУУ ЗАХИРАМЖИЙГ БИЕЛҮҮЛЭХ ШИНЭ ҮЕИЙН УДИРДАГЧДЫГ ӨСГӨХ НЬ

Есүсийн бий болгосон удирдлагын соёлын наад захын зүйлс нь юу байв? Эхлээд тэдгээр удирдагч өөрсдийгөө сонгогдсон гэдгээ мэддэг байсан явдал байв. Есүс тэднийг өөрийн багтаа урихдаа зориуд зорьж очин, хувьчлан урьж нэгтгэдэг байв. Тэд өөрсдийн харъяалалаа мэддэг байв. Есүс үргэлж үнэнийг хайр дотор хэлдэг байсан. Петр болон бусад дагалдагч нар Есүсийн энэхүү удирдлагын чанарыг их сайн мэддэг байв. Гуравдугаарт, Есүс дорд болохоос үл эмээж өөрийгөө даруу болгосноор зарц удирдагчийн соёлыг бий болгосон юм. Дөрөвт, Есүс өвчтэй, ядуу зүдүү хүмүүст үйлчилж тусладаг, биеэ үнэлэгчид болон татвар хураагч нартай нөхөрлөж, хэрэгцээтэй хүмүүст өгөөмөр зан, нигүүлслийг өгч үлгэрлэснээр удирдагчийн үүрэгт соёлыг бий болгосон. Есүс нигүүлсэл өршөөлөөр дүүрэн удирдагчийн соёлыг бий болгосон билээ.

СУРАЛЦАХ, ДАДЛАГАЖИХ БОЛОМЖ БОЛОЛЦООГ БИЙ БОЛГО

Есүс дагалдагч нартаа ажиглаж харснаасаа болон эрх мэдэлтэй сургаалуудыг сонсоод сурсан зүйлсээ дадлагажуулах олон боломжийг өгсөн. Хоёр алдартай жишээг дурдвал, Есүс арван хоёр дагалдагчдаа сайнмэдээг тунхаглах, өвчтэйг эдгээх, чөтгөрүүдийг хөөх зэрэг үүрэгт ажлууд өгч явуулсан түүх Библид гардаг. Есүс бүр ч олон хүмүүсийг мөн адил зүйлс хийлгэхээр илгээсэн байдаг. Есүс дагалдагч нараасаа ихийг хүлээж байв. Есүс тэднийг илгээхдээ ямар ч богц, бэлэн мөнгөгүй, ямар ч буудлын захиалга урьдчилан хийлгэлгүйгээр явуулсан байдаг. Үндсэндээ бол дагалдагч нар дамжуулах мэдээ тээгээд өмссөн хувцастайгаа явсан юм. Харин тэд Бурхан тэднийг агуугаар ашигласанд баярлан баясч, мөн Есүс өөрийн биеэр байгаагүй ч тэдэнд чухал ажлыг итгэл даалган явуулсанд нь маш их хөөрөн баярлаж буцаж ирсэн байдаг. Есүс тэднийг хоноглох газраа олоод, хаана очиж сайн мэдээг тунхаглаж заахаа олчихно гэж, найдвар хэрэгтэй хүмүүст хүрэх зориг, бүтээлч байдлыг гарган хүмүүсийг оролцуулж чадна гэж дагалдагч нартаа итгэл үзүүлсэн юм. Есүс чимээгүйхэн ажиглаад явж болох байсан ч тэд сурсан зүйлсээ хэрэгжүүлж, улмаар хүмүүсийн амьдралд мөнхийн өөрчлөлтийг бий болгож, түүгээрээ дамжуулж өөртөө итгэх итгэл нь өсөөсэй гэж хүссэнийх юм. Тэд эргэн ирээд Есүст Бурхан тэднээр дамжуулан юу хийснийг тайлагнахуйд Есүс тэднийг суулгаад, хэрхэн илүү дээр хийж болох байсныг даруй зааж өгсөн удаагүй билээ. Есүс баясч тэдэнтэй хамт баярлаж байв. Есүс тэдний амжилтад баярлаж байв. Үнэн хэрэгтээ Есүс тэднийг ирээдүйд энэ дэлхийд сайнмэдээг түгээхэд бэлтгэж эдгээр сургалтуудыг зориуд зохион байгуулсан юм.

Та ч бас өөрийн чуулган эсвэл байгууллагад байгаа шинэ үеийн удирдагчдад таны удирдлагаас сурсан зүйлсээ батжуулах, дадлага хийх сайхан боломжуудыг бий болгох боломжтой шүү. Үүнийг бодит болгохын тулд, энэхүү гарын авлагыг уншиж буй зарим удирдагчид чухал хэдэн зүйлсийг хийх хэрэгтэй болно. Эхлээд та шинэ үеийн удирдагчдад итгэж сурах хэрэгтэй. Таныг сонсч байсан гэдэгт, таны удирдлагын арга барилыг ажиглаж байсан гэдэгт тэдний харагдаж буй байдлаас үл хамааран итгээрэй. Тантай адилхан удирдагчийн байр суурийг өгвөл тэд боломжийг ашиглан өсч хөгжих болно гэдэгт итгээрэй.

Хоёрдугаарт, та тэднийг гайхамшигт зүйлсийг хийх бололцоотой гэдэгт нь итгэдгээ харуулах хэрэгтэй. Та тэдэнтэй харилцахдаа ямар үгс хэлж байна, ямар биеийн хэл харуулж байна вэ? Гуравдугаарт, та тэдний итгэлийг өсгөж, тэдний төсөөлөлд урам зориг өгөх хэрэгтэй. Тэдэнд шийдэлцэх чухал асуудлуудыг өг. Таны хөндлөнгийн оролцоогүйгээр, жижиг удирдлагын оролцоогүйгээр санаачилга гаргаж, асуудлуудаа өөрсдөө шийдвэрлэхийг нь зөвшөөр. Ариун Сүнс тэдний амьдралд чиг өгч хөдлөнө гэдэгт итгэ. Тэд нигүүлслээр дүүрэн удирдагчийн соёлыг сурч, түүнийгээ дадлагажуулах хэрэгтэй юм. Та тэднийг чухал үйлчлэлд эсвэл бизнесийн төслүүдэд тэднийг оролцуулж, тэдний нөлөөг зөвшөөрөх үед шинэ үеийн удирдагч нар ямар чадвартай болохыг төсөөлөх ч үгүй.

ЭРГЭЦҮҮЛЭМЖ

1. Танай чуулган, бизнесийн байгууллагад байгаа хүмүүсийн удирдлагын соёл ямар вэ? Нигүүлсэл, өршөөл, жинхэнэ үнэнээр дүүрэн үү? эсвэл гүйцэтгэл, айдас, захиргаадалтын орчин гэж тодорхойлогдох уу?
2. Таны гарт удирдлагын хөгжлийн ямар потенциал, нөөц бололцоо байгаа вэ? Шинэ Үеийн удирдагчдыг хөгжүүлэх нөөц бололцоог бий болгоход ямар үйлчлэл эсвэл ямар бизнестэй хамтрах боломж байгаа вэ? Танай чуулган эсвэл бизнес шинэ үеийн удирдагчдыг хөгжүүлэх санаачилгад урт хугацааны төлөвлөгөө, санхүүгийн хөрөнгө оруулалтыг хэрхэн төлөвлөж боловсруулах вэ?



АГУУ ЗАХИРАМЖИЙГ БИЕЛҮҮЛЭХ ШИНЭ ҮЕИЙН УДИРДАГЧДЫГ ӨСГӨХ НЬ

3. Дотоод тойрогтоо шинэ үеийн удирдагчдыг оролцуулан өргөжүүлэхийн тулд хэрэгжүүлж болох ямар гурван боломж байна вэ? Дараах хэрэгжүүлэх алхмын хүснэгтийг ашиглан бодол санаагаа тэмдэглэнэ үү.

ЗАЛБИРАЛ

Эзэн Есүс ээ, зорилготой удирдагч байсанд баярлалаа. Есүс Та дотоод тойргоо бүрдүүлэхдээ хэнийг сонгохоо төлөвлөсөн байсан. Мөн Та зарим үед сүнслэг удирдагчдыг өсгөхийн тулд, чухал даалгаваруудыг гүйцэтгүүлэхээр тойргоо тэлдэг байсан. Зорилготой удирдагч байсан Таны жишээг дагахад минь туслаач. Гэр бүл, нийгэм, ажлын газартаа гайхалтай сүнслэг удирдагчийн Бурханлаг үлгэр дууриалалтай амьдралаар амьдрахад минь туслаач. Сүм чуулгандаа, бизнестээ эрүүл, нигүүлсэл өршөөлөөр дүүрэн, шинэ үеийн удирдагчдыг хөгжүүлэхэд анхааран удирдлагын соёл орчныг бий болгоход Ариун Сүнсээрээ дамжуулан Та надад мэргэн ухаан хайрлаач. Цаг заваа сайтар ашиглахад минь туслаж, Таны мөнхийн зорилгуудад удирдах арга барилыг маань ашиглаж өгөөч. Энэ бүхнийг Эзэн Есүсийн нэр дээр залбирч байна. Амэн.

Amen.

ШААРДЛАГАТАЙ АРГА ХЭМЖЭЭ	ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

ЗАРЧИМ 3: ХАРИЛЦААНЫ ЧАДВАРТАЙ УДИРДАГЧ

“Есүс арван хоёрыг томилон, элч хэмээсэн нь тэднийг Өөртэйгөө хамт байлгаж...” Марк3:14

“Би та нарыг боолууд гэж дахиж дуудахгүй. Учир нь эзнийхээ юу хийж байгааг боол эс мэдэх юм. Харин Би та нарыг анд нөхөд гэж дуудав...” Иохан15:15

“дэлхийд байсан Өөрийнхнийгөө хайрлаж байсан тул тэднийг эцсээ хүртэл хайрлав...”

ЗОЧЛОМТГОЙ БАЙДАЛД СУРАЛЦ

Есүс “Үнэгэнд нүх, тэнгэрийн шувуудад үүр байдаг ч Хүний Хүүд толгой хоргодох газар ч үгүй гэлээ” Матай8:20 хэмээн дагалдагч нартаа хэлсэн байдаг. Оршин суух газар үгүй бол зочломтгой байдлыг хэрэгжүүлэх нь бэрхшээлтэй санагдаж байж болох юм. Гэсэн ч бид зочдыг гэртээ зугаацуулахаас илүү өргөн хүрээнд үүнийг ойлгох хэрэгтэй юм. Хенри Ноувэн зочломтгой занг “танихгүй хүн орж ирээд дайсан бус анд нөхөд болдог чөлөөт орон зайг бий болгох нь зочломтгой байдал юм. Зочломтгой байснаар бусдыг өөрчилдөггүй харин өөрчлөгдөж болох орон зайг хүмүүст олгож байгаа хэрэг юм. Эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийг өөрийн талд оруулахын тулд бус шугам зааг гарган хуваалгүйгээр эрх чөлөөг олгох явдал юм” (Nouwen 1986) хэмээн тодорхойлсон байдаг.



Бид судалгаанд оролцогчдоос сүнслэг удирдагчаас хамгийн их биширдэг хоёр чанарыг дурдахыг хүссэн. Хариултын 61% нь үнэн жинхэнэ байдал, 57% нь бүх хүмүүстэй харилцдаг гэсэн бол 56% нь шинэ удирдагчдыг халамжилдаг чанаруудыг тус тус сонгон хариулсан.



АГУУ ЗАХИРАМЖИЙГ БИЕЛҮҮЛЭХ ШИНЭ ҮЕИЙН УДИРДАГЧДЫГ ӨСГӨХ НЬ

Есүс харанхуйд нуугдан Өөрийг нь зорьж ирсэн Никодемд сайн мэдээг сонсох аюулгүй орчныг өгч, түүнийг хөгжөөсөн түүх байдаг. Есүс дагалдагчдаа сүнслэг өсөлтийн сургалтад авч явж, зочломтгой байдлыг харуулж, тэдний удирдах чадварыг хурцалж, олон зүйлсийг заах цаг орон зайг гаргаж өгдөг байсан билээ.

Бид ч бас бусадтай харилцах харилцааг гүнзгийрүүлэх гол түлхүүр бол зочломтгой байдал гэдгийг бодож үзэх хэрэгтэй. Олон сүнслэг удирдагчдын хувьд, зочломтгой байдал бол амьсгалахтай адил байх ёстой зүйл юм. Учир нь тэдний соёлд зочломтгой байдал гүн бат шингэсэн байдаг. Зарим хүмүүсийн хувьд зочломтгой байх нь нэг л хиймэл, нэлээд хичээл зүтгэл шаарддаг. Зочломтгой байдлыг илүү өргөн хүрээнд тухайлбал өөрийн гэрийг бусдад нээж өгөхөөс гадна, өөрийн амьдрал, өөрийн цагийн хуваарь болон зүрх сэтгэл, ариун нандин орон зайг бусдад нээж өгснөөр тэднийг сайнмэдээг сонсох, ойлгох боломж руу хөтлөх юм.

ЖИНХЭНЭ ХАЛАМЖЛАГЧ / МЕНТОР БАЙ

Таныг сүнсээр өсч байх үеийн удирдагчдын тухай эргүүлэн бодоорой. Тэдгээр он жилүүдэд танд хамгийн их нөлөөлсөн хүмүүс хэн байв? Таны амьдралд хамгийн том сүнслэг нөлөөллийг үзүүлсэн нэг хоёр хүний нэрс танд бэлхэнээ бууж байгаа биз ээ. Сайтар тунгаан бодвол өнөөдөр таныг удирдагч болох хүртэл танд туслаж дэмжсэн дөрвөөс таван ч хүн гарч ирж магадгүй юм.

1990-ээд онд Паул Станли болон Роберт Ж.Клинтон нар сайн тэмцлээр тэмцсэн сүнслэг удирдагчдын талаар судалгаа явуулжээ. Мянга гаруй сүнслэг удирдагчдын талаар судласны эцэст, тэдгээр удирдагчдад нийтлэг анзаарагдсан таван гол зан чанарууд байжээ. Нэг нийтлэг зүйл анзаарагдсан нь амьдралынх нь турш хэд хэдэн чухал халамжлагч буюу утга учиртай харилцааны сүлжээ тэдэнд байсан байжээ (Stanley and Clinton 1992). Стенли болон Клинтон нар менторлох үйл явцыг “Бурханы өгсөн нөөц бололцоог нэг нэгэнтэйгээ хуваалцсанаар бие биенээ хүчирхэгжүүлдэг харилцааны туршлага” гэж тодорхойлжээ.

- 20** Жинхэнэ ментор буюу халамжлах харилцааг хоёр түвшинд байгуулах хэрэгтэй. Нэгдүгээрт, эцсийг нь хүртэл тэмцлээ сайн дуусгахын төлөө явдаг, бусдад үлгэр дуурайлал болж амьдардаг менторуудтай байх ёстой. Сүнслэг амьдралын аянд дэргэд чинь зэрэгцэн явдаг үе тэнгийн менторууд чамд хэрэгтэй. Ядаж л танаас түрүүлж алхдаг нэг ментор бас байх хэрэгтэй.

Нэгэнт ийм харилцаанууд байраа олчихвол та бусдыг илүү үр дүнтэй дагуулж үлгэрлэхэд зохистой бэлтгэгдэх юм. Хоёрдугаарт, Бурханаас өгсөн нөөц боломжуудыг шинэ үеийн удирдагч нартай хуваалцсанаар улам бүр бэхжсэн жинхэнэ менторын харилцаанууд өсч хөгжих хэрэгтэй юм.

Үүний араас идэвхтэй ятгалга орно. Шинэ үеийн удирдагч нар өөрсдөө зориг гарган тан руу ирэхийг хүлээж идэвхгүй суух хэрэггүй. Санаачилгатай бай. Сүнслэг удирдагч болох чадамжтай гэж харж байгаа залуу хүмүүст хүрч оч. Өөрсдөө дагалдуулья гэж хүссэн хүмүүсээ зориудаар, төлөвлөгөөтэйгээр сонгож байсан сүнслэг агуу удирдагчдын талаарх олон түүхүүд Бичвэрт гардаг. Елиа Елишаг сонгосон. Есүс ирээдүйн арванхоёр элчийг сонгож авсан. Барнаб Паулыг хайж очдог. Паул Тимот, Тит болон бага Азиас өөр бусад залуу удирдагчдыг сонгон дагалдуулсан байдаг. Прискила болон Акул нар Аполыг хайн олж “авч гаран түүнд Бурханы замыг нарийн тайлбарлаж өгөв.” гэж Үйлс18:26-д гардаг билээ.

ОЛОН МЕНТОРТОЙ БОЛОХЫГ УРИАЛ

Фүүлер Теологийн Их Сургуулийн тэтгэвэртээ гарсан професор Доктор Роберт Клинтон хэлэхдээ “Өөрийн амьдрал болон үйлчлэлдээ эрүүл саруул хараатай байж, байнга өсч хөгжиж байхын тулд өсч яваа удирдагч хүнд менторууд, үе тэнгийнхэн, шинэ удирдагчдаас бүрэлдсэн харилцааны сүлжээ хэрэгтэй” (Stanley and Clinton 1992). Эдгээр эрдэмтэд анх удаа ‘менторуудын хүрээлэл’ гэх нэр томъёог гаргаж ирсэн билээ. Хүн амьдралынхаа турш олон ментортой байх хэрэгтэй талаар. Нэг ментор сүнслэг удирдагчийг төрж гаргахад дангаараа бүх хэрэгцээг нь хангаж чадахгүй билээ. Менторын харилцаа бүр урт хугацаанд үргэлжлэх учиргүй байдаг. Заримдаа Бурхан бидний сүнслэг өсөлтийн тодорхой нэг үед хамт байх менторыг өгдөг бөгөөд дараа дараачийн хүмүүсийг бидэнд бэлдэж өгдөг. Удирдагч нар менторын энэхүү урсгалыг хувьчлан эмзэг хүлээж авах хэрэггүй бөгөөд сүнслэг удирдагчдыг өгсөхийн тулд Ариун Сүнс менторуудыг ашигладаг болохыг ойлгох хэрэгтэй.



АГУУ ЗАХИРАМЖИЙГ БИЕЛҮҮЛЭХ ШИНЭ ҮЕИЙН УДИРДАГЧДЫГ ӨСГӨХ НЬ

Бидний эргэн тойронд олон менторууд байдагт хэд хэдэн шалтгаан байдаг. Нэгдүгээрт, бидний сүнслэг амьдралын аялалд өөр өөр үе шатууд байдаг тул өөр өөр менторууд байх шаардлагатай юм. Жишээлбэл, хэрэв Бурхан залуу удирдагчийг шинэ сүм байгуулахад дуудаж байвал, эрүүл сүм чуулган тарьж өсгөж байсан туршлагатай шинэ менторыг хайж олох нь оновчтой байх билээ. Бусад менторуудтай харьцуулахад сүм тарих талаар зөвлөгөө өгөхүйц хараа, туршлагатай сүм таригч хүн энэ тохиолдолд тохиромжтой ментор болох нь эргэлзээгүй билээ.

Залуу удирдагч хүний хувьд ментороо солих, шинэ ментортой болох зэрэг нь үнэнч бус хэрэг биш юм. Үнэн хэрэгтээ менторуудыг ялгаж салгах нь өөрчлөлт хэрэгтэйг зөгнөж байгаа бөгөөд залуу удирдагч хүн нэмэлт ментортой болох үйл явцыг туулж байгаа хэрэг юм. Шинэ үеийн удирдагч нартай менторын харилцааг анх байгуулж эхлэхдээ энэхүү боломжийн тухай ярих нь ухаалаг хэрэг юм. Тэдэнд шаардлагатай үед менторуудаа сольж өөрчлөх нь хэвийн зүйл болохыг урьдчилан хэлэх нь дээр бөгөөд тэдэнд ямар ментор хэрэгтэй байж болох талаар дахин үнэлгээ хийж ярилцаж туслаарай. Өөрсдийнхөө менторуудтай байгуулах харилцааг гартаа авч санаачилгатай байхыг тэдэнд сануулж болно. Ингэснээр тэд ментороо солих шаардлага гарах үед санаа зовох, өөрийгөө буруутгах зэрэг шаардлагагүй зүйлс гарахгүй юм.

Олон ментортой байх хэрэгтэй гэсний хоёр дахь шалтгаан бол нэг ментор бүх талын мэргэн ухаантай, бүх зүйлс дээр туршлагатай, олон талын хараатай байх нь үгүй. Ирээдүйг чиглэн өөрийгөө хөгжүүлэх гэж байгаа залуу удирдагч нарт олон ментор хэрэгтэй. Бид бүгдэд өөр өөрсдийн гэсэн сүнслэг авъяас, бодит чадварууд, амьдралын туршлагууд байдаг ч нэг хүн бүгдийг туулна гэж байдаггүй шүү дээ. Бид өөрсдийнхөө талаар эрүүл ухаанаар бодож байх хэрэгтэй бөгөөд Христийн адил даруу байж, дагалдуулах гэж байгаа хүмүүст маань Бурханаас өгөгдсөн потенциалдаа хүрэхэд нь өөр, нэмэлт ментор хэрэгтэй гэдгийг ойлгох хэрэгтэй. Менторын үүрэг гүйцэтгэж байгаа бидний үүрэг бол бидний хүсэл зорилгоос илүүтэй Ариун Сүнсний хийхийг хүссэн зүйлстэй хамтран туслах явдал гэдгийг санах хэрэгтэй.

Нэгэн хувийн жишээнээс хуваалцъя. Бурхан түүнийг шинэ бизнес рүү хөтлөөд байгааг мэдэрсэн нэгэн залууг би одоогоор менторлож байгаа юм. Түүний хувьд тодорхой хэмжээний туршлагатай ч тэрхүү бизнесийн хувьд бол ямар ч туршлагагүй. Би түүний төлөө залбирахын хажуугаар түүнд энэ талбарын бизнесийг амжилттай эхлүүлж, эрүүл өсөлттэйгээр авч яваа Христитгэлт бизнесийн мэргэжилтэнг олж зөвлөгөө авахыг санал болгосон юм. Би энэ талд чадамжтай гэж үзсэн нэгэн менторыг имэйлээр дамжуулан танилцуулж санал болгосон. Тэд саяхан уулзалдсан бөгөөд менторын харилцаанд орох боломжийн талаар удахгүй уулзаж ярилцахаар болцгоосон юм. Энэ талаар тавгүйтэхийн оронд би тэр залуугийн сүнслэг аян замд тус болж чиглүүлж өгсөндөө таатай байгаа. Сүнслэг өсөлтийн хувьд би одоо ч түүнийг менторлодог ч Бурханы түүнийг удирдаж байгаа хэмээн итгэж байгаа чиглэлд хамгийн сайн бэлгэхийн тулд түүнд нэмэлт ментортой болох шаардлага гарч байгааг ойлгодог байх хэрэгтэй.

Олон ментортой байх дөрөв дэх шалтгаан бол Бичвэрт үүнийг үлгэрлэн харуулсан байдаг. Паул Тимотыг менторлож байхдаа Тимотыг өөр бусад хүмүүст ментор хийхийг зааварласан байдаг. Тимотын менторлосон хүмүүс ч нэгэн адил Тимотоос чиглүүлэг авч байх зуураа ч өөр бусад хүмүүсийг менторлож байв.

Танд өөрийнхөө амьдралд эрүүл менторын үлгэр жишээ бүхий амьдралыг бий болгох энгийн нэгэн алхмыг санал болгоё. Өдөр тутмын амьдралаас жишээ татъя. Аливаа хот тосгонд шинэ байшин баригдах бүрт ойролцоох талбайд нь мод тарьдаг шүү дээ. Учир нь өсч томорсон өндөр модны суулгац их үнэтэй байдаг учраас ихэнх байшингийн эзэд их зардал гаргалгүй зулзаган мод худалдан авдаг. Зулзаган модонд дэс дараатай арчилгаа их хэрэгтэй байдаг тухайлбал үндсийг нь булж хийхээс эхлээд. Борооны улирал, хүчтэй салхины үед модыг эгц чигээр нь байлгахыг тулд тогтворжуулах аргыг ихэнх тохиолдолд хэрэглэдэг. Модыг тарихдаа гол модноос яг адил зайнд татуурга хийж уядаг. Тэгж байж модонд шаардлагатай түшиц тулгуурыг өгдөг.



АГУУ ЗАХИРАМЖИЙГ БИЕЛҮҮЛЭХ ШИНЭ ҮЕИЙН УДИРДАГЧДЫГ ӨСГӨХ НЬ

Та өөрийнхөө амьдралыг өндөр, чигээрээ ургасан бат бөх үндэстэй мод гэж, мөн танд хүчтэй найдвартай түшиг тулгуурууд хэрэгтэй гэж төсөөлөөд үзээрэй. Түшиц тулгууруудыг менторууд гэж бодоорой. Барнаб таныг урамшуулахын тулд, Паул таныг сорихын тулд, Тимот таныг удирдагч болгон хөгжүүлэхийн тулд байна гэж бод. Мод тулгуур хоёрын хоорондох уяа холбоос нь найдвартай, жинхэнэ харилцаануудыг төлөөлж байгаа юм. Хэрэв уяа холбоос тасрах юмуу сулрах үед, тулгуур үүргээ алдана. Хэрэв уяа холбоос нь хэт чангадвал мод салхи шуургыг сөрөн зогсох хүчгүй, уян хатан бус байх болно. Шинэ Үеийн удирдагчдыг зөв зохистой хөгжиж дэвшүүлэхийн тулд Ариун Сүнсний тусламжтай тогтоосон аюулгүй бас хүчтэй менторын харилцаа оршиж байх ёстой.

Зулзаган мод гаднаас тулах түших дэмжлэг авах шаардлагагүй болоод өөрөө ургаж эхэлдэг ч та бидэнд зөв чиглэлдээ явсаар байхын тулд менторын харилцаа үргэлж хэрэгтэй байх болно. Миний амьдралыг зааж зааварлаад байх хүн хэрэггүй гэж бодох мөчид л бидний доторх бардам, өөрийгөө дөвийлгөх үзэл зүрхэнд буглаж, өөрсдийн махан биеийн хүсэл, дэлхийн гэмт нөлөөнд хүчгүйдэж, муу нэгнээс ирэх сүнслэг дайралтуудыг амсдаг гэдгийг битгий мартаарай.

ХАМТ ОЛНЫГ БҮРДҮҮЛ

Маркын сайнмэдээний номд Есүс арван хоёр дагалдагчаа цуглуулсаныг өгүүлсэн түүх надад их таалагддаг. Есүс тэднийг 'Өөртэй нь хамт байж болзошгүй юм' хэмээн бодон урьдаас төлөвлөж тэднийг хайж очдог билээ. Есүс тэднийг Өөрийн дагалдагчаас гадна найз нөхдөө болгоно гэж шийдсэн байсан юм. Гурван жилийн турш, Есүс дагалдагч нартайгаа чанартай цагийг гаргадаг байснаас гадна их хэмжээний цагийг хамт өнгөрөөсөн байдаг.

Есүс дагалдагч нартайгаа зөвхөн хамт амьдрангаа тэднийг удирдагч болгон бэлтгэнэ гэж төлөвлөснөөс гадна олон хүмүүсийн үзэж хараагүй олон мөчүүдийг тэдэнтэй хуваалцсан байдаг. Дагалдагч нар Есүсийг ядарсан, өлссөн байхыг харж байсан мөн чимээгүй газар ганцаараа байхыг ихэд хүсэмжилж байсныг нь ч харж байсан. Дагалдагч нар итгэлгүй байх үед бухимдаж байсныг нь ч харсан, Фарисайчуудын сүнслэг харанхуй байдал, хоёр нүүрт амьдралыг нь хараад уурсч байхыг нь ч харж байсан. Дотны андаа алдаад гашуудан уйлж байсныг нь ч дагалдагч нар харж байсан. Есүс арван хоёр дагалдагчаа сүнсний илүү гүн гүнзгий нөхөрлөл рүү урьж, жинхэнэ удирдагчийг үнэнээр үлгэрлэн харуулдаг байсан. Есүс галын дэргэд ойр зуур зүйлс ярих цаг гаргаж, найз нөхөдтэйгээ хошигнолдож, сүнслэг гүнзгий яриа хөөрөө өрнүүлдэг байсан. Есүс бидний хүн бүрт үлгэрлэн дагах итгэлийн үлгэр дуурайллыг харуулж амьдарсан билээ. Есүс төрж гарч буй удирдагч нартай чин сэтгэлийн харилцааг бий болгож, Есүс бол Эзэн ба Христ төдийгүй тэдний анд нөхөр гэдгийг тэдэнд ойлгуулан амьдарсан билээ. Бид ч бас Түүнийг дуурайн амьдрах хэрэгтэй юм.

Та бүхнийг чуулган болон бизнесийн хүмүүсээсээ хол хөндий байдаг сүнслэг удирдагчдын жишээг битгий дагаасай гэж би ятгаж байна. Тэдний шалтаг шалтгаан юу ч байлаа гэсэн, тэдний үлгэрлэн харуулж байгаа удирдлагын тухай Бичвэрт байдаггүй билээ. Харин бид Есүс, Паул, Барнаб, Тимот, Прискила, Акул болон Тит нар шиг итгэгч нарт өөрсдийн амьдралаа нээлттэй байлгаж, хамтдаа сүнслэг амьдралаар анд нөхөд болон алхцгаадаг тухай л Бичвэрээс олж хардаг. Бурхан хүмүүс бидний хязгаар сул талыг ч бас мэддэг тийм ч учраас Есүсийн адилаар цөөн хүмүүсийг удирдан дагуулах нь ухаалаг хэрэг юм.

Бусдаас зайтай байхыг хүсч байгаа зарим сүнслэг удирдагчдын хамгийн том шалтгаан бол тэд бусдын өмнө сул дорой харагдахаас, бусад хүмүүст тайзны ард талын үнэн төрхөө, өөрсдийн жинхэнэ төрхөө харуулахыг хүсдэггүй, айдгаас болдог болов уу гэж би боддог.

NEXTGEN RISING

25



АГУУ ЗАХИРАМЖИЙГ БИЕЛҮҮЛЭХ ШИНЭ ҮЕИЙН УДИРДАГЧДЫГ ӨСГӨХ НЬ

Тэд нүгэлт хүн гэж харагдахаас үхтлээ айдаг. Үнэндээ бид бүгд л нүгэлтэй. Бурхан хэзээ ч биднээс төгс байдлыг хүлээдэггүй. Бурхан биднийг газар шорооноос бүтсэнийг мэддэг. Гэвч Бурхан сүнслэг удирдагчдаас жинхэнэ, үнэнч байдлыг л хүлээдэг. Бурхан биднийг бусдаар хүлээн зөвшөөрүүлэх гэсэн, бусдаар сайшаан магтуулах гэсэн дарамт ачаанаас чөлөөлөх болтугай. Бурхан биднийг хуурамч сүнслэг удирдагч бус харин Бурханы сайн ба нигүүлсэлд найдагч, удирдаж байгаа хүмүүстэйгээ бодит, жинхэнэ, төгс бус ч өршөөнгүй байдлаар чөлөөтэй ханддаг болгож чөлөөлөх болтугай.

ЭРГЭЦҮҮЛЭМЖ

1. Таныг залуу удирдагч байхад Ариун Сүнсний таны амьдралд эрх мэдэлтэйгээр илгээсэн сүнслэг менторууд, үе тэнгийн менторууд чинь ямар хүмүүс байсан талаар бодно уу. Тэдгээр хүмүүсийн төлөө Тэнгэрлэг Эцэгт талархах мөч гаргаарай. Боломжтой бол тэдний таны амьдралд үзүүлсэн сүнслэг хөрөнгө оруулалт, дэмжлэгийнх нь төлөө тэдэнтэй холбоо барин талархлаа илэрхийлээрэй.

2. Та өөрийгөө голд нь тавиад таныг тойрсон менторуудыг схемчлэн зураад үзээрэй. Таны сүнслэг аянд хэн таны өмнө явж байна вэ? Хэн таны дэргэд таны ментор болон алхаж байна вэ? Таныг сүнслэг ментороо болгон хардаг ямар хүмүүс таны ард байна вэ? Тэдгээр менторуудын тойрогт дутагдаж байгаа хүн байна уу? Менторынхоо хүрээнд Шинэ Үеийн удирдагчийг нэмэн оруулах зай байна уу?

3. Зочломтгой байх сүнслэг хэв журмыг та хэрхэн хэрэгжүүлж байгаа вэ? Шинэ Үеийн Удирдагч нарт жинхэнэ харилцааг үүсгэх орон зай танд байна уу? Залуу удирдагч нарт зочломтгой байхын тулд зүрх сэтгэл, цагийн хуваарь, орон гэр болон менторын орон зайгаа нээж өгөх ямар үйлдлүүдийг та хийж болох вэ?

ЗАЛБИРАЛ

Эцэг минь, миний сүнслэг аян замын турш амьдралд маань илгээж өгсөн сүнслэг удирдагч менторуудын төлөө талархъя. Тэд миний амьдралд мөнхийн өөрчлөлтийг авчирсан бөгөөд тэдний төлөө талархъя. Тэдний үзүүлсэн нөлөөллүүдийн төлөө талархъя. Шинээр менторын харилцаанууд үүсгэхээр амьдралдаа орон зайг бий болгоход минь туслаач. Миний менторын хүрээллийн аль хэсэг нь хүчгүй байгааг харах даруу занг өгөөч. Удирдагчийнхаа хувьд уралдаанаа сайтар дуусгахын тулд сүнслэг дэмжлэгүүд болох бусад

удирдагч нар луу зоригтойгоор хүрч уулзахад минь туслаач. Эцэг минь, би уралдаандаа сайн гүймээр байна, сайн дуусгамаар байна. Бусад сүнсэг удирдагчдын хамтаар аянаа дуусгаж, бид бүгд Таны амнаас 'сайн байна' хэмээх магтаалыг сонсмоор байна.

Амэн

ШААРДЛАГАТАЙ АРГА ХЭМЖЭЭ	ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА



АГУУ ЗАХИРАМЖИЙГ БИЕЛҮҮЛЭХ ШИНЭ ҮЕИЙН УДИРДАГЧДЫГ ӨСГӨХ НЬ

ЗАРЧИМ 4: ӨӨРЧЛӨЛТ АВЧИРДАГ УДИРДАГЧ

*“Үнэнээр тэднийг ариусгаач. Таны үг үнэн мөн. Та Намайг ертөнцөд илгээсний адилаар Би мөн тэднийг ертөнцөд илгээв. Тэд бас үнэнээр ариусгагдахын тулд Би Өөрийгөө тэдний төлөө ариусгана.”
Иохан17:17*

“Тэд нэг нэгэндээ – Замд Тэр бидэнтэй ярилцаж, Бичвэрийг бидэнд тайлбарлаж байхад нь зүрх маань шатаж байсан бус уу?” Лук24:32

ӨӨРЧЛӨЛТИЙГ ДОТРООС НЬ (ЗҮРХ СЭТГЭЛ)

Есүс загалмайд цовдлогдохынхоо өмнө нэлээд удаан дагалдагч нар болон ирээдүйд Бурханы гишгэсэн мөрөөр явах бүх дагалдагч нарынхаа төлөө залбирсан байдаг. Өөрт нь итгэсэн хүмүүсийг дэлхийд сайнмэдээг хүргэхээр илгээгдэхээс нь өмнө нь ариусгаж өгөөч хэмээн Эцэгээсээ залбирсан байдаг. Есүс ‘хийх’-ийн өмнө ‘оршин байх’ нь чухал болохыг мэдэж байв. Дагалдагч нар Агуу Захирамжийг биелүүлэх үйлчлэлээ эхлүүлэхээс өмнө Үнэний Үгээр дамжуулан Эцэгээр тусгаарлагдаж, сүнсээр өөрчлөгдөөсэй гэж Есүс хүссэн. Бурханы Үг бидний зүрхэнд шингэхэд гал адил шатдаг. Бурханы Үг хүний зан чанарыг шалган гялтгануулж, амьдралыг ариусгаж, бодлыг шинэчилдэг. Бурханы үг итгэгчдийн сүнс болон сэтгэлд нэвчдэг. Тийм ч учраас дээр Эммау орох замдаа үхлээс амилсан Христтэй таарсан дагалдагч нарын ярьсанчлан Бурханы үг тэдний зүрхийг шатааж байсан юм. Ариун Сүнсний хүч, Есүсийн эрх мэдлээр дамжин хэлэгдсэн Бурханы Үг сүнслэг удирдагчдын зүрхийг өөрчилдөг юм.

Удирдагч бэлтгэдэг үйлчлэлүүд, семинарууд, Библийн сургуулиуд голдуу удирдагчдын толгой ба гарт буюу илүү сайн сүнслэг удирдагч болгохын тулд мэдлэг, ур чадваруудад нь анхаарч ажилладаг. Христийн биед эдгээр зүйлс чухал бөгөөд тустай байдаг. Юунд анхаарал сулраад байна гэвэл сүнслэг удирдагчийн дотроос гарах өөрчлөлт буюу зүрхэнд явагдах сүнслэг өөрчлөлтөд анхаарахгүй байгаа юм.

ЗАРЧИМ 4: ӨӨРЧЛӨЛТ АВЧИРДАГ УДИРДАГЧ

Маш их мэдлэгтэй, мундаг чадвартай удирдагч хүн бизнес эсвэл үйлчлэлд нэлээдгүй хол явах л байх гэвч удирдагч хүний зүрхэнд болж буй дотоод өөрчлөлт л эргэн тойронд байгаа хүмүүсийн зүрхийг шатааж, тэднийг өөрчлөгдөх шалтгаан болж байдаг юм шүү дээ. Жинхэнээсээ өөрчлөгдсөн амьдралаас илүү сайнмэдээ рүү хүмүүсийн анхаарлыг татаж чадах зүйл цөөхөн байдаг.

Тарсын Саулд түүнийг Иудейн нийгэмд өндөр байр суурьт хүргэж нөлөө бүхий хүн болгох зүйлс буюу теологийн мэдлэг, удирдагчийн ур чадвар гээд бүгд л байсан. Гэвч Дамаск орох замдаа Есүстэй уулзах хүртлээ түүний зүрх сэтгэл огт өөрчлөлтийг мэдрээгүй байсан юм. Саул ч өөрчлөгдсөнөө хожим батлан харуулсан. Есүс Саулын нэрийг өөрчлөж түүний амьдралд шинэ дуудлага өгснөөс хойш эрс өөрчлөгдсөн үзэгдэл юм. Тийнхүү Паул өөрийн мэдлэг, ур чадвар, шинэчлэгдсэн зүрх сэтгэлээрээ дэлхийн хамгийн агуу сүнслэг удирдагчдын нэг болтлоо дуурсагдахуйц өөрчлөлт агуу зүйлсийг хийж чадсан сүнсний удирдагч хүн байсан билээ.

Таны зүрх сэтгэлийн тухайд ярья. Бурханы үгийг уншин, тунгаан бодох үед таны дотор шатдаг уу? Бусдаар дамжуулан зааж сургаж байгаа Бурханы үгийг сонсон суухдаа таны зүрх сэтгэл шатдаг уу? Бурханы Сүнс таны бодол санаа болон амьдралыг өөрчлөн хувьсгадаг уу? Эсвэл энэ дэлхий ертөнц таныг өөрчлөн хувиргахыг та зөвшөөрдөг үү? Та үйлчлэлээ ахиулан урагшилахдаа мэдлэг ур чадвартаа илүү түшиглэдэг үү, эсвэл таны зүрхийг өөрчилдөг Христтэй дотно харилцахаа илүүд тавьдаг уу?

Тухайн хүний хэн байх нь түүний үйлдлийг чиглүүлдэг. Бурхан эмэгтэйчүүд ба эрчүүдийн зүрх сэтгэлийг хардаг бөгөөд тэднээр дамжуулан хийх зүйлсээ тодорхойлдог. Жералд Хартис нэгэнтээ 'Есүсийг дагах зуураа хийдэг зүйлс маань үйлчлэл юмаа' гэж хэлсэн байдаг. (Ford1991) Энэ таны хувьд үнэн зүйл үү? Есүсийг дагах нь таны эрхэмлэдэг хамгийн чухал зүйл мөн үү? 'Намайг дага. Би чамайг хүмүүсийн загасчин болгоё.' гэсэн Есүсийн урилга одоо ч хэвээр билээ. Таны зүрхэнд ийм өөрчлөлт хийгдэхэд та бэлэн үү? Таныг юу хойш нь чангаана вэ?



АГУУ ЗАХИРАМЖИЙГ БИЕЛҮҮЛЭХ ШИНЭ ҮЕИЙН УДИРДАГЧДЫГ ӨСГӨХ НЬ

СОЁЛЫН НӨЛӨӨГҮЙ ӨӨРЧЛӨЛТИЙГ ХИЙ

Есүс Бурханы хаанчлал газар дэлхий дээр ирснийг зарлан тунхаглаад Хаанчлалын сайнмэдээ ба хаанчлалын зарчмуудыг зааж сургаж эхэлсэн билээ. Есүсийн сургаал зарчмуудыг сонссон хүмүүсийн хувьд тэдгээр нь тэдний соёл заншилтай нь үргэлж зөрчилдсөн, маргаантай асуудлууд болж сонсогддог байсан нь тодорхой байдаг. Хэдийгээр итгэлээр сонсч, үйлдсэн хүмүүсийн зүрх сэтгэлд өөрчлөлтүүд эхэлсэн байсан ч өөрчлөлт нь удаан үргэлжлээгүй мэт. Есүсийн авчирсан өөрчлөлт усны ундарга мэт хязгааргүй урсах горхи мэт аврагдсан зүрхнээс гарах өөрчлөлтүүд байх учиртай байв. Сонссон хүмүүст эдгээр гол горхи адил өөрчлөлтийн урсгал сүнслэг бас соёлын өөрчлөлтүүдийг авчрах ёстой байсан бөгөөд тийнхүү итгэгч нар Сайнмэдээг цааш нь түгээн тараах учиртай байв.

Есүс Өөрийн сүм чуулганыг нийгэмд амь амьдралыг өгөгч, соёл ахуйд уусчихгүй дархан цаазтай байлгахыг хүссэн ч сүм чуулган өөрсдийгөө нийгмээс тусгаарлаж, холдуулах болжээ. Уг нь нийгэмд сүм чуулганы нөлөө маш ихээр хэрэгтэй юм. Анди Крауч Culture Making хэмээх номондоо дуудлагадаа бүтээлчээр хандах тухай өгүүлсний дотор дэлхий дахины сүм чуулган соёлтой таван нийтлэг хэлбэрээр холбогддог болохыг тайлбарласан байдаг. Тодруулбал буруутгах, шүүмжлэх, хуулбарлах, ашиглан хэрэглэх мөн соёлыг бий болгох (Crouch2008). Сүм чуулганы нийгэм соёлтойгоо холбогддог дээрх арга барилуудаас эхний дөрөв нь нийгэм соёлдоо ямар ч өөрчлөлт авчирдаггүй хандлагууд юм. Удаан хугацаанд өөрчлөлт авчрах чадвартай ганц хандлага нь бол тав дахь буюу соёлыг бий болгох хандлага юм.

Анди Краучийн бодлоор Есүс Христийн чуулган нь буруутгаж шүүмжилдэг хандлага байнгын буруутгагч хандлагыг бүр мөсөн тогтоодог гэж үзсэн. Чуулган уг нь давс ба гэрэл байх үүрэгтэй атлаа өнөө үед өөрсдийгөө нийгэм соёлоос тусгаарлах болжээ. Өөрөөр хэлбэл, сүм чуулганууд оршин байгаа нийгэм соёлоо шууд дуурайж дагадаг. Ингэвэл итгэлийн хүрээлэл ба эргэн тойрны соёл ахуйгаасаа ялгагдах зүйлгүй болох билээ. Тийнхүү сүм чуулганууд нийгэм соёлдоо ууссанаар Бурханы хаанчлалын өөрчлөлт авчрах нөлөөг багасгаж байдаг. Краучийн батлан хэлснээр, хэрэв дэлхийн бүх сүм чуулганууд Есүсийн бий болгосоны адил шинэ соёлыг бий болгохоор шийдвэл бидний нийгэм соёлд урт хугацаанд маш том өөрчлөлтүүд бий болно.

Шинэ Үеийн удирдагчид шинэ соёлыг бий болгохыг туйлаас их хүсдэг. Дэлхий нийтэд нүүрлээд байгаа том том асуудлын зарим дээр нь шинэ санаанчилга гаргах хүсэл тэдэнд бий. Есүс Христийн чуулганд нийгмийн зарим шудрага бус байдал, зарим үндэстнүүд дэх хүлээн зөвшөөрөхөд ч хэцүү байдлыг өөрчлөх чадвар бий гэж хардаг бөгөөд Есүс Христийн хайр ба Сайнмэдээний хүчээр өөрчлөлтийг зөвхөн итгэгч нар авчирах үүрэгтэй ч гэж хардаг.

Глобал Адванс байгууллага маань сайнмэдээ, сүнслэг ба соёлын өөрчлөлтийг Миллениалчуудад эхлэн хүргэх, энтерпренерийн нийгүүлсэлийг Ариун Сүнс бидэнд өгнө гэж итгэдэг. Бид танай болон бусад чуулган, байгууллагуудад туслаж, Шинэ Үеийн Удирдагч нарыг Христийн элчин сайд болгон бэлтгэж, соёлыг өөрчлөгчид болгон бэлдэх хараа зорилготой. Агуу Захирамжийг биелүүлэгч дарааийн үеийн удирдагчдыг бэлтгэх Шинэ Үеийн Санаачилгад та нэгдэх үү?

АРИУН СҮНСЭЭР ӨӨРЧЛӨГД

Бурхан хэдийгээр тантай адил төлөвшсөн удирдагчдыг Шинэ Үеийн удирдагчдыг сүнслэг өөрчлөлтөд хүргэхийн тулд ашиглдаг ч мөнхийн өөрчлөлтийн жинхэнэ эх сурвалж бол Бурханы Ариун Сүнс билээ. Ариун Сүнс Пентекост баярын үеэр дагалдагч нарт цутгагдан өгөгдсөний адилаар, итгэгчдийг дотроос гадагш чилэлтэйгээр өөрчлөхийн тулд Ариун сүнсийг Есүс итгэгч нарт ч цутган өгсөн билээ.

Христэд итгэгч нарт Бурханы дуудлагыг харах чадвар өгөгдсөн (Алсын хараа)

Алсын хараа бол бидний итгэлийнхээ нүдээр харж чадах зүйлс юм. Эш үзүүлэгч Иоел Ариун Сүнс залуус ба хөгшдөд огт харж байгаагүй зүйлсээ харах чадварыг адилхан өгөх цаг ирээдүйд ирнэ хэмээн эш үзүүлсэн билээ.



АГУУ ЗАХИРАМЖИЙГ БИЕЛҮҮЛЭХ ШИНЭ ҮЕИЙН УДИРДАГЧДЫГ ӨСГӨХ НЬ

Тэдгээр зүйлсийг эрт цагт эш үзүүлэгчид ойроос харахыг хүсэн тэмүүлдэг байсан ч тэд зөвхөн итгэж найдан төсөөлөхөөс цаашгүй байв. Элч Петр ч бас тэнгэрэлэг илчлэлтээр Пентекостын өдөр хүмүүст харагдсан бүхэн эш үзүүлэгч Иоелийн зөгнөлийн биелэл гэдгийг тунхагласан. Христ дагалдагч нараа Сүнсний бэлгүүдээр зэвсэглэн хүчирхэгжүүлснээр тэд энэ дэлхий дээрх Бурханы хаанчлалын талаарх Түүний алсын харааг ойлгож чадсан. Тэрхүү алсын хараа нь сүр жавхлантай бөгөөд бүхнийг хамарсан байв. Энэ алсын хараа нь хаанчлалын сайн мэдээг бүх дэлхийд тунхаглаж, улмаар бүх улс үндэстэн, бүс нутаг, хэл, хот, овог аймгуудад Есүс Христэд итгэж Бурханы гэр бүлд үрчлэгдэн нэгдэх боломж олгох юм.

Итгэгч нарт Бурханы үнэнийг дамжуулах чадвар өгөгдсөн (Мэдээ)

Есүс Христ чуулганд Ариун Сүнсээ цутган алсын хараагаа өгснөөс гадна итгэгч нарт энэ дэлхийд түгээх мэдээг хүлээлгэн өгсөн. Пентекостын өдөр Сайнмэдээ үндэстнүүдэд сонсогдохоор суллагдсан.

“Тэр цагт тэнгэрийн доорх үндэстэн бүрээс сүсэгт иудейчүүд Иерусалимд амьдарч байж. Энэхүү чимээнээр үй олон цугларч, өөрсдийнх нь төрөлх хэлээр тэдний ярихыг сонсоод ихэд гайхжээ.” Үйлс 2:5-6

Тэд юу сонссон бэ? Лук Үйлс 2:11-д дээрх үгсийг шууд эш татсан: “... тэдний яриаг өөр өөрийн хэл дээр сонсоцгоолоо гэв!” Петр босон зогсоод Есүс Христ нас барж, оршуулагдан, дахин амилсан тухай Сайнмэдээг зоригтойгоор тунхаглаж байх үед мянга мянган хүн түүний урилгыг хүлээн авч, гэмшин, гэмийн уучлал ба Ариун Сүнсийг хүлээн авсан юм. Түүгээр ч зогсохгүй тэд өөрсдийн нөлөөллийн хүрээндээ Бурханы үнэнийг дамжуулах чадварыг ч бас хүлээн авсан.

Итгэгч нарт Бурханы дэлхийг өөрчлөх чадварыг өгсөн (Илгээлт)

Есүс дагалдагч нартаа, “Харин Ариун Сүнс та нар дээр ирэхэд та нар хүчийг олж, тэгээд Иерусалим, бүх Иудей, Самари тэр байтугай дэлхийн хязгаар хүртэл Миний гэрч болно гэв.” Үйлс 1:8

Пентекостын өдөр үндэстэн бүрээс ирсэн төлөөллийн сонссон тэрхүү мэдээ бол Есүс Христийн Сайнмэдээ бөгөөд өөрчлөлтийг авчрах хүчтэй энэ мэдээг бид Ариун Сүнсний тосолгоогоор дэлхийн төгсгөл хүртэл тунхаглах ёстой билээ. Есүс Христ бүх дэлхий рүү явж сайнмэдээг бүх үндэстэнд тунхаглаж, Эцэг, Хүү, Ариун Сүнсний нэрээр тэдэнд баптисм хүртээн, Түүний тушаасан бүгдийг сахин биелүүлэхийг тэдэнд зааж сургах томилгоог бүх үеийн бүх итгэгчдэд өгөөд зогсохгүй үүнийг хийх тэнгэрлэг эрх мэдлийг тэдэнд олгосон юм. Тэр Өөрийн оршихуйгаар, чуулганы дээр хязгааргүй ихээр, бялхтал цутгагдсан Ариун Сүнсээр дамжуулан бидэнтэй үргэлж хамт байх болно гэж амласан. Бидний амьдрал ба дамжуулж буй мэдээнд Түүний алдрын төлөө бусдын амьдрал, гэр бүл, орон нутаг, улс үндэстнийг өөрчлөх хүч байх болно гэж Тэр амласан.

ЭРГЭЦҮҮЛЭМЖ

1. Таны сүнслэг удирдлагын хэв маяг өөрчлөлтийг хэр их авчирж байгааг тодорхойлно уу? Таны дотор гарсан өөрчлөлт харьяалагддаг нийгэм, орчинд тань ямар өөрчлөлтийг авчирж байна вэ?
2. Танай чуулган эсвэл бизнес сүүлийн үед хүрээлэн буй ахуй соёл нийгэмдээ хэрхэн хандаж байгаа вэ? Та нийгмийн соёлыг шүүмжилсэн эсвэл буруутгасан байр сууринаас хандаж тэднээс өөрийгөө тусгаарлаж байсан уу? Эсвэл та нийгэм ба үндэстэндээ гэрэл ба давс болохуйц идэвхтэй оролцоотой амьдарч байна уу?
3. Танай чуулган болон бизнесийн ИрҮеийн удирдагчдыг Сайнмэдээнд зохистой соёлыг бий болгож, тийм соёлтой холбох боломжийг нээх ямар санал санаачилга орон нутгийн хэмжээнд авч хэрэгжүүлж болох вэ? Цаг гарган Шаардлагатай арга хэмжээ, Хэрэгжүүлэх хугацаа гэсэн хүснэгтэд тэдгээрийг бичээрэй.



АГУУ ЗАХИРАМЖИЙГ БИЕЛҮҮЛЭХ ШИНЭ ҮЕИЙН УДИРДАГЧДЫГ ӨСГӨХ НЬ

ЗАЛБИРАЛ

Тэнгэрт байгаа бидний Эцэг минь бидний дунд хаанчлалаа байгуулахын тулд Өөрийн Хүү Есүс Христийг илгээсэнд баярлалаа. Аль хэдийн ирчихсэн бөгөөд хараахан ирээгүй байгаа Таны мөнхийн хаанчлалд баярлалаа. Бид одоо Таны Хаанчлалыг зөвхөн урьдчилсан төрхөөр нь л харж байгаа ч удахгүй үүнийг бүрэн дүүрэн биеллээ олсон төрхөөр ирэхийг харах болно. Таны хаанчлал ирэх болтугай, Хүсэл тань тэнгэр дэх шигээ газар дээр биелэгдэх болтугай. Ааваа, бидний зүрхийг Сайнмэдээ ба мөнхийн Үгээрээ өөрчлөөч. Ариун Сүнсний бидний дотор эхлүүлсэн амийн усны гол бидний зүрхнээс халин гарч гэр бүл, орон нутаг, улс үндэстэнд маань хүрэх болтугай.

Та биднийг Хүүгийнхээ дүр төрхийн дагуу өөрчилсөөр байгаач. Ингэснээр бид энэ нийгэмд Христийн элчин сайд байж, шинэ соёлыг бүтээгч байх болтугай.

Амэн.

ШААРДЛАГАТАЙ АРГА ХЭМЖЭЭ	ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

ЗАРЧИМ 5: СҮНСЛЭГ УДИРДАГЧ

“Есүс Ариун Сүнсээр дүүрч Иорданаас буцаж цөлд Сүнсээр хөтлөгдөн, дөчин өдрийн турш диаволд соригджээ... Есүс Сүнсний хүч дотор Галилд буцаж ирэв.” Лук 4:1, 14

Сүнслэг удирдлагыг Есүс Христ өөрийн биеэр үлгэрлэн харуулсан. Лукын Сайнмэдээний ном дах дээрх эшлэлүүд нь Христийн удирдлагын гол мөн чанарыг товч бөгөөд тодорхой илэрхийлсэн байна. Тэгвэл энэ нь Түүний нэрийг үүрэн явж сүнслэг удирдлагын үүргийг залгамжих бүх хүний баримтлах жишиг юм.

2014 онд би Библийн энэ хэсгийг үндэслэн “Сүнсээр дүүрэн Аврагч” нэртэй дараах блогийг бичиж байлаа:

Бичвэрт бидний Аврагч энэ дэлхий дээрх үйлчлэлээ эхлэхдээ Ариун Сүнсий тосолгоо ба хүчээр дүүрэн илгээгдсэн гэдгийг тэмдэглэжээ. (Лук 4:1-19). Түүний энэхүү дотно харилцаа нь Хаанчлалын Сайнмэдээг тунхаглах ба Аавын хайрыг дэлхийд харуулах үйлчлэлийг нь тэтгэж байсан юм. Есүс бидний авралын төлөө “мөнх Сүнсээр өө сэвгүй Өөрийгөө Бурханд өргөсөн” билээ (Еврей 9:14). Элч Паул: “Учир нь Түүн /Христийн/ дотор Бурханы төгс дүүрэн нь бүхлээрээ биетээр оршдог” (Колоссай 2:9) хэмээн тунхагласан. Энэхүү төгс дүүрэн харилцаа нь Есүсийг цөлд сорилтыг даван туулж ялах үед, цэцэрлэгт шаналан зовох үед, загалмай дээр тарчлан байхад, дахин амилж ялалт байгуулах үед нь гол тулгуур нь болсон юм. Маш олон талаараа Есүсийн амьдрал биднийхээс хавьгүй илүү өндөр түвшнийх боловч нөгөө талаар бид Түүнийг даган дуурайх ёстой.



АГУУ ЗАХИРАМЖИЙГ БИЕЛҮҮЛЭХ ШИНЭ ҮЕИЙН УДИРДАГЧДЫГ ӨСГӨХ НЬ

Тэр бидэнд Түүний нэгэн адил хайрлаж, үйлчилж, яв хэмээн тушаасан. Тэр Түүний агуу амийг олохын тулд өөрийн амиа орхиж, загалмайгаа үүрч Түүнийг даган, Түүний үйлдсэнээс ч илүү агуу зүйлсийг хийх урилга бидэнд өгсөн. Гэсэн хэдий ч Тэр дагалдагч нартаа Иерусалимд үлдэж, итгэгчдийг дээрээс ирэх хүчээр дүүргэх Түүний амласан Ариун Сүнсний бэлгийг хүлээ гэж тушаасан (Лук 24:49; Үйлс 1:4-8). Бидний зүрх сэтгэлд нутаглаж, биднийг чадавхжуулдаг Ариун Сүнсний оршихуйгүйгээр чуулган Түүний хүсч байгааг хийж, Түүний хүссэн дүр төрхийг харуулах ямар ч боломжгүй юм. Элч Паул яагаад Ариун Сүнсний онгодоор итгэгчдийг Сүнсээр дүүрэн байж, Сүнсээр алх хэмээн ятгасан юм бол? Учир нь Есүс ч бас тийн үйлдсэн юм. Биднийг Есүсийг гэрчлэхийн төлөө, энэ дэлхий дээрх Эзэний энэрэнгүй гар хөл болж, бие биеэ хайрлаж, уучилж, босгон байгуулж, бие биедээ үйлчилдэг Түүний чуулган байхын тулд Түүний тушаалуудыг сахихдаа хараагаа Аврагч руугаа чиглүүлж, Түүний Сүнсээр дүүрэн бөгөөд Сүнсээр удирдуулдаг амьдралыг нь даган дуурай хэмээн ятгадаг. Үүнийг хэрхэн биелүүлэх вэ?

Тасралтгүй залбирангаа өөрийн хүслээс татгалзан, Ариун Сүнсний тэнгэрлэг удирдлагад амьдралаа өргөн даатгаж, бидний зүрхэнд нутагладаг Бурханы Сүнсэнд бүрэн захирагдвал үүнийг биелүүлж чадна. Есүстэй нэгэн адилаар Ариун Сүнсний удирдамжид бүрэн захирагдвал бид Сүнсээр дүүрэн Аврагчийнхаа алхсан мөрөөр алхахдаа Түүний нэгэн адил бүрэн дүүрэн байдлыг амсах болно. (Вэст, 2014).

Ихэнх сүнслэг удирдагч бид үргэлж сүнслэг хүн шиг мэдрээд байдаггүй гэдэгтэй санал нэгдэх байх. Үнэндээ бид заримдаа сүнслэг байдлаас огт өөр зүйлсийг мэдэрдэг. Учир нь бид бүгдээрээ өөрийн бодол, хүсэл, сул тал ба гэмт зуршлуудаа хэтэрхий сайн мэддэг. Хүмүүс бидний сүнслэг удирдлагыг сайшаан магтах үед өөрийн эрхгүй бусдыг мэхлээд байгаа мэт санагдах үе ч бий. Мөн бид Ариун Сүнсний удирдамжийн дагуу гэхээсээ илүү өөрөө бүхнийг хяналтандаа авчихсан яваагаа олонтаа анзаардаг.

Бидний үлгэрлэн дагахыг хүсдэг элч Паул ч хүртэл Ром 7:24-д “Би юутай хөөрхийлөлтэй хүн бэ! Хэн намайг үхлийн энэ биеэс ангижруулах вэ?” гэж өчсөн байдаг. Бид бүгдээрээ адилхан нөхцөлд байгаа. Гэсэн хэдий ч Сүнсний хуулиар дамжуулан биднийг ялаас чөлөөлсөн Бурхан магтагдах болтугай. Тийм учраас бид Ариун Сүнс бидний удирдлагын ур чадварыг чиглүүлж, дүүргэж, чадваржуулж, тосолж, үүнийг жинхэнэ сүнслэг болгож байгааг мэдэн Бурханы хүмүүсийг даруу зан, чин сэтгэл, итгэл ба баяр хөөртэйгөөр удирдаж чадна.

Манай үеийнхэн энэ цаг үед оршин буй шалтгаан нь сайнмэдээг илүү ахицтай тунхаглаж, Ариун Сүнсний удирдамж дор даяар чуулганыг сүнслэг удирдлагаар хангах юм. Мөн бид сүнслэг удирдлагын дараагийн үеийг босгон, тэдэнд итгэлээр, Бурханы Сүнсээр алхахыг заах үүрэгтэй.

Бид энэ чухал даалгаврыг яаж биелүүлэх вэ? Агуу захирамжийн дараагийн үеийн удирдагч холбогдож, тэднийг төлөвшүүлж өсгөхөд тань туслах таван үйл ажиллагааг би санал болгож байна:

АРИУН СҮНС БА ШИНЭ ҮЕИЙН УДИРДАГЧ НАРТАЙ ХАМТРАН АЖИЛЛА

“Антиох дахь чуулганд эш үзүүлэгч мөн багш нар байв. Тэднийг Эзэнд үйлчилж, мацаг барьж байх үед Ариун Сүнс

–Миний дуудсан үйлчлэлд Барнаб, Саул нарыг надад тусгаарлагтун гэв. Тэгээд тэд мацаг барин залбирч, тэдэн дээр гар тавиад, явуулжээ.” Үйлс 13:1-3

Антиохын чуулганы ахлагч нар үйлчлэлийн ажлыг сүнслэг удирдлагаар хангана гэдэг нь Ариун Сүнсстэй хамтрахын нэр гэдгийг ойлгодог байсан. Чуулганы хамгийн дээд удирдагч нь Ариун Сүнс бөгөөд Тэрээр дэлхий даяар Түүний авралын ажлыг гүйцэлдүүлэх хүч ба удирдамжаар хангадаг.

Даяар чуулганы бүх сүнслэг удирдагч нар Ариун Сүнсний удирдамжийг итгэл төгс дуулгавартай дагахаар дуудагдсан.

Энэхүү Библийн хэсэгт ахлагч нар Ариун Сүнсний удирдамжийн дагуу цаашдаа хэрхэн үйлчлэх талаар Ариун Сүнснээс заавар хүсэн магтаал өргөж, залбирч, мацаг барьж байсныг онцолсон. Чуулганы үйлчлэл нь амжилттай яваа эдгээр удирдагч нар ийнхүү даруугаар Бурханд бүрэн найдан түшиглэж байгаа нь бид бүгдийн суралцах ёстой үлгэр дуурайл мөн. Та болон танай чуулганы эсвэл бизнесийн удирдлагууд хамтдаа Бурханыг магтан бууж өгч, Ариун Сүнсний удирдамжийг хүлээх цаг хэр их гаргадаг вэ?



АГУУ ЗАХИРАМЖИЙГ БИЕЛҮҮЛЭХ ШИНЭ ҮЕИЙН УДИРДАГЧДЫГ ӨСГӨХ НЬ

Нөгөө талаас та өөрийн санаа, төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр зүтгэж байгаад сүүлдээ Ариун Сүнснээс төлөвлөгөөг минь ерөөгөөч гэж гуйх нь хэр их тохиолддог вэ?

Барнаб Саул нар дээрх үйл ажиллагаанд оролцсон ахлагч нарын дунд байсан. Тэднийг ердийнхөөсөө илүү урт хугацаагаар магтаж залбирч байх үед Ариун Сүнс тэдний амьдралд, тэдний чуулганд хандсан төлөвлөгөө ба дуудлагаа илчилсэн. Ариун Сүнсний удирдамжийг даруу хийгээд тэвчээртэйгээр эрэлхийлж, чуулганы түүхэн дэр хоёр агуу илгээлтийн эзнийг илгээхээр Ариун Сүнстэй хамтран ажилласан Антиох чуулганы ахлагч нарт Есүс Христийн Чуулган үүрд өртэй.

Хэрэв Бурхан танай чуулганы эсвэл бизнесийн ИрҮеийн залуу удирдагч нарт ч бас үүнтэй ижил зүйлийг төлөвлөсөн гэвэл ямар байна? Та нарын дунд шинэ ажилд хөл тавихаар Ариун Сүнсээр дуудагдсан Барнаб, Саул нар байж болохгүй гэж үү? Та Ариун Сүнс төлөвлөгөөгөө тодорхой илчилэх боломжтой сүнслэг үйл ажиллагаагаар багаа удирдан авч явахаас нааш үүнийг яаж мэдэх билээ?

Магадгүй танд Шинэ Үе удирдагч нарт зориулсан олон төлөвлөгөө байгаа бөгөөд Ариун Сүнснээс тэдгээрийг ерөөгөөч гэж гуйж байгаа байх. Та яагаад өөрийн төлөвлөгөө ба санаануудаа залбирал, магтаал, мацаг барилтаар дамжуулан Ариун Сүнсний удирдамжид өргөж болохгүй гэж? Хэрэв та Эзэнийг тэвчээртэй хүлээвэл Тэр танд төлөвлөгөөгөө илчлэн, хэн ирээдүйн удирдагч болохыг тодорхой болгож өгөх бөгөөд Түүний төлөвлөгөө ба зорилгуудтай нэгдэхийн тулд юу хийх

СҮНСЛЭГ ЭРХ МЭДЛИЙН СУУРИАС УДИРДАХ НЬ

“Самуелыг өсөж торниход ЭЗЭН түүнтэй хамт байж, түүний үгнээс нэг нь ч хөсөр хаягдсангүй. Самуелыг ЭЗЭНий эш үзүүлэгч мөн болохыг Данаас Беершеба хүртэлх Израиль даяар мэдэв. ЭЗЭН, Шилод үзэгдэж байсан бөгөөд Шилод Өөрийнхөө үгээр Өөрийгөө Самуелд илчилсэн юм.” 1 Самуел 3:19-21

38

Эзэн Самуелыг бүр бага настай үеэс нь Израйлын ард түмний сүнслэг удирдагч болгохоор тусгаарласан. Түүнд байсан удирдлагын болон үр нөлөөтэй харилцах чадварын эх сурвалж нь түүний амьдрал дах Эзэний оршихуй ба дуу хоолой юм.

Эзэн Самуелтай хүүхэд нас болон өсвөр насных нь туршид хамт байж хэмжээлшгүй эрх мэдлээрээ сүнслэг удирдлагын суурь болж байв. Эзэн Самуелын хэлсэн нэг ч үгийг, тэр ч бүү хэл түүний өсвөр насандаа хэлсэн үгсийг ч хүртэл хоосон, үр нөлөөгүй байлгаагүй. Израйлд Эзэний үг ховор байх үед Эзэн Самуелд үзэгдэн, үгээрээ дамжуулан Өөрийгөө түүнд илчилсэн (I Самуел 3:1). Бурхан ИрҮеийн удирдагчийг үндэстний сүнслэг удирдагч болгохоор урьдаас төлөвлөн, хайраараа халамжлан өсгөсөн. Эцэст нь Самуел үндэстнийхээ гарамгай удирдагч болсон. Самуелийн хувьд төлөвшсөн удирдагч байж чадсан сүнслэг эрх мэдлийнх нь эх сурвалж нь түүний албан тушаал, боловсрол, угсаа гарал бус харин түүний Бурхны дуу хоолойг сонсоод “Айлдаж хайрла. Боол тань сонсож байна.” (I Самуел 3:10) хэмээн хариулсан мөчөөс эхлэн насан туршид нь үргэлжилсэн Израйлын Бурхантай хувьчилан харилцах харилцаа байсан юм. Энэ хариултыг тэр сүнслэг аяныхаа туршид маш олон удаа давтан хэлж байсан гэдэгт эргэлзэх ч хэрэггүй буй заа. Самуел сүнслэг эрх мэдлийн сууриас удирддаг байсан.

“Эрх мэдлийн суурь” гэдэг үгийг анх “сүнслэг удирдлагын чадвар нь төрөлхийнх бус харин Ариун Сүнс тухайн хүний амьдралынх нь туршид хэмжээлшгүй эрх мэдлээрээ хүрч, ажилласаны үр дүнд энэ чанар төрөн гардаг” гэдэг санааг дэвшүүлсэн Ж.Роберт Клинтон бичсэн Удирдагч төрөн гарах онолд ашигласан байдаг. Клинтон эрх мэдлийн суурийг “хариуцлагын эх сурвалж, эрх мэдлийн давуу байдал буюу тухайн удирдагчийг дагалдагч нартаа нөлөөлөх эрх мэдэлтэй болгож буй нөөц бололцоо” гэж тодорхойлсон. (Клинтон, 1988). Тэр сүнслэг удирдлагын суурь хоёр төрөл байдаг гэж үзсэн.

Эхний төрөл нь байр суурийн хувьд олгогдсон эрх мэдлийн суурь юм. Энэ удирдагчийн хувьд эрх мэдэл, нөлөөлөл, хариуцлагын эх сурвалж нь түүний байгууллагадаа хашиж буй албан тушаалтай нь холбоотой байдаг. Хуучин гэрээний Саул хаан бол зөвхөн байр суурийн хувьд олгогдсон эрх мэдлийн сууриас удирдсан хүний жишээ юм. Эцэстээ түүний удирдлагын хэв маяг нь атаархал, айдас, сүрдүүлэг, түгшүүр, захиргаадалтаар тодорхойлогдох болсон.

Саул хаан эрүүл бус, айдас зовнилд хэт авсан удирдлагын хэв маягийг бий болгосон бөгөөд үүнээс нь болоод авьяаслаг удирдагч нар түүнээс холдон



АГУУ ЗАХИРАМЖИЙГ БИЕЛҮҮЛЭХ ШИНЭ ҮЕИЙН УДИРДАГЧДЫГ ӨСГӨХ НЬ

явж, түүнийг дагагсад нь айдас, түгшүүрт автах болсон. Саул бусдад итгэхдээ тааруу хүн байсан бөгөөд үнэнч албатууд нь түүний үйлдэл ба санал бодолтой өчүүхэн зөрчилдөх төдийд тэднийг өөрт нь үнэнч бус байна хэмээн буруутгадаг байв. Тэр ч бүү хэл хүү Ионатанаа Давидтай нөхөрлөсөнийх нь төлөө өөрөөс нь урвасан гэж буруутгадаг. Саул албан тушаалын дагуу олгогдсон эрх мэдлийн сууриа буруу ашигласанаас удирдагчийн хувьд маш том бүтэлгүйтэл амссан.

Хоёр дах нь сүнслэг эрх мэдлийн суурь бөгөөд тухайн хүний эрх мэдэл, нөлөөлөл нь түүний байгууллагад ямар байр сууринд байдгаас нь бус харин түүний амьдралд илэрхий харагддаг сүнслэг хүч эрх мэдлээс үүдэлтэй байдаг. Давид бол хоньчин хүү байж байгаад хожим нь Израйлын хаан болсон бөгөөд сүнслэг эрх мэдлийн сууринаас удирдсан нэгэн юм. Тэр бүр залуухан хүү байхдаа Израйлыг доромжлон сүрдүүлж байсан аварга Голиаттай нүүр тулан ялах үедээ энэ эрх мэдлийг харуулсан. Тэр өөрөөс нь хавьгүй өндөр, хүчтэй туршлагатай дайчинтай эрэлхэгээр тулах үедээ *“Давид филист хүнд –Чи илд, бамбай, жад барьж над уруу ирж байгаа бол харин би чиний доромжилсон Израилийн бүх цэргийн Бурхан, түг түмдийн ЭЗЭНий нэрээр чам уруу ирж байна.”* (1 Самуел 17:45.) хэмээн тунхагласан юм.

Эцэст нь Бурхан Давидад Израйлын хаан хэмээх өндөр эрх мэдэлтэй байр суурийг өгсөн бөгөөд Давид насан туршдаа нэг тохиолдлоос бусад бүх үед сүнслэг эрх мэдлийн сууриас улс орноо удирдсан билээ. Давид Израйлын армитай хамт дайнд явах ёстой байсан ч яваагүйгээс болоод Батшебатай завхайрч улмаар түүний нөхөр Уриаг алах хуйвалдаан зохиодог. Эндээс харвал тухайн үед Давид байр суурь дагасан эрх мэдлийн сууриас удирдаж байсан нь илэрхий. Энэ үед түүний удирдлагын суурь нь Ариун Сүнсний эрх мэдэл байхаа больсон байв. Тэр хааны байр сууриа ашиглан Батшебаг өргөөндөө дуудаж авчран завхайрсан бөгөөд Уриаг алуулах хуйвалдааныг удирдан зохион байгуулсан. Хэдийгээр Давид дараа нь Бурханаас уучлалыг хүлээн авч, сүнсээр сэргэсэн боловч энэхүү гамшиг дагуулсан шийдвэр нь зөвхөн Бурханы түүнд итгэж даатгасан удирдлагын байр суурийг завхруулаад зогсохгүй асар их үнэ төлөөс төлөхөд хүргэсэн.

Түүний амьдралд маш эмгэнэлтэй үр дагаварууд гарсан бөгөөд энэхүү үйл явдал нь түүний удирдлагын нөлөө хүчээ алдан аажмаар суларч уруудан буйг харуулсан дохио байв. Давид хааны амьдралын туршид байсан түүний агуу нөлөөлөл, хариуцлагатай чанар, эрх мэдлийн давуу байдал зэрэг нь Бурханы Сүнсээр Бурхантай нөхөрлөдөг дотно харилцаанаас нь ирдэг байсан.

Бурхан таныг байгууллагынхаа хэмжээнд эрх мэдэлтэй, нөлөө бүхий, хариуцлага өндөртэй албан тушаалд очихыг зөвшөөрсөн байж магадгүй. Бусдад нөлөө үзүүлэх болон ажил хэрэг явуулахдаа албан тушаалдаа хэт эрдсэн сонголт хийх амархан. Би таныг албан тушаалаасаа үл хамааран сүнслэг эрх мэдлийн сууринаас удирдаарай гэж зоригжуулмаар байна. Шинэ Үе удирдагч нарт сүнслэг удирдлагын ийм төрлийг үлгэрлэн харуулаарай. Энэ хоёр эрх мэдлийн суурь ямар ялгаатайг тэдэнд тайлбарлаж, буруу эрх мэдлийн сууриас удирдсан эсвэл үүнд уруу татагдсанаас болоод авсан сургамжуудаа хуваалцахад бэлэн байгаарай. Хэрэв та залуу удирдагч нар эрх мэдэл, нөлөө бүхий байр суурийн төлөө өрсөлдөн зүтгэж буйг харвал түүнд хайр дотор үнэнийг хэлээрэй. Тэднийг зүрх сэтгэл дэх сэдлээ шалгахыг даруугаар ятгаж, жинхэнэ эрх мэдэл хаанаас ирдгийг сануулаарай. Бурхан бүх цаг үеийн удирдагчдын санаж явбал зохистой үгийг Зехариагаар дамжуулан түүний Шинэ Үе удирдагч Зерубабелд хэлсэн. "...Хүч чадлаар ч бус, эрх мэдлээр ч бус, харин Миний Сүнсээр," гэж түг түмдийн Эзэн айлдаж байна." Зехариа 4:6.

ЗАЛБИРЛААР ХҮЧИРХЭГ БАЙХЫГ ҮЛГЭРЛЭН ХАРУУЛ

"Дараа нь Мосе Түүнд

—Хэрэв Таны оршихуй явахгүй бол биднийг эндээс бүү явуулаач. Эс тэгвэл би болон Таны ард түмэн мэлмийд тань тааллыг олсон нь юугаар мэдэгдэх вэ? Та бидэнтэй хамт явж байгаагаар бус уу? Тэгвэл би болон Таны ард түмэн бид газрын хөрсөн дээр буй бүх ард түмнээс ялгагдах юм гэв." Гэтлэл 33:15-16

NEXTGEN RISING

41



АГУУ ЗАХИРАМЖИЙГ БИЕЛҮҮЛЭХ ШИНЭ ҮЕИЙН УДИРДАГЧДЫГ ӨСГӨХ НЬ

Ялангуяа өөрийн залуухан шадар Иошуагийн өмнө. Иошуа юуны түрүүнд Мосе Бурхантай ямар ойр дотно харилцаатай болохыг анзаарсан. Мосе Синай уулан дээр Эзэнтэй ярилцан дөчин өдөр, шөнө болох үед Иошуа түүнтэй хамт байсан (Гэтлэл 24:13-18; 32:15-19). Амлагдсан газрыг тандахаар явсан тагнуулууд мэдээ авчирсны дараа Израйлын ард түмэн тэрслүү итгэлгүй зан гаргах үед Мосе, Арон нар Эзэний өмнө нүүрээрээ унахыг хараад Иошуа Мосег Бурханы өмнө даруу байж ард түмний төлөө зуучлан залбирч байгааг харсан. (Тооллого 14:5-6).

Мосе Израйлын Бурхантай дотно харилцаатай байж, Түүнтэй ярилцдаг байсан нь Иошуад гүнзгий нөлөөлсөн нь гарцаагүй. Энэ талаар Гэтлэл номд “Ийнхүү хүн анд нөхөртэйгөө ярьж байгаа мэт ЭЗЭН, Мосетэй нүүр нүүрээрээ тулан ярьдаг байлаа. Мосег хуаран уруу буцах болгонд харин түүнд үйлчлэгч залуу, Нуны хүү Иошуа майхнаас холддоггүй байв.” (Гэтлэл 33:11) гэж тэмдэглэсэн байна. Мосег явсны дараа майханд үлдэх ямар шалтгаан Иошуад байсан байж болох вэ?.

Зарим хүмүүс түүнийг майхныг хамгаалахаар үлддэг байсан гэж хэлж магадгүй. Тодорхой хэдэн шалтгааны улмаас энэ нь тийм ч үндэслэлтэй биш дүгнэлт юм. Нэгдүгээрт, уулзалтын майхан бол тусгайлан Эзэнд зориулсан ариун өргөө байгаагүй. Гэтлэл 33:7-д, “Мосе майхан авч, хуарангийн гадна, хуарангаас нэлээд зайдуу барьж, түүнийгээ уулзалтын майхан гэж нэрлэв.” Мосе тухайн үед ашиглаж болохоор байсан ямар ч хамаагүй нэг майхныг аваад Эзэнтэй нүүр нүүрээрээ тулан хоёулханаа уулзах газар болгосон гэдэг нь тодорхой байна. Тэр майхан нь энгийн нэг оромж, бусдыг зочлох хэрэгсэл байсан тул хүн ашиглаагүй үед бусдаас илүү онцлох үнэ цэнэтэй зүйл байгаагүй.

Хоёрдугаарт, Бурханы оршихуйд хэн нэгэн харгалзагч, хамгаалагч хэрэггүй. Тэр Өөрийн алдрыг Өөрөө хамгаалах бүрэн чадвартай бөгөөд мөнх бус зүйлсээр хамгаалуулах шаардлага Түүнд үгүй. Мэдээж Иошуа майханд үлдэх болсон хамгийн үнэмшилтэй шалтгаан нь тэр энэ майханд Бурхан Мосетой нүүр нүүрээрээ уулзаж байгааг мэдсэнтэй холбоотой юм. Магадгүй Иошуа Бурхан нэг өдөр түүнийг тэр майханд урин дотночлон уулзах байх гэж найдсан байх. Мөн тэр Бурханы оршихуйд аль болох ойрхон байхыг хүссэн байх. Мосег залгамжлах цорын ганц залгамжлагчийн хувьд Иошуа Мосе энэ ард түмнийг удирдахын тулд Бурханд залбирч, Түүний удирдамжид бүрэн түшиглэдэгийг сайн ойлгож байсан. Тиймдээ ч тэр менторынхоо үлгэр жишээг дагахыг хүссэн байх.

Мосе Бурхантай хамт байж байгаад ирэхдээ биеэс нь гэрэл цацарч байсан. Бурхан Мосег сонссон бөгөөд тэдний хооронд маш гүнзгий дотно нөхөрлөл байсан тул Тэр түүний гуйлтуудыг хүндэтгэн үздэг байсан. Эрхэм удирдагч та энэ тал дээр хэр байна даа? Тэнгэр дэх Аавтайгаа дотночлон хамт байсан цагийнхаа дараа сүнслэг дүр төрх чинь өөрчлөгдөж байна уу? Таны залбирлууд хариугаа авч, та залбирлынхаа үр дүнд өөрчлөгдөж байна уу? Шинэ Үеийн удирдагч нар та бидний үргэлж харуулдаг үлгэр дуурайллын үр дүнд илүү хүчтэй, үр нөлөөтэй залбирах аргад суралцаж байна уу? Бидний Бурхантай дотно харилцах харилцааг харсан залуу удирдагч нарт Христтэй дотно харилцах юмсан гэсэн хүсэл тэмүүлэл төрж байна уу?

Бүгдээрээ өдөр бүр Бурхантай илүү гүнзгий, илүү дотно харилцаж уулзахад зориулж шинээр “уулзалтын майхан”, залбирлын харанхуй өрөө, ариун газар, босгох шийдвэр гаргацгаая. Бүгдээрээ Шинэ Үеийн удирдагч нар биднийг дуурайхыг хүсэхүйц хэмжээнд тасралтгүй, хүчирхэг, өөрчлөлт авчирдаг залбирлын дадал хэвшлийг тэдэнд үлгэрлэн харуулцгаая.

СҮНСЛЭГ САХИЛГА БАТЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ, ДЭМЖДЭГ БАЙ

“Үүр шөнөөр Тэр босоод гадагш гарч зэлүүд газар очин, тэндээ залбирч байв.” Марк 1:35

“Тэр дөчин өдөр, дөчин шөнө мацаг барьсны эцэст өлсжээ” Матай 4:2

Есүс энэ дэлхий дээрх үйлчлэлийнхээ туршид сүнслэг сахилга батыг хэрэгжүүлсэн. Тэдгээрээс тодорхой жишээг дурдвал, ганцаараа байх, залбирах, мацаг барих зэрэг юм. Есүст сүнслэг сахилга батыг сахих олон шалтгаан байсан. Нэгдүгээрт, Тэр Тэнгэрлэг Аавтайгаа дотно харилцах цагийг хүсэмжилдэг байсан. Хоёрдугаарт, Тэр үйлчлэлийн хүнд хүчир нөхцөл, шашны удирдагчдын эсэргүүцэл, сүнсний ширүүн дайнд бэлэн байхын тулд эдгээр сүнслэг сахилга батуудыг ашигласан. Гуравдугаарт, Тэр хүнд хүчир үйлчлэл хийсэн эсвэл ширүүн эсэргүүцэлтэй тулгарсныхаа дараа Өөрийгөө дахин цэнэглэж, хүчээ сэлбэхийн тулд сүнслэг сахилга батыг хэрэгжүүлсэн.

Есүс дадгалдагч нартаа муу нэгэнтэй тулгарсан үедээ ялалт байгуулахын тулд сүнсээр бэлэн байх ёстой гэж заасан. Дагалдагч нар нь нэг удаа муу сүнсийг хөөн гаргаж чадахгүй байх үед Есүс тэнд оролцож чөтгөрийг зайлуулсан. Тэр үед дагалдагч нар нь яагаад тэд тэр муу сүнсийг зайлуулж чадахгүй байснаа Түүнээс сэмхэн асуухад, “Тэр, —Энэ төрөл нь зөвхөн залбирлаар л гарч чадна.” (Марк 9:29) гэсэн байдаг. Энэ хариултаас үзвэл, сүнслэг сахилга батыг сахиж байж л зайлуулахаас өөр аргагүй гүн суурьшсан, бат бэх сүнслэг цайзууд байдаг нь тодорхой байна. Есүсийн хариултаас Тэр сүнслэг эсэргүүцэлтэй тулгарах бүртээ цаг ямагт бэлэн байдаг шалтгаан нь эдгээр сахилга батууд гэдэг нь харагдаж байна.



АГУУ ЗАХИРАМЖИЙГ БИЕЛҮҮЛЭХ ШИНЭ ҮЕИЙН УДИРДАГЧДЫГ ӨСГӨХ НЬ

Амралтын өдрийг сахих сүнслэг сахилга батыг хэрэгжүүл хэмээн ухуулж ятгах шаардлагатай олон хүн өмнөх үеийн удирдагч нар дунд байдаг. Бид өөрөөсөө нэг долоо хоногийн дотор хийх ёстойгоосоо ихийг хийхийг шаардах нь элбэг. Үнэнийг хэлэхэд бид заримдаа цуглааны үйл ажиллагаа, арга хэмжээнд очихгүй бол хүмүүсийн урмыг хугалчих байх, байгууллагадаа зориулсан сэтгэлийн минь талаар бусад хүмүүс юу гэж ярих бол зэрэг айдас, бусдад үлгэр жишээ болохын тулд бусдаас илүү ажиллаж байгаа гэдгээ батлах хүсэл, бид ганц өдөр амарчихвал чухал үйлчлэл эсвэл бизнесийн үйл хэрэг амжилтгүй болчих байх гэсэн санаа зоволт зэрэг буруу сэдлээр ажиллаж байдаг. Сүнслэг удирдагч атлаа амралтын өдрийг сахих сахилга батыг сахихгүй байгаа олон шалтгаануудын зөвхөн заримыг нь л дурдахад ийм байна. Эдгээр шалтагуудын цаана ямар сэтгэл нуугдаж байж болох вэ? Бардамнал уу? Эсвэл хуурамч буруутгал уу? Ажлын дон уу? Эсвэл Бурханд болон бусдад итгэж чаддаггүй байдал уу? Хэрэв та ажлаасаа холдож, сүнс сэтгэл бие махбодын цэнэгээ нөхөх Шаббат өдрийг тогтмол гаргаж чаддаггүй бол эдгээр асуултуудыг өөртөө тавин эргэцүүлэх нь зүйтэй.

Марк Бучанан “Бурханы Амралт,” гэдэг номдоо ийнхүү бичжээ, “Саббат бол хүний төлөө бүтээгдсэн. Бурхан үүнийг бүр эртнээс төлөвлөж, бусад бүх өдрүүдийн эрч хүч буурсны дараа бүтээлийн хамгийн сүүлийн өдөр байхаар тогтоосон. Тэд заавал амрах ёстой байсан. Бурхан энэ өдөр бидэнд санаа тавьдаг байхаар бүтээсэн болохоос бид энэ өдөрт санаа тавих ёсгүй юм. Энэ нь биднийг өөрсдийн бий болгосон бүх эмзэг сул талууд ба Бурханы бүтээсэн гоо үзэсгэлэн ба асар их үнээр олж авсан эрх чөлөөн дунд маань, мөн Бурханы дүр төрхөөр бүтээгдэж Түүний гараар, цусаар нь чөлөөлөгдсөн эрэгтэй эмэгтэй хүний маань хувьд биднийг хамгаалж, үнэ цэнийг маань мэдрүүлж, эрхлүүлэх зорилгоор бүтээгдсэн.” (Бучанан 2006)

Өмнөх үеийн удирдагч нар Шинэ Үеийн удирдагчдад сүнслэг сахилга батын тал дээр ямар үлгэр дуурайлал үзүүлж байгаа вэ? Амьдралаа эрүүл хэмнэл, тэнцвэртэй авч явахын ашиг тус ба ерөөлийг илүү сайн ойлгоход нь тус болж байна уу? Бид тэдэнд сүнслэг сахилга батуудыг хэрэгжүүлснээр амьдрал ба үйлчлэлдээ хөгжин цэцэглэхийг зааж байна уу? Бид тэднийг сүнслэг тулаанд шаардлагатай зэвсгүүдээр **44** бүрэн зэвсэглэж байна уу? Сүнслэг сахилга батуудыг “заахаасаа илүү өөрийн биеэр харуулах” нь илүү үр дүнтэй. Шинэ Үеийн удирдагч нар өөрсдийг нь төлөвшсөн удирдагч болгохоор халамжилж байгаа хүмүүсийнхээ харуулсан эерэг үлгэр дуурайллыг харах ёстой.

СҮНСЛЭГ ЕРӨӨЛИЙГ ДАМЖУУЛ

Эцэгийн хамгийн анхны ерөөл Эхлэл 1-р бүлэгт *Бурхан эрэгтэй эмэгтэй хүнийг бүтээсний дараа тэмдэглэгдсэн байдаг. Тэр тэднийг ерөөгөөд, үржин олширч, газар дэлхийг дүүргэн, үүнийг эзэмшицгээ гэж тушаасан* (Эхлэл 1:28). Дараа нь их үер газар дэлхийг устгасаны дараа Бурхан Ноа болон түүний хөвгүүдийг ерөөж, тэдний өвөг эцэг Адамд өгсөнтэйгөө ижил тушаалыг тэдэнд өгсөн. Мэдээж хамгийн алдартай ерөөл бол Эхлэл 12-р бүлэгт гардаг Бурхан Абарахамд түүний үр удмыг үүрд ерөөнө гэсэн амлалт юм. Ерөөлийг өвлүүлдэг уламжлал Хуучин гэрээний туршид итгэлийн өвөг дээдсүүд, эш үзүүлэгч нар, тахилч болон хаадын амьдралд байсаар ирсэн. Арон болон түүний хөвгүүдэд тахилчийн үйлчлэлийн зааврыг өгч байх үед Эзэн Мосед Израйлчуудыг дараах үгсээр ерөө гэж хэлсэн: *"Чамайг ЭЗЭН ерөөж, сахин хамгаалах болтугай. Чиний дээр ЭЗЭН царайгаа гэрэлтүүлж чамайг өршөөх болтугай. ЭЗЭН чам уруу нүүрээ харуулж, Чамд амар тайвныг өгөх болтугай."* Тооллого 6:24-26. Мянга мянган жилийн дараа ч яг энэ ерөөлөөр дэлхий даяар чуулганууд итгэгчдээ байнга ерөөсөөр байгаа бөгөөд ерөөхдөө ч хүлээн авахдаа ч чин сэтгэлээсээ талархалтайгаар үйлддэг.

Энэ ерөөл нь нэг үеийн төлөөлөл дараагийн үедээ, эсвэл хайрын Бурхан сонгосон зарцдаа дамжуулж буй эш үзүүлэлийн чанартай хүчирхэг нөлөөтэй үйлдэл юм. Үүнийг өгч байгаа болон авч байгаа хүмүүс аль аль нь чин сэтгэлээсээ нухацтай хандан хүлээж авдаг. Ерөөж байгаа хүн нь ерөөгдөж байгаа хүний амьдралын ирээдүйг чиглүүлж Эзэний тусламж сайн сайханд итгэх итгэлийг бат суулгахад ерөөлийг ашигладаг бөгөөд энэ нь удирдлагын буухиаг дараагийн үедээ дамжуулан өгч байгаа гэсэн утга илэрхийлдэг.

Шинэ гэрээнд ч мөн энэ уламжлал үргэлжлэн гарсаар байдаг. Есүс уулан дээрх сургаалаа зааж байх үедээ дагалдагч нараа ерөөсөн. Түүн рүү ирсэн бяцхан хүүхдүүдийг Тэр ерөөсөн. Мөн Тэр Өөрөө баптисм хүртэх үедээ болон уулан дээр хувирах үедээ тэнгэрлэг Ааваараа ерөөлгөсөн. Элч Паул үйлчлэлийн хүүхдүүдээ болон өөр газар чуулган тарихаар хөдлөхөөсөө өмнө тухайн хот болгонд томилогдсон ахлагчдыг ерөөдөг байсан. .



АГУУ ЗАХИРАМЖИЙГ БИЕЛҮҮЛЭХ ШИНЭ ҮЕИЙН УДИРДАГЧДЫГ ӨСГӨХ НЬ

Удирдагчдын болон гэр бүлийн амьдралд ерөөл чухал байр суурь эзэлдэг байсан бөгөөд одоо ч байсаар байгаа гэдэгт эргэлзэх зүйлгүй.

Энэ гарын авлагыг уншиж байгаа зарим өмнөх үеийн удирдагчид хэзээ ч эцэг эхээрээ ерөөлгөж байгаагүй байж магадгүй. Зарим нь сүнслэг эцэг эхээсээ ерөөл хүртэж байсан удаагүй ч байж болох юм. Ийм байдлаас болоод хүмүүсийн сэтгэл шархалж гүн хүсэл хэрэгцээ нь хангагдалгүй үлддэг. Ерөөх ёстой үед ерөөхгүй байх нь хараахаас ялгаагүй сэтгэл өвтгөдөг. Биднийг яагаад ерөөлгүй үлдээснийг ойлгох амаргүй. Үйлчлэлд ч, бизнест ч заримдаа Шинэ Үеийн удирдагч нарт тэднийг ерөөлөөс гадуур үлдээгээд байгаа мэт сэтгэгдэл төрдөг. Тэд өмнөх үеийн удирдагч нар нь тэдний амьдралыг эш үзүүлэгийн, хүчирхэг үгсээр ерөөгөөсэй хэмээн хүсэмжилдэг. Тэд өмнөх үеийн удирдагч нар нь тэдэнд найдаж, цаг нь ирэхээр тэд ч бас удирдлагын буухиаг үргэлжлүүлж энэ үүргийг нэр төртэй авч явж чадна гэдэгт итгээсэй гэж хүсдэг.

Ирэх үеийнхнээ ерөөхөөс хойш суудаг шалтгаануудын ихэнх нь ямар ч үндэслэлгүй байдаг. Үндсийг нь ухаад харвал үүний цаад шалтгаан нь бидний тэр бүр хүлээн зөвшөөрөх дургүй хувиа хичээсэн зан маань байдаг. Өмнөх үеийн удирдагч нарт магадгүй бардам, байр сууриа алдах вий гэсэн айдас, аймхай, бусдыг хянах гэсэн хүсэл эсвэл Шинэ Үеийн удирдагч нар удирдлагын буухиаг үргэлжүүлж чадах эсэхэд эргэлзэх асуудал байдаг байх.

Удирдагч анд минь, та ямархуу байна вэ? Таны нөлөөллийн хүрээнд байдаг Шинэ Үеийн удирдагч нар дунд танаас сүнслэг ерөөлийг хүртэх зайлшгүй шаардлагатай хүн байна уу? Сүнслэг ерөөлийг дамжуулахад танд юу саад болж байна вэ? Бурхан таныг ашиглан хийлгэхийг хүсч буй зүйл, хэлэхийг хүсч буй үг, Агуу захирамжийн ирэх үеийн удирдагч нарт ерөөлийн гараа сунга хэмээн өдөөж байгаа зүйлс байна уу?

ЭРГЭЦҮҮЛЭМЖ

1. Лук 4:1, 14-ийг дахин уншаарай. Таны Ариун Сүнстэй харилцах одоогийн харилцаа Сүнсээр дүүрэн байж, Сүнсээр удирдуулж, Сүнсний хүчээр амьдардаг байсан Есүсийн дүр төрхийг тусган харуулж байгаа эсэхийг өөрөөсөө асуугаарай.
2. Эрх мэдлийн суурийн тодорхойлолт ба өмнө ярилцсан хоёр төрлийн удирдлагын эрх мэдлийн суурийн талаар эргэцүүлээрэй. Та одоогийн байдлаар албан тушаалийн дагуу өгөгдсөн эрх мэдлийн сууриас удирдаж байна уу эсвэл сүнслэг эрх мэдлийн сууриас удирдаж байна уу?
3. Та ганцаараа байх цаг, залбирал, мацаг барилт ба амралт зэрэг сүнслэг сахилга батуудыг хэр сахиж байгаа вэ? Эдгээр сүнслэг сахилга батуудыг сахиж, бусдад үлгэр дуурайл үзүүлэхийн тулд цагийн хуваарьтаа хил хязгаар тогтооход тань туслах ямар арга хэмжээг та авах хэрэгтэй вэ? Энэ талбарт өсөхийн тулд та юу хийх шаардлагатай вэ? Дараах хэсэгт тэдгээрийг бичиж тэмдэглээрэй.

ЗАЛБИРАЛ

Тэнгэрлэг Эцэг минь, Таны Хүү Есүс Христ сүнслэг удирдлагын төгс загварыг бидэнд үлдээсэн. Түүний удирдлагын хэв маягийг би дуураймаар байна. Миний амьдрал болон гэр бүлд Түүний үзүүлсэн нөлөөллийн төлөө талархъя. Сүнслэг удирдлагын сайн муу жишээнүүдийг Бичвэрт тэмдэглэн үлдээсэнд баярлалаа. Тэдгээрээс сургамж авч удирдлагын арга барилдаа тусгахад минь туслаач. Бусдыг албан тушаалын дагуух эрх мэдлийн сууриас биш харин сүнслэг эрх мэдлийн сууриас удирдахад минь туслаач. Таны хаанчлалын төлөө өөрийн хэмжээнд байж чадах хамгийн сайн удирдагч байхын тулд сүнслэг сахилга батуудыг хэрэгжүүлэх хүсэл эрмэлзлийг минь өрдөж өгөөч. Ааваа, хувиа хичээлгүй, бүрэн итгэлтэйгээр Шинэ Үеийн



АГУУ ЗАХИРАМЖИЙГ БИЕЛҮҮЛЭХ ШИНЭ ҮЕИЙН УДИРДАГЧДЫГ ӨСГӨХ НЬ

удирдагч нарт ерөөлийг дамжуулахад минь туслаач. Мөн тэднийг цаг нь ирэхээр хүлээн авах удирдлагын буухиагаа нэр төртэйгөөр үргэлжүүлэхэд нь бэлтгэхэд туслаач. Залбирлын амьдралыг минь үр нөлөөтэй, хүчирхэг байхад туслаач. Таны надад даатгасан Шинэ Үеийн удирдагч нарт залбиралд өөрийгөө зориулдаг амьдралыг үлгэрлэн харуулахад туслаач.

Амэн.

ШААРДЛАГАТАЙ АРГА ХЭМЖЭЭ	ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

ЗАРЧИМ 6: НИГҮҮЛСЭНГҮЙ УДИРДАГЧ

"Үг нь махбод болж, бидний дунд оршин, бид Түүний алдар сууг үзсэн. Энэ нь Эцэгээс цор ганц Төрөгчийн алдар бөгөөд нигүүлсэл ба үнэнээр дүүрэн юм."
Иохан 1:14


*"НИГҮҮЛСЭНГҮЙ УУР АМЬСГАЛ БА ХАРИЛЦААГ"
БИЙ БОЛГО*

Би "нигүүлсэнгүй уур амьсгал ба харилцаа" гэдэг үгийг анх Билл Фралл /Bill Thrall/, Брюс МкНиколь /Bruce McNicol/, Кен МкЕлраф /Ken McElrath/ нарын бичсэн Удирдагчийн өсөлт хөгжил: Эгэл харилцаагаар дамжуулан эгэл бус зан чанар ба нөлөөллийг бий болгох нь гэдэг номоос уншсан юм. Энэ номыг өмнөх үеийн болон Шинэ Үеийн удирдагч нар аль аль нь уншууштай сайн ном гэж зөвлөх байна.

Уг номыг зохиогчид, *"Ихэнх хүн нигүүлсэнгүй уур амьсгал орчинг хараад л шууд мэддэг"* гэжээ

Тэд үүний үр дүнг нь онцолсон: хүмүүс аюулгүй тайван байдлыг мэдэрдэг, өсдөг, бие биедээ итгэдэг, өөрөөрөө байдаг, бие биеийнхээ төлөө баярладаг, их инээдэг, илүү сайныг бүтээдэг ... хүмүүс илүү хүчирхэгжсэн мэт мэдэрдэг ...тэд 'энэ бол миний байх ёстой газар мөн' гэсэн найдварыг өгч сэтгэлд нь хөдөлгөх хүч болдог эерэг сүнсийг таньдаг." (Thrall, McNicol et al. 1999).

Тэд цааш үргэлжлүүлэн нигүүлсэнгүй уур амьсгал нь *"итгэл, бүтээлч чанар, найдвар болон бусад эерэг үр дүн гардаг соёлыг бий болгохын төлөө нигүүлсэнгүй харилцаатай мөр зэрэгцэн ажилладаг."* гэж тайлбарласан. Нөгөө талаас, "Нигүүлсэл үгүй орчинд хүн сайн сайхныг хүртэж, хайрлуулахын тулд байнга хичээл зүтгэл гаргах шаардлагатай болдог.



***Бусад итгэгч нартай
хамт аюулгүй орчинд
ажиллах боломж
олдсон нь надад
жинхэнэ ерөөл болсон.
(Эмэгтэй, Нас 31-35,
АНУ)***



АГУУ ЗАХИРАМЖИЙГ БИЕЛҮҮЛЭХ ШИНЭ ҮЕИЙН УДИРДАГЧДЫГ ӨСГӨХ НЬ

Ямар байдлаар нэг сул талтай хүмүүс бүгдээрээ хэт өндөр шаардлагыг хангаж чадаагүйгээсээ болоод сайн сайхан, хайр халамж хүртэж чадахгүй мэт санагдаж найдвар алдардаг.” (Thrall, McNicol et al. 1999).

Есүс дагалдагч нартайгаа хамт амьдарч үйлчилсэн гурван жилийнхээ туршид тэдний төлөө бий болгосон соёлтой энэхүү нигүүлсэнгүй орчин ба харилцаа нэлээд ойртож очдог. Бид энэхүү нигүүлсэл дүүрэн орчин ба харилцаа бодитоор бүрэлдсэн байгааг Шинэ гэрээн дээрээс Бетаны тосгоны Лазарын гэрт, сүмийн шүүх танхимд болон тосгоны синагогуудад, дээд өрөөн дэх нүүрсний галын дэргэд харж болно. Христийн бие дотор ажиллах соёл ба нийгэмшин амьдрах загвар болсон нигүүлсэнгүй орчин ба харилцааг Есүс бий болгосон. Дагалдагч нар өөрсдийгөө үнэ цэнэтэй, хайрлагдсан, тэдэнд итгэдэг, тэднийг байгаагаар нь хүлээн авч баярладаг гэдгийг мэддэг байсан. Есүсийн ойр тойронд байх үедээ тэд чин сэтгэлийн харилцаа ба нигүүлсэл дүүрэн уур амьсгалаас болоод өөрийнхөөрөө чөлөөтэй байж чаддаг байсан.

Иерусалимд байсан анхны чуулган бол чуулганы эрүүл соёлын гайхалтай жишээ юм. Хэдий төгс бус байсан ч энэ чуулган нигүүлсэл, үнэн сэтгэл, итгэл, бүтээлч зан, өгөөмөр зан, эрх чөлөө, найдвар ба хайр бүхий соёл ямар байхыг үлгэрлэн харуулсан. Элч ахлагч нар өөрсдөө Есүс Христтэй хамт байх үедээ сайн сайхныг нь амсдаг байсан тэрхүү нигүүлсэнгүй харилцаа ба уур амьсгалыг чуулганыхаа соёлын үндэс суурь болгосон.

Танай одоогийн соёл ямар байгаа вэ? Танай байгууллагын Шинэ Үеийн удирдагч нар байгууллагынхаа уур амьсгалыг юу гэж тодорхойлох бол? Тэд үүнийг айдас, захиргаадалт, алагчлал бүхий соёл гэж тодорхойлох болов уу? Эсвэл тэд нигүүлсэл бялхсан удирдлагатай соёл гэж батлан хэлэх болов уу? Би таныг байгууллагынхаа соёлын талаар Шинэ Үеийн удирдагч нартай үр дүнтэй сайн ярилцах цаг гаргаарай гэж зоригжуулмаар байна. Тэднийг ажиглалт дүгнэлтээ илэн далангуй шударгаар хуваалцахыг урь. Хэрэв хэн ч ямар ч санал хэлэхгүй, эсвэл бүгд ямар нэг зүйл хэлэхээс айсан мэт байвал энэ нь тэдэнд сөрөг дүгнэлт байгаа эсвэл тэд айж байна гэсэн

үг бөгөөд танай байгууллага “нигүүлсэл үгүй уур амьсгалтай” байх магадлалтай гэсэн үг. Байгууллагын уур амьсгал эрүүл байсан ч түүнийг сайжруулах боломж үргэлж байдаг бөгөөд та Шинэ Үеийн удирдагчдыг байгууллагынхаа хэмжээнд нигүүлсэнгүй харилцаа ба уур амьсгалыг бүрдүүлэхэд идэвхтэй оролцохыг уриалаарай.

Есүс нигүүлсэл ба үнэнээр дүүрэн байсан. Тэр удирдагчдын даган дуурайх ёстой үлгэр жишээг харуулсан. Хэрэв удирдагч нар нигүүлсэл ба үнэнээр дүүрэн байвал тэд Ариун Сүнсээр удирдуулан байгууллагынхаа хэмжээнд нигүүлсэнгүй харилцаа ба уур амьсгалыг бүрдүүлэхэд ашиглагдах болно. Бизнесийн орчин, боловсрол, шашин, урлаг, шинжлэх ухаан технологи, гэр бүл, засгийн газар гээд нийгмийн бүхий л зонхилох хэсгүүдэд хийгдэж буй Бурханы ажлуудыг нигүүлсэл ба үнэнээр дүүрэн гэхээс өөрөөр юу гэж тодорхойлох билээ.

ХОЁР ДАХ БОЛОМЖИЙГ ОЛГО

Бичвэрт тэмдэглэгдсэн миний дуртай хэсгүүдийн зарим нь хоёр дах боломжийн тухай түүхүүд юм. Аваасаа хоёр дах боломжийг авсан төөрсөн хүүгийн түүхэнд дургүй хэн байх билээ? Бид бүгдээрээ л Иохан Маркд сүнслэг удирдагч болох хоёр дах боломж олгосон түүхийг сонсох дуртай. Түүнд урам хугарч бууж өгөөгүй үеэл Барнабд нь талархъя. Завхайрч байгаад баригдсан эмэгтэйд Есүс хоёр дах боломжийг олгосон. Закхай ч бас хийсэн алдаагаа залруулах боломж хүлээн авсан бөгөөд хэдийгээр бидний хүссэн хэмжээнд талархалтай хүлээж аваагүй ч Ионад магадгүй хамгийн том хоёр дах боломж олдож байсан.

Мэдээж Бичвэрт гардаг хамгийн сэтгэл хөдлөм хоёр дах боломж бол Есүс Галил нуурын хөвөөн дээр Петрийг дахин босгож үйлчлэлд томилсон түүх билээ. Есүс баригдаж, Петр урвахаас хэдхэн цагийн өмнө үнэнч байж чадна хэмээн бахдалтай нь аргагүй хэлж байсантай нь харьцуулаад харвал Петрийн Есүсийг үгүйсгэсэн нь маш ноцтой хэрэг байсан. Алдаа нь том байх



АГУУ ЗАХИРАМЖИЙГ БИЕЛҮҮЛЭХ ШИНЭ ҮЕИЙН УДИРДАГЧДЫГ ӨСГӨХ НЬ

тусам түүний сүнслэг удирдагч хайр энэрлээрээ алдаатай нь тулан ажиллаж залуу удирдагчийг дуудлага, зорилгоо эргүүлэн олж авахад нь туслаж буй төгс жишээг эндээс харна. “Иоханы Симон оо, чи Намайг эднээс илүү хайрладаг уу? ... Хургануудыг минь тэжээ ... Хоньдыг минь хариул ... Хоньдыг минь тэжээ.” Иохан 21:15-17. Есүс нигүүлсэнгүй уур амьсгал ба харилцаан дунд гал асаан дагалдагч нараа хооллон, тэдэнтэй нөхөрлөөд дараа нь өөрийнх нь ажлыг үргэлжлүүлэх удирдагчийг томилох удирдлагын чухал үүргээ биелүүлсэн. Энэ бүхэн Петрийн сэтгэлийг маш их өвтгөж байсан ч чухамдаа түүнд яг хэрэгтэй байсан, дутагдаж байсан, ангаж цанган тэмүүлж байсан хоёр дах боломж юм! Бид бүгдээрээ л Петрийг сүнслэг удирдагчийн хувьд эргэж боссонд нь талархалтай ханддаг. Сүнслэг удирдагчдад хоёр дах боломж олгодоггүй байсан бол бидний чуулганы түүх ямар өөр байх байсныг төсөөлөөд үз.

Элч Паул маш ихээр хүндлэгдсэн нэгэн байсныг Бичвэрт тодорхой харуулдаг. Түүнд ч бас удирдагчийн хувьд алдаа дутагдалтай үе байсан. Тийм дутагдлынх нэг жишээ нь Иохан Марк гэдэг Шинэ Үеийн удирдагчид хоёр дах боломж олгоогүй явдал юм. Паулд ууч сэтгэл, уян хатан байдал дутмаг байснаас болоод тэр Ариун Сүнсний эхлүүлсэн харилцааг хагаралдахад хүргэсэн. “Миний дуудсан үйлчлэлд Барнаб, Саул нарыг надад тусгаарлагтун гэв.” Хэрэв элч Паул Барнабын үгэнд орж Иохан Маркд хоёр дах боломжийг олгосон бол тэр энэ дэлхий дээрх хамгийн шилдэг илгээлтийн эздийн багийг хадгалан үлдэж, Иохан Маркийн итгэл гайхалтайгаар өсөхийг таатайяа харж болох байв. Бурхан нигүүлслээрээ элч Паулд ч бас хоёр дах боломжийг өгсөн.

Эрхэм удирдагч таны хувьд ямархуу байна даа? Паул адил Шинэ Үеийн удирдагч нар алдах үед тэдэнд хоёр дах боломжийг өгөхөөс хойш сууж байна уу? Удирдагч нар замаасаа гажих үед тэднийг уучлалгүй, уян хатан бус хандаж байна уу? Барнабын үлгэр дуурайллыг дагаарай гэж би таныг зоригжуулж байна. Алдаа эндэгдэл, өөртөө итгэлгүй байдал, сул тал болон айдастайгаа тэмцэлдэж байгаа ирээдүйн удирдагч нарын доторх хараахан илчлэгдээгүй нөөц бололцоог олж хар. Та өөрөө удирдагчийн амьдралаар амьдрахдаа хэдэн удаа хоёр дах боломжийг хүлээн авч байснаа сана. Есүсийн жишээг даган төөрч яваа удирдагчдын асуудлыг хайр дотор шийдвэрлэж, тэднийг бататгаж дахин босгоорой.

52

Зарим зан авир тухайн удирдагчийг байгууллагын хэмжээнд хуучин албан тушаалд нь буцаан тавих боломжгүй хэмжээний үр дагавартай байдаг гэдгийг хэлэх хэрэгтэй байх. Үнэндээ тэд уур амьсгал болон одоогийн тогтсон соёлоос болоод байгууллага дотор үлдэх боломжгүй ч болж магадгүй.

Нигүүлсэл дүүрэн соёлын хувьд үүнийг дүрэм журмын дагуу гэхээс илүү онцгой тохиолдол гэж тооцох нь зүйтэй. Нигүүлсэл, ялгах чадвар, ухаалаг зөвлөгөө хэзээ нэгэн цагт гарцаагүй тулгарах хүндхэн цаг үеүдэд зайлшгүй хэрэгтэй чухал зүйлс мөн. Таны удирдлагын үүргийн зарим хэсэг нь Шинэ Үеийн удирдагчдад аливааг шинээр эхлэх боломжтой нөхцөл байдал дунд үйлчлэлийн шинэ байр сууриа олоход нь туслах байж болох юм. Спортын ертөнцийн хэлц үгсийг амьдралд ашиглах дуртай хүмүүст хандаж хэлэхэд алдаа гаргасан удирдагч “шар карт” авсан байж болох ч Эзэн “улаан карт” өгөх нь маш ховор. Шинэ Үеийн удирдагчийг тоглолтод буцааж оруулахаасаа өмнө эргэцүүлэн бодох хангалттай цаг гаргаж, гэмээ өчиж, сэргээн босгох, зөвлөж, халамжлах ажил заавал хийхийг зөвлөдөг. Таны төлөвшсөн нөлөөлөл тэдэнд эргэн ирэхэд нь туслах бөгөөд амжилттай сайн удирдагч байхад шаардлагатай боломж бүрээр хангах болно.

ТӨЛӨВШӨӨГҮЙ БАЙДЛЫГ ТЭВЧ

Дагалдагч нар өөр хоорондоо хэн нь агуу болох талаар маргах үедээ сүнсээр төлөвшөөгүй гэдгээ харуулсан. Тэднийг маргалдаж, бусад дагалдагч нараас илүү агуу болох гэж тэмцэлдэж байгаагийнх нь төлөө загнаж зэмлэхийн оронд Есүс тэдэнд жинхэнэ агуу нэгэн байхын тулд юу хийх ёстойг зааснаар ярианы чиглэлийг нь өөрчилсөн. Тэр бяцхан хүүхдийг гар дээрээ өргөөд агуу байдлын тухай санаагаа тэдэнд заасан. Есүсийн сургаалийн дагуу Бурханы эдийн засгийн хувьд агуу байдалд хүрэх зам бол хамгийн өчүүхэн нь байх чин сэтгэлийн хүсэл юм. Бурханы хаанчлалын хувьд сүнслэг удирдлагын тэргүүн эгнээнд хамгийн хурдан хүрэх зам бол бусад бүх хүнийг өмнөө оруулах юм. Есүс тэднийг эдгээр үнэнүүдийг тунгаан бодохыг хүссэн. Дагалдагч нар агуу болохыг хүссэн нь буруу зүйл биш. Тэд зүгээр л агуу байдлын тухай буруу ойлгож байсан. Есүс тэвчээртэйгээр тэдэнд зааж сургасанд талархууштай. Тэд сүнслэг удирдлагын талаар маш чухал зүйлийг сурсан.

Иохан 14-р бүлэгт Есүс дагалдагч нартаа хандан тэдэнд зориулан орон байр бэлдэхээр явж байгаа бөгөөд нэгэн өдөр эргэн ирж тэднийг шинэ гэрт нь аваачих болно гэж хэлэх үед Филип Түүнд, “Эзэн, бидэнд Эцэгээ харуулаач. Энэ л бидэнд хангалттай. гэхэд Есүс хариулсан, Би та нартай хамт ийм удаан байхад чи Намайг таньж мэдсэнгүй гэж үү, Филип ээ? Намайг харсан нь Эцэгийг харсан. Гэтэл “Бидэнд Эцэгээ харуулаач” гэж чи яаж хэлнэ вэ?” Иохан 14:9 Филипд өгсөн Есүсийн хариултаас үзвэл Филипийн үзэл бодол хараахан төлөвшөөгүй байсан нь илэрхий байна.



АГУУ ЗАХИРАМЖИЙГ БИЕЛҮҮЛЭХ ШИНЭ ҮЕИЙН УДИРДАГЧДЫГ ӨСГӨХ НЬ

Заримдаа Шинэ Үеийн удирдагчдийг өсгөж байх үед танд тэд таны туршлага, ухаанаас суралцан, таны зааж, үлгэрлэн харуулж байгаа зүйлсийг маш сайн ойлгож байгаа мэт санагддаг. Гэтэл үе үе тэдний төлөвшөөгүй зан ил гарч ирэх үед танд “Чи надаар тоглож байгаа байлгүй дээ! Энэ талаар бид мянган удаа ярилцсан шүү дээ! Чи аль хэдийн үүнийг өөрийн болгоод бид цааш нь явж байгаа биш билүү! Миний хэлж байгаа үгийг чи сонсож байна уу? Энийг ойлгочих арай дөнгүүр шинэ дагалдагч олж авах минь!” гэсэн бодол төрж ч магадгүй.

Төрөн гарч буй Шинэ Үеийн удирдагчдыг халамжлах ажил таны тэвчээрийг шалгаж ч болох юм. Паул залуухан пастор Тимотод ямар ч нөхцөлд сэрэмжтэй бэлэн байхыг сануулсныг санаарай. Тэдэнд ашиглаж болох маш их авьяас чадвар, нөөц бололцоо байдаг ч төлөвшөөгүй байдлаас нь болоод бид тэдний бага багаар өсөж хөгжиж байгааг олж харж чадахаа больчихож магадгүй. “Уужим сэтгэлээр, сургаалаар сэнхрүүл зэмлэ, урамшуул.” 2 Тимот 4:9.

Төлөвшөөгүй байдлаас болж үе үе тохиолддог бухимдал гутрал нь мөнхийн үр дүнд хүргэхүйц үнэ цэнэтэй зүйлийн төлөө төлөх л ёстой зүйл юм. Тиймд урам хугаралгүй, тэвчээртэй байгтун. Шинэ Үеийн удирдагч нар ч бас хуучин удирдагч нартай харилцахдаа үе үе тэдний гаргадаг уян хатан бус байдал, аливааг хийхдээ удаан хойрго байдлаас нь болоод тэвчих шаардлага гардаг гэдгийг санаарай. Тэгэхээр энэ бол харилцан тэвчиж, хүчээ нэтгэх ёстой хамтын аялал юм.

ЦАГАА ОЛСОН, УРАМ ӨГСӨН САНАЛ ДҮГНЭЛТ ХЭЛЖ БАЙ

“Элч нар эргэж ирээд, өөрсдийн хийсэн бүхнээ Түүнд тайлагнав. Тэгээд Тэр тэднийг дагуулан Бетсайд хэмээх хотыг зүглэж хэдүүлхнээ явлаа...” Лук 9:10

Есүс дагалдагч нартаа Бурханы хаанчлалыг тунхаглах, өвчинг эдгээн чөтгөрүүдийг зайлуулах эрх мэдэл, хүч чадлаа өгч тэднийг илгээлтээр явуулсан. Тэр тэднийг эргэн ирэх үед нь туулсан зүйлсийнх нь талаар дэлгэрэнгүй тайлан сонсох гэж цагаа үрсэнгүй. Харин тэр даруй тэднийг дагуулан Бетсайда руу сүнсийг нь сэргээж амраахаар авч явсан. Хэдийгээр олон түмэн тэднийг тэр дор нь олж төлөвлөсөн амралтыг нь эрт дуусгасан боловч энэ үйл явдлаас сүнслэг удирдагч нь цагаа олж урам өгсөн дүгнэлт, хариу үйлдэл хийхээр хичээж байгааг харж болно. Түүний даалгасан ажил нь тэдний хамтарсан удирдлага, итгэл, зоригийг шалгасан. Тэд хийсэн зүйлээсээ юу сурсныг бататгаж дүгнэх нь чухал байсан. Сайн багш, халамжлагч нар заах тохиромжтой мөчийг зөвхөн баярлаж тэмдэглэхийн тулд төдийгүй суралцах явцыг бататгахын тулд алдалгүй ашигладаг.

Агуу захирамжийн ирэх үеийн удирдагчдыг бэлтгэхийг эрмэлзэж буй өмнөх үеийн удирдагч таны эрхэм боломж, үүрэг хариуцлага болсон зүйл бол Шинэ Үеийн удирдагчдийн удирдлагын ухаан, итгэл, эр зоригийг шалгах даалгаваруудыг өгснөөр тэдэнд заах юм. Тэднийг байгаа хэмжээнээс нь татаж сунгах хэрэгтэй бөгөөд тэд таны заасан зүйлсийг бататгаж сурахын тулд сурснаа бодит амьдрал дээр хэрэгжүүлдэг байх ёстой. Удирдагчдыг хөгжүүлэхийн тулд нарийн төлөвлөж үүнийхээ дагуу алхам хийдэг чанар тодорхой хэмжээгээр байх шаардлагатай бөгөөд та тэдний сэтгэл ба оюунд нь сурсан зүйл нь шинэхэн байгаа дээр дараагийн арга хэмжээнүүдийг хурдан хурдан авч сурах хэрэгтэй болно.

Шинэ Үеийн удирдагчдаар таны тэдэнд өгсөн үйлчлэлийн даалгавар бүрт тэмдэглэл хөтлүүлээрэй. Ингэвэл тэд өдөр тутам туулсан ба эргэцүүлж бодсон зүйлсийнхээ талаар үнэн зөв тайлан өгч чадна. Амжилт болон шинэ зүйл сурсныг нь заавал тэмдэглэн өнгөрүүлж бай. Шаардлагатай бол дахин чиглүүл. Гэхдээ хэт шүүмжлэлтэй хандахаас сэргийлээрэй. Бүх л удирдагч хийж үзэж байж сурдаг бөгөөд заримдаа туршлага дутсанаас болж бүтэлгүйтэх, боломжоо алдах үе байдгийг санаарай. Ихэнх тохиолдолд хор уршиг нь үүр үргэлжлээд байдаггүй. Суралцах, хийж үзэх, эргэцүүлэн тунгаах, дасан зохицох нь насанд хүрсэн хүмүүсийн аливаад суралцах үйл явцын нэг хэсэг гэдгийг санаж явах нь чухал. Та одоогийн удирдлагын хэв маягийнхаа талаар бодож үзээрэй. Шинэ Үеийн удирдагчид ажил даалгахдаа та хэрэгтэй үед нь ашигтай зөвлөгөө, урам зориг, зохистой санал дүгнэлт өгөх тал дээр хэр санаачилгатай, алсын бодолтой ханддаг вэ? Та дагалдах арга хэмжээг хурдан авсандаа хэзээ ч харамсахгүй ээ.

ЭРГЭЦҮҮЛЭМЖ

1. Таны одоогийн байгаа орчны ажилчдын дунд хэрэгждэг соёлыг тодорхойлоорой? Та үүнийг “нигүүлсэнгүй уур амьсгал ба харилцаа” гэх үү эсвэл захиргаадалт, айдас, сүрдүүлэг, тусгаарлагдсан орчин гэх нь зохистой байна уу? Танай ажилчид одоогийн уур амьсгалыг эрүүл гэх болов уу эсвэл эвдэрсэн гэх болов уу? Тэд таны дэргэд байхдаа иймэрхүү асуултад хариулахаас эмээдэг үү? Та тэдний хариултаас айдаг уу?



АГУУ ЗАХИРАМЖИЙГ БИЕЛҮҮЛЭХ ШИНЭ ҮЕИЙН УДИРДАГЧДЫГ ӨСГӨХ НЬ

2. Таны нөлөөллийн хүрээнд байгаа Шинэ Үеийн удирдагч нар дунд танаас хоёр дах боломж эсвэл сүнслэг ерөөл хүлээн авах шаардлагатай байгаа хүн байна уу? Тэдний энэ хэрэгцээг хангахад тань саад болж байгаа зүйл юу вэ?

3. Шинэ Үеийн удирдагч нарт шинэ зүйл сургах ажил даалгах ба цагаа олсон санал дүгнэлт хэлж байх тал дээр та яаж илүү санаачилгатай идэвхтэй байх вэ? Тэдний удирдлагын ур чадвар, итгэл, эр зоригийг өсгөх үйлчлэлийн арга хэмжээнүүдийг төлөвлөх цаг гарга. Тэдэнд цагаа олсон, урам зориг өгөх санал дүгнэлт өгөхийн тулд дараагийн шатны уулзалт эсвэл амралт семинарыг төлөвлө. Доор буй Шаардлагатай алхмууд ба Гүйцэтгэх хугацаа гэсэн хүснэгтэд төлөвлөгөөгөө нарийвчлан тэмдэглээрэй.

ЗАЛБИРАЛ

Аваа, Ариун Сүнс байгууллагад маань "нигүүлсэнгүй уур амьсгал ба харилцаа" гэж тодорхойлогдохуйц удирдлагын соёлыг бий болгоосой гэж би сэтгэлдээ маш их хүсч байна. Эзэн минь, зөвхөн Та л зүрх сэтгэлийг өөрчилж чадна. Удирдлага доорх хүмүүсээ бие биедээ нигүүлсэл бялхсан чин сэтгэлийн хандлагаар харилцдаг болгон дагуулахад минь туслаач. Аливаа айдас, сүрдүүлгийг зайлуулж, бусдыг хянан захирах гэсэн хүсэл бүрийг хөөн гаргаач. Урьд өмнө хэзээ ч амсаж үзээгүй эрүүл соёлыг цогцлооход бидэнд туслаач. Аваа, Таны Хүү Есүс Түүнд итгэн даатгасан удирдагч нарт хэрхэг хандсантай адил бусдад хоёр дах боломж олгодог нигүүлсэнгүй сэтгэл ба төлөвшөөгүй занг тэвчих тэвчээрийг надад өгөөч. Бидний соёл энэ дэлхийн хэв маягаас илүү Таны мөнхийн хаанчлалын үнэт зүйлсийг тусган харуулдаг байгаасай гэж би хүсч байна. Энэ бүхнийг би Таны Хүү Есүсийн нэрээр залбирлаа.

Амэн.

ШААРДЛАГАТАЙ АРГА ХЭМЖЭЭ	ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА



АГУУ ЗАХИРАМЖИЙГ БИЕЛҮҮЛЭХ ШИНЭ ҮЕИЙН УДИРДАГЧДЫГ ӨСГӨХ НЬ

ЗАРЧИМ 7: ХҮЧИРХЭГЖҮҮЛДЭГ УДИРДАГЧ

“Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Надад итгэдэг нь Миний хийдэг үйлсийг бас хийх бөгөөд эдгээрээс агуу ажлуудыг ч хийх болно. Учир нь Би Эцэгтээ очно.”

Иохан 14:12

Есүс арванхоёр дагалдагчаа хүчирхэгжүүлсэн. Гурван жил эрчимтэй сургасаны дараа Тэр тэднийг нэгэн өдөр Түүний хийж байгааг одоо харж байгаагаасаа ч илүү агуу зүйлсийг хийх болно хэмээн зөгнөн хэлдэг. Мэдээж тэдгээр “агуу зүйлсийн” эх сурвалж нь Есүсийн эрх мэдэл, Ариун Сүнсний өгөх хүч байх болно. Есүс Агуу захирамжийг биелүүлж, Өөрийнх нь чуулганы төрөлт ба өсөлтийг хариуцах үүргийг элч нартаа болон тэдний мөрийг даган явах бүх дагалдагч нарт даатган үлдээхээр анхнаасаа төлөвлөж бэлтгэж байсан. Сайнмэдээний үйлчлэл ба сүнслэг удирдлагын хөгжил нь хүнийг хүчирхэгжүүлэх тухай ойлголт юм. Удирдагчдыг бэлтгэхийн эцсийн зорилго нь тэд бидний ерөөл ба хувирашгүй дэмжлэгтэйгээр удирдлагын үүргийг биелүүлэхэд бэлэн болж, зөв цаг нь ирэх үед тэднийг үйлчлэл рүү илгээх юм. Өмнөх үеийн удирдагчдын зарим нь Шинэ Үеийн удирдагчдыг бэлтгэх үүргийг сөрөг өнцгөөс харж, үүнийг онцгой завшаан гэхээс илүү үйлчлэлийн хүнд дарамт ачаа гэж үздэг нь гайхмаар. Энэ материал тиймэрхүү үзэл бодлыг өөрчлөх байх гэж найдаж байна.

Манай пастор гайхалтай хүн. Тэр Бурханы надад өгсөн алсын харааг хүчирхэгжүүлэхэд минь туслахыг нэн тэргүүний чухал зүйл гэж үздэг. (Эмэгтэй, Нас 26-30, АНУ)

Матайн сайнмэдээнээс бид удирдагчдыг хүчирхэгжүүлсэн түүхийг харж болно. Матай 14:15- 16-д *“Орой болоход шавь нар нь Түүн дээр ирж, –Энэ газар зэлүүд мөн цаг хэдийнээ оройтжээ. Хурсан олныг тараан явуулаач. Тэд тосгодод очиж, өөрсдөдөө хоол хүнс худалдаж авцгааг гэцгээв. Харин Есүс тэдэнд, –Тэд явах хэрэггүй. Та нар тэдэнд идэх юм өг”*

Хэрэв Есүс дагалдагчдын гаргасан санааг дэмжиж хурсан олныг тараан явуулсан бол юу болох байсан бэ? Асуудал ямар ч байсан шийдвэрлэгдчих байх. Мянга мянган хүн хоосон ходоодтой буцаж тэдний өлссөн ходоодыг цатгах боломжтой цөөхөн хэдэн дэлгүүр, айл олдох л байсан байх. Магадгүй зарим нь хэдэн өдөр өлсгөлөн явж эцэст нь нэг юм төрсөн нутагтаа хүрэх байсан ч байж магадагүй. Нөгөө талаас, хэрэв Есүс ер бусын хүч чадлаараа тэдний гэдсийг цатгалан болгож тэр оройдоо гэр рүү нь явуулсан бол яах вэ? Бүгд сэтгэл хангалуун гэртээ харьж, дагалдагч нар ч бас хүмүүсийн хэрэгцээний талаар Есүст хэлж сануулсан гээд өөрсдийнхөө талаар таатай сэтгэгдэлтэй байх байсан биз. Гэхдээ л тэгсэн бол тэд өнөөгийн итгэгчдийг ч гайхшруулсаар буй бялхам дүүрэн Бурханы хангамжийн гайхамшигт биечлэн оролцох боломжоо алдах байсан.

Харин Есүс дагалдагч нартаа Бурханы бялхсан хангамжид итгэхэд нь туслах гүн утга учиртай хичээлд сууж, суралцах үнэ цэнэтэй боломж олгосон юм.



***“Манай Камерунд ихэнх хүмүүс “өөрчлөлт”ийг хүлээж авахдаа тааруу, аливааг хуучин аргаараа хийхийг илүүд үздэг тул энэ нь шинэ санаачилгыг өсөж хөгжихөд маш хүнд удаашралтай болгодог.”
(Эрэгтэй, Нас 18-25, Камерун)***



АГУУ ЗАХИРАМЖИЙГ БИЕЛҮҮЛЭХ ШИНЭ ҮЕИЙН УДИРДАГЧДЫГ ӨСГӨХ НЬ

Хүний байр сууринаас харвал дагалдагч нарын хувьд цөөн хэдхэн хүнээс илүүг хооллох ямар ч боломжгүй байсан. Харин Есүс тэднийг дундаасаа түүж цуглуулсан багахан нөөцөөрөө хүмүүсийг хоолло гэж тушаасан. Хэдэн мянган өлсгөлөн хүн юу юугүй тулаад ирчихсэн байхад тийм жоохон хүнс олж Есүст авчрах тэдэнд ямар ичмээр байсан бол? Эсрэгээрээ, Есүс тэдний өргөлийг хүлээн авч гайхамшгаа үйлдэн үүнийг хоосон ходоод бүрийг дүүргэхэд хангалттай хүрэлцээд илүү гарахаар их хоол болгох үед тэд ямар их баярласан бол?

Дагалдагч нар сагсаа үлдэгдэл талх ба шарсан загасаар дүүргэх үед энэ онцгой өдрийн нар жаргахтай зэрэгцэн тэдний итгэл хэр их тэлж Бурханыг мэдэх мэдлэг нь хэр гүн болсныг бид зөвхөн төсөөлж л чадах юм. Тэр өдөр тэд аливаа зүйлсийг боломжтой гэж харж чаддаг болсон байх. Хэрэв Есүс таван талх, хэдхэн жижиг загасаар хэдэн мянган өлсгөлөн хүнийг хооллож чадсан юм бол бидний Түүнд өргөсөн амьдрал, итгэлийн энгийн алхмыг ашиглан ямар агуу зүйлсийг хийх бол?

Бурхан таныг Шинэ Үеийн удирдагчдын итгэлийг өсгөж, таамаг эргэлзээг нь арилгахад ашиглахыг хүсдэг. Сүрдмээр хэцүү асуудлуудыг хэрхэн шийдвэрлэхийг та өөрөө хийж харуулах биш харин тэдэнд өөрсдөд нь даатган шийдвэрлүүлэх хэрэгтэй.

Тэд тухайн үедээ нэг их чухал ач холбогдолгүй мэт санагдах ч Бурханы аль хэдийн хангачихсан байгаа нөөц бололцоог эрэлхийлж сурах ёстой. Тэд хүмүүсийг хангаж, ерөөхийн тулд Бурханы хийж буй гайхамшигт гар бие оролцохыг хүсэн тэмүүлдэг. Та тэдэнд Бурханы хаанчлалын төлөө түүхэн зүйл хийх боломж олгож байна уу? Та тэднийг эрсдэлтэй алхам хийж, Бурханд итгэ хэмээн зоригжуулж байна уу? Бурхан аливааг боломжтой гэж хардаг удирдагчдын эрин үеийг босгохыг хүсдэг бөгөөд бидний үүрэг бол тэднийг энэ зорилгод хүрэхэд нь туслах юм.

ШИНЭ ҮЕИЙН УДИРДАГЧДЫГ ӨМГӨӨЛ

- 60** Агуу захирамжийн ирэх үеийн удирдагчдыг хүчирхэгжүүлэх ажлыг хийхдээ өмнөх үеийн удирдагч юунаас эхлэх ёстой вэ? Бидний залуучуудаас авсан судалгаанаас үзэхэд даяар чуулганы удирдлагын үе хоорондын зөрүүтэй холбоотой тэдэнд тулгардаг тэдний томоохон хэрэгцээний нэг нь өмнөх үеийн удирдагч нар энэ үеийнхнийг ойлгож, харилцахад нь туслах өмгөөлөгчтэй байх гэжээ.

Бүгдээрээ үүнд чин шударга байцгаая. Өмнөх үеийн бараг хүн бүр 18-35 насны шинээр гарч ирж байгаа залуучуудын талаар ямар нэгэн байдлаар сөргөөр ярьсан яриаг сонссон эсвэл өөрөө тэнд оролцсон байж таардаг.

Хойд Америкийн хувьд Милинеиал эриний залуучууд ажлын ёс зүй муутай, ажлын цагаа тогтмол баримтлах тал дээр асуудалтай, хариуцлага шаргуу зан ихээр шаардсан ажилд томилоход найдваргүй зэрэг яриа түгээмэл байдаг. Милинеиалуудын талаар ярих үед “дүрдээ итгэсэн” гэдэг үгийг ашиглах нь элбэг. Тэднийг заримдаа тогтворгүй, хувиа хичээсэн, дураараа, залхуу зэрэгээр цоллоно. Гэхдээ эдгээр тодорхойлолтод харъяалагдах насанд хүрэгчид ч байгаа нь гарцаагүй шүү дээ. Энэ чанарууд зөвхөн нэг үеийнхэнд хамааралтай биш. Үнэнийг хэлэхэд бүтэн нэг үеэр нь дүгнэхэд энэ нь тийм ч шударга үнэлгээ биш бөгөөд шулуухан хэлэхэд үүнээс болоод тэдэнд муу нөлөө үзүүлж байна.

Ер нь залуучуудын ертөнцийг үзэх үзэл, чухалчлах зүйлсийн эрэмбэ, үнэт зүйлс, итгэл үнэмшил нь өмнөх ахмад үеийнхнээсээ ялгаатай байдаг. Үүнийг түүхийн туршид байсан тоо томшгүй олон залуу үеийнхэн бүгд дуу нэгтэй хэлэх биз. Бид манай үеийнхэн л илүү дээр гэсэн үзэлд автахас сэрэмжлэх ёстой. Бидэнд ч бас Хойд Америкийн ажилд донтох хандлагаас авахуулаад материализм, консьюмеризм, индивидуализм гээд хангалттай олон асуудал бий.

Өмнөх үеийн удирдагчид Шинэ Үеийнийнхнийг энэ дэлхий дээр аливаад өөрөөр хариу үйлдаж байгаагаас нь болоод овлигогүй гэж дүгнэхийн оронд тэднээс суралцахад бэлэн нээлттэй хандлагатай байх нь зүйтэй. Шинэ Үеийн удирдагч нартай холбоо тогтооход тань тус болох хэдэн санааг би энд дурдъя. Тэдэнтэй чин сэтгэлээсээ ярилц. Тэд юунд итгэж, юуг үнэ цэнэтэй гэж хардагийг мэдэж ав. Соёл, улс төр, шашны талаар өөр санаатай байж, тэд аливааг өөрөөр тайлбарлахад нээлттэй ханд. Тэдний итгэл үнэмшил, үзэл бодлыг ойлгохгүй эсвэл санал нэгдэхгүй байсан ч тэднийг сонсоход бэлэн бай. Тэднийг гэртээ урьж хамт хоолло. Тэдэнтэй нийтлэг, ижил төстэй зүйлсийг хайж ол. Өөрийн амьдрал, түүхээ тэдэнтэй хуваалц. Тэднийг насанд хүрсэн хүн, тантай эрх тэгш нэгэн гэж ханд. Нэг үгээр хэлбэл тэднийг хүндэл.



АГУУ ЗАХИРАМЖИЙГ БИЕЛҮҮЛЭХ ШИНЭ ҮЕИЙН УДИРДАГЧДЫГ ӨСГӨХ НЬ

Хэрэв Бурхан ИрҮе удирдагч нарт Агуу захирамжийг даатган, Ариун Сүнсээрээ тэднийг хүчирхэгжүүлсэн бол бид ч бас Түүний удирдамжийг дагаж тэднийг Бурханы хүссэн хүмүүс болон өсөхөд нь туслаж, зоригжуулахын тулд хийж чадах бүхнээ хийх ёстой. Тэдэнд тэдний талд зогсож, тэднийг дэмжигч, дасгалжуулагч, тэдний үеийнхний аварга нь байх хүн хэрэгтэй. Манай үеийнхэн Бурханы томилсон ирэх үеийнхэнтэй хэрхэн холбоо тогтоож, тэднийг хамгаалж, бэлтгэн хүчирхэгжүүлснээ Бурханд тайлагнах болно гэж би итгэдэг.

***“Манай Камерунд ихэнх хүмүүс “өөрчлөлт”ийг хүлээж авахдаа тааруу, аливааг хуучин аргаараа хийхийг илүүд үздэг тул энэ нь шинэ санаачилгыг өсөж хөгжихөд маш хүнд удаашралтай болгодог.”
(Эрэгтэй, Нас 18-25, Камерун)***

БҮТЭЭЛЧ ЗАН БА ШИНЭ САНААЧИЛГЫГ ДЭМЖ

Шинэ Үеийн удирдагчидтай чин сэтгэлийн харилцаатай байна гэдэг эрч хүч бадраасан таатай зүйл юм. Би 25 гаруй жилийн турш залуу удирдагчдыг халамжлахад санаачилгатай идэвхтэй оролцож ирсэн бөгөөд үүнийгээ үйлчлэлийн маань нэг онцлох давуу тал гэж бодож явдаг. Том мөрөөдөж Бурханы төлөө эрсдэл хүлээхээс айдаггүй залуу удирдагч нараас эрч хүч, бүтээлч чанар, шинэ санаачилгууд тасралтгүй урсаж байдаг. Тэдэнд дутагддаг мэргэн ухаан ба төлөвшлийг нь эрч хүч ба ажил үйлс нь гүйцээж байдаг. Хоёр үеийнхэн хамтран ажилласанаар тус тусын давуу талуудаа нэгтгэн илүү үр нөлөөтэй удирдлагын багийг бүрдүүлдэг.

Бүгдээрээ үнэнийг хүлээн зөвшөөрцгөө. Залуу үеийн удирдагч нарт өмнөх үеийн удирдагч нар хэрэгтэй байдагтай яг адил өмнөх үеийн үеийн удирдагч нарт залуу удирдагч нар хэрэгтэй. Бид нас ахих тусам аливааг аль болох аюулгүй, урьдаас тооцоолох боломжтой, тав тухтай, байгаа хэвээр нь байлгах талаас нь бодож эхэлдэг. Бид тохиромжгүй арга хэрэгсэл ашиглах вий гэхээсээ илүү алдаа гаргах вий гэж айдаг.

Ирэх үеийнхэн биднийг нэг хэвийн байдал, аюулгүйн бүсээсээ гарахыг уриалж, Хаанчлалын төлөө шинэ санаачилга ба бүтээлч сэтгэлгээгээр урагшлах зориг өгдөг.

Удирдлагын үг хэллэгийн хувьд тогтмол хэрэглэвэл зохих нэг үг бол санаа боловсруулах юм. Толь бичигт үүнийг “олон янзын санааг бий болгох ба төрүүлэх үйлдэл буюу чадвар” (Merriam-Webster Inc. 2016) гэж тайлбарласан. Санаа боловсруулах гэдэг үгийн ижил утгатай үгс нь төсөөлөн бодох чадвар өндөр, зохион бүтээх чадвартай, шинийг эрэлхийлэгч зэрэг юм. ИрҮе удирдагч нар нь төсөөлөл, бүтээлч чанар, шинэ санаануудаар дүүрэн байдаг. Энэ их баялгийг Хаанчлалын төлөө олборлон ашиглах тал дээр та хэр сайн ажиллаж байна вэ?

Хэрэв та шинэ санаа, хамтын ажиллагааг дэмжих үүднээс чуулган юмуу байгууллагадаа санаа төрүүлэх өрөөтэй болвол энэ нь үйлчлэлээ тэлэхэд тань хэр их нэмэр болох бол? Энэ нь янз бүрийн дүрэм журам багатай бүтээлч байдлыг хязгаарлаагүй орчин байвал зохино. Та байгууллагынхаа Шинэ Үеийн удирдагч нарыг өмнөх үеийн удирдагч нартайгаа хамт нэг юмуу хоёр өдрөөр бие биеэ илүү таньж мэдэн, хайрцагнаас гарч сэтгэхийн тулд санаа боловсруулах семинар амралтад явахыг урьж яагаад болохгүй гэж? Шинэ Үеийн удирдагч нар өөрсдийн төсөөлөл ба хүсэл тэмүүллийнхээ дагуу хувь нэмрээ оруулж болох ямар шинэ төсөл хөтөлбөрт тэднийг хамруулж болох вэ? Тэдний санаа нь ямар уран цэцэн, шинийг эрэлхийлсэн, амжилттай гэдгийг хараад та лав гайхах буй заа.

ИТГЭЛ БА ЭРХ ЧӨЛӨӨГ ЭРХЭМЛЭДЭГ СОЁЛЫГ ЦОГЦЛОО

“Би тэднийг амьтай, бялхсан амьтай байлгахын тулд ирсэн билээ.” Иохан 10:10



АГУУ ЗАХИРАМЖИЙГ БИЕЛҮҮЛЭХ ШИНЭ ҮЕИЙН УДИРДАГЧДЫГ ӨСГӨХ НЬ

“Иймээс Хүү та нарыг чөлөөлвөл та нар үнэхээр эрх чөлөөтэй болно.” Иохан 8:36

Есүсийн Өөр рүү нь ирсэн хүмүүст өгнө гэж амласан бялхсан, эрх чөлөөтэй амьдрал нь зөвхөн анх итгэх мөчид л өгөгдсөн зүйл биш. Энэ бол сүнслэг аялалын туршид амлагдсан зүйл юм. Бидний Аврагч Өөрийн үнэт цусаараа бидэнд худалдан авч өгсөн эрх чөлөө ба бялхсан амьдралыг нь бүх үеийн хүмүүс адилхан эдлээсэй гэж хүсдэг. Итгэгч хүмүүс Христ итгэлт байгууллага дотор эрх чөлөө, итгэл, бялхсан амьдралаас илүү хянаж захиргаадах, хуучинсаг нэг хэвийн байдал ноёлсон соёл бий болговол энэ нь Бурханы ажилд саад болдог. Шинэ Үеийн удирдагч нар сүнслэг бэлэг авьяас, хүсэл тэмүүлэл, бүтээлч чанар, төрөлх чадваруудаа чөлөөтэй илэрхийлж хэрэгжүүлэх эрх чөлөөгөөр дутагдаж байгаа бол тухайн байгууллагад ямар нэг зүйл буруу байна гэсэн үг. Тэднийг удирдлагын үүргээ гүйцэтгэх үед маш хатуу хязгаар хориг байгаа бол, тэдний санааг үл тоомсорлодог бол, мөн тэд өмнөх үеийн удирдагч нартай таагүй харилцаатай бол энэ нь удирдлагын соёлд ямар нэг эрүүл бус зүйл байна гэдгийг илэрхийлдэг.

Бурхан ирэх үеийн удирдагчдыг итгэлтэй, эрх чөлөөтэй эрчүүд, эмэгтэйчүүд болон өсгөхийн тулд урам зориг өгөх үүргийг өмнөх үеийн удирдагч нарт өгсөн. Би үргэлж залуу удирдагч нарт хандан Бурхан тэдэнд “мөрөөдөх эрх чөлөө, шинийг эрэлхийлж нээх зориг” өгсөн гэж хэлдэг. Бурхан Өөрийн удирдагч нараа хүчтэй, зоригтой байгаасай гэж хүсдэг бөгөөд тэднийг чөлөөтэй мөрөөдөж, Сайнмэдээний төлөө эрсдэл үүрэхэд бэлэн эр зоригтой байгаасай гэж хүсдэг.

Та Бурханы Хаанчлалын төлөө бусдыг урамшуулдаг, хамтдаа эрсдэл хүлээдэг нэгэн мөн үү? Сүнслэг аяллынхаа одоогийн цэг дээрээс итгэлээ хэмжиж үзвэл таны итгэлийн сав дүүрэн байна уу, бараг хоосорч байна уу? Та өөрийн удирдлагын хэв маягаа эрэлхэг зоригтой гэж тодорхойлох уу? Итгэлтэй, эрх чөлөөтэй хүмүүс байхын тулд урам зориг хэрэгтэй эрин үеийнхэн гарч ирж байна. Таны үүрэг бол ирэх үеийнхэн дунд ийм хандлагыг төлөвшүүлэх, тэдэнд итгэл, зориг, Бурханы төлөө эрсдэл хүлээхэд бэлэн байдал, Бурханаас зүрхэнд тань өгсөн хүсэл эрмэлзлийг биелүүлэх эрх чөлөөг үлгэрлэн харуулах юм.

СТРАТЕГИЙН ЧАНАРТАЙ ҮҮРГИЙГ ДААЛГАХ

64

Глобал Адвансийн Глобал хэрэгцээг үнэлэх хэсэгт Шинэ Үеийн удирдагчдаас “Танд ямар боломж олговол таныг хамгийн сайн өдөөж чадах вэ?” гэж асуусан талаар дурдсан байна. Тэдний хариултыг харвал 36% нь “ямар нэг шинэ, онцгой зүйл бүтээх,” 29% нь эвдэрсэн зүйлсийг засах, 19% нь угаасаа сайн ажиллаж байгаа зүйлийг илүү сайжруулах гэсэн бол 16% нь угаасаа сайн ажиллаж байгаа зүйлээ сайн хариуцаж авч явах гэж сонгожээ.

Тэднээс мөн “Байгууллагадаа ямар үүрэг эсвэл харилцаатай байвал таныг илүү идэвхтэй оролцоход урам болох вэ?” гэж асуухад 57% нь “байгууллагынхаа соёлыг бий болгох эсвэл өөрчлөхдөө намайг оролцуулахыг хүсдэг байвал” гэсэн бол 43% нь “оролцоог олон талаар дэмждэг байгууллага” гэж сонгожээ.

ИрҮе удирдагч нар соёлыг өөрчлөх нөлөөтэй, нэгдмэл хамтын ажиллагаа сайтай багийн нэг хэсэг байхыг хүсдэг. Тэд өмнөх үеийн удирдагч нар болон байгууллагынхаа нэг хэсэг нь, хамтран зүтгэгч нь байхыг хүсдэг. Тэдний олонх нь шинэ санаачилга эхлүүлэх эсвэл шинэ санаачилгыг дахиад бүр шинэ түвшинд гаргаж ирэх дуртай. Заримдаа тэдний удирдлага ба бүтээлч байдалд тулгардаг хамгийн том саад нь тэдний өөрсдийнх нь хязгаарлагдмал байдал биш харин тэдний дээд албан тушаалд томилогдсон нэгэн тэдэнд байгууллагын удирдах үүрэг, стратегийн ач холбогдолтой үйл ажиллагаанд оролцох боломж олгодоггүй явдал байдаг.

Шинэ Үеийн удирдагчдын аливааг шүүн тунгаах, удирдах чадварт итгэл хүлээлгэх нь тэднийг хүчирхэгжүүлэх ажлын нэг хэсэг мөн. Тэд хийх шаардлага гарах үед удирдагчдын хийдэг тийм ч сайхан харагддаггүй ажлуудыг гүйцэтгэхээр хангалттай даруу байх нь чухал боловч тэдэнд хувь ногдол өндөртэй, илүү их хүчин чармайлт шаардсан ажлуудыг удирдан явуулах боломж олгох нь ч ялгаагүй чухал юм. Үе үе тэдэнд Бурханы дайтай том асуудлуудыг даалгаж байх хэрэгтэй.



***“Дэлхий хором тутамд өөрчлөгдөж байна. Харин шинэ үеийнхэн бид үүнд хэрхэн дасан зохицохоо мэддэг.”
(Эрэгтэй, Нас 18-25, Вьетнам)***



АГУУ ЗАХИРАМЖИЙГ БИЕЛҮҮЛЭХ ШИНЭ ҮЕИЙН УДИРДАГЧДЫГ ӨСГӨХ НЬ

Би олон жилийн өмнө гал сөнөөх ангийн сонсогч болсон юм. Гал түймрийг хэрхэн унтраах талаар хэдэн долоо хоногийн турш танхимын хичээл сонслоо. Тэнд олсон боловсролдоо би ихэд баярлаж гал түймрийг амжилттай сөнөөж чадах хангалттай мэдлэг эзэмшсэн мэт санагдаж байв. Гэхдээ энэ дэлхийн бүх онол ч удахгүй нүүр тулах бодит асуудлуудыг зөв шийдвэрлэхэд хангалттай бэлтгэл болж чадахааргүй байв. Зааварлагч багш нарынхаа том том галыг унтрааж байгааг хараад сурах боломжтой ч ажил дээр гарах үед надад шаардлагатай чадварыг энэ нь олгож чадахгүй юм. Хэрэв надад зөвхөн жижиг галыг унтраах ажил л даалгаж байсан бол би битүү утаанд дарагдаж шатаж байгаа байшин руу орох бэлтгэлгүй байх байсан. Манай ангийнханыг сонсогчийн түвшинд байх үеэс маань л барилгын гал болон шатахуун асгарснаас болсон галыг тодорхой хяналттай орчинд унтраах дасгал хийх боломж олон удаа олгож байсан. Энэ бэлтгэлийн ачаар бид зохих хэмжээнд бэлтгэгдэн тус тусын гал унтраах ангидаа очоод итгэлтэйгээр ажиллах бодит туршлагатай болж чадсан юм. Мөн ахмад туршлагатай гал сөнөөгчид үүнийг хараад чухал үед бидэнд найдаж болно гэдэг итгэлтэй болсон. Бидний чадварыг маш нарийн шалгаж, сурсан зүйлсийг маань бодитоор хийлгэж туршсан юм.

Үүний нэгэн адил хэрэв өмнөх үеийн удирдагч нар зөвхөн зааж, яаж удирдахыг үлгэрлэн харуулаад л зогсвол тэд Шинэ Үеийн удирдагчдыг ирээдүйд тулгарах бодит нөхцөл байдалд хангалттай сайн бэлдэж чадахгүй гэсэн үг. Залуучууд хэдий суралцах үе шатандаа явж байсан ч тэдэнд стратегийн санал санаачилгыг удирдах боломж олгох нь зүйтэй. Ингэж бэлтгэсэнээр Шинэ Үеийн удирдагч нар удирдлагын ур чадвартаа итгэлтэй болж ирээдүйд үйлчлэлийн талбарт тулгарах бэрхшээлүүдэд хангалттай бэлтгэгдсэн гэдэг итгэлийг тэдэнд төрүүлнэ.

ТОМИЛГОО БА ИЛГЭЭЛТ

“Есүс дөхөж ирээд, тэдэнд

66 *–Тэнгэр газар дээрх бүх эрх мэдлийг Надад өгсөн. Иймээс та нар яв, бүх үндэстнийг дагалдуулагтун, Эцэг, Хүү, Ариун Сүнсний нэрээр тэдэнд баптисм хүртээ, та нарт тушаасан бүгдийг минь сахин*

биелүүлэхийг тэдэнд заа. Харагтун, үеийн төгсгөл хүртэл Би та нартай үргэлж хамт байх болно гэж айлдав.” Матай 28:18-20

Тэднийг Эзэнд үйлчилж, мацаг барьж байх үед Ариун Сүнс, –Миний дуудсан үйлчлэлд Барнаб, Саул нарыг надад тусгаарлагтун гэв. Тэгээд тэд мацаг барин залбирч, тэдэн дээр гар тавиад, явуулжээ.” Үйлс 13:2-3

“Тэд чуулган бүрд ахлагчдыг томилж, мацаг барин залбирч, тэднийг өөрсдийнх нь итгэсэн Эзэнд тушаав.” Үйлс 14:23

Эцэст нь бүх удирдагч Бурханы тэдэнд зориулж төлөвлөсөн хувь тавиланг ухаарч дагахаар илгээгдэж, томилогдох ёстой. Энэ бол сүнслэг удирдлагын хөгжлийн салшгүй нэг хэсэг нь юм. Мөн энэ нь сүнслэг аяллын дунд дамжин өнгөрөх ёстой чухал зан үйл юм. Ихэнхдээ өмнөх үеийн удирдагч нар Шинэ Үеийн удирдагчдыг илгээж томилоход бэлэн болохоос өмнө Шинэ Үеийн удирдагч нар ажил үйлчлэлд томилогдоход бэлэн болчихсон байдаг. Заримдаа өмнөх үеийн удирдагч нар Шинэ Үеийн удирдагч өөрийгөө бэлэн болсон гэж мэдэхээс ч өмнө түүнийг илгээгдэхэд бэлэн болсныг мэддэг. Зарим залуу удирдагчдад тэвчээртэй байж Бурханы цагийг хүлээхийг сануулах хэрэгтэй байдаг бол заримыг нь харин өөрийгөө бэлэн болсон гэж бодохоос нь ч өмнө шинэ үүрэг хариуцуулахаар зоригжуулж, үүрнээс нь хайраар түлхэн гаргах хэрэгтэй байдаг.

Паул, Барнаб нар чуулган тарьж явахдаа зарим чуулганд нь удаан хугацаагаар тухлан чуулганы пастор удирдагчдыг томилох боломжгүй байсан. Зарим үед нь тэдэнд удирдагчдыг босгох хангалттай цаг, хүчин зүтгэл гаргах боломж олддог байсан. Заримдаа тэд хавчлага эсвэл Ариун Сүнсний ятгалгаас болж тухайн газраас явах хүртлээ хэдхэн долоо хоногт багтаан чуулган тарих ёстой болдог байсан. Тэр ч бүү хэл чуулганы удирдлагын үүргийг хариуцах шинэ удирдагч томилж, үйлчлэлд илгээхдээ Паул, Барнаб нар удирдагчдыг албан ёсоор томилоод, тэднийг тэнгэрлэг хүчээр тэтгэгдэж, амжилттай үйлчлэхийн төлөө мацаг барин, залбирч Эзэнд даатган үлдээхээс өөр аргагүй хүндхэн үеүд ч тохиож байв.



АГУУ ЗАХИРАМЖИЙГ БИЕЛҮҮЛЭХ ШИНЭ ҮЕИЙН УДИРДАГЧДЫГ ӨСГӨХ НЬ

Шинэ Үеийн удирдагчдыг томилж, үйлчлэлд гаргах ажлын хамгийн чухал нь Эзэнд итгэх итгэл юм. Паул, Барнаб нар “тэднийг өөрсдийнх нь итгэсэн Эзэнд тушаа.”-даг байсан. Шинэ Үеийн удирдагчдыг хэт удаан барьж цагдах гол шалтгаан нь айдас байдаг. Зарим тохиолдолд айдас нь бүр Сайнмэдээг тунхаглах болон даяар чуулганы өсөлтийг сааруулах гол хүчин зүйл болчихдог.

Есүсийг дээш одох үед элч нарын суралцах ёстой маш чухал нэг зүйл байсан. Тэр удирдагчдыг хөгжүүлэх ажлын зарим зайлшгүй чухал хэсгийг Ариун Сүнсэнд үлдээсэн. Есүс, *“Та нарт хэлэх зүйл Надад олон бий ч та нар одоо түүнийг дааж эс чадна. Харин үнэний Сүнс ирэхдээ та нарыг бүхий л үнэн өөд удирдана.”* (Иохан 16:12-13) гэж хэлсэн. Энэ нь өмнөх үеийн удирдагч нарт ихээхэн сургамжтай үг юм. Шинэ Үеийн удирдагч нарын амьдралд суралцах хэрэгтэй зүйлс үргэлж байсаар байх болно. Ариун Сүнс удирдагчдыг хөгжүүлэх ажлыг үргэлжлүүлж, тэдэнд сурах ёстой зүйлийг нь заана гэдэгт та найдах ёстой. Та Бурханаас зүрх сэтгэлд нь өгсөн хүсэл эрмэлзлийг биелүүлэхийг ерөөн тэднийг явуулах хэрэгтэй. Тэднийг илгээх үйл явдлыг дурсамжтай, баяр хөөртэй мөч болгон үлдээ. Чуулган ба байгууллагынхныгаа ч бас тэднийг урамшуулж, ерөөхөд уриал. Та тэднийг явуулахад бэлэн биш байгаагаас эсвэл тэд бэлэн биш байх вий гэсэн айдсаас тань болоод тэднийг байгууллагаасаа ямар нэг буруутгал тээсэн эсвэл хүмүүсээс хол хөндий харилцаатайгаар явуулж болохгүй. Ариун Сүнс зөв цаг мөн бишийг мэддэг бөгөөд бид бүгдээрээ Түүний удирдлагыг дуулгавартай дагаж, тэднийг Бурханы өгсөн хувь тавиланг биелүүлэхээр явахад нь баярлан тэмдэглэх ёстой.

Шинэ Үеийн удирдагчдыг томилж, илгээх нь бид цаашид тэдний удирдлагын үйл ажиллагаанд оролцохгүй гэсэн үг биш харин тэдэнтэй харилцах харилцааны хэлбэр маань өөрчлөгднө гэсэн үг юм. Энэ нь яг л бид төрсөн хүүхэд маань өсөж том болон насанд хүрэх үед тэдэнтэй харилцах харилцаагаа өөрчилдөгтэй адил юм. Бид тэднийг хайрлаж, амьдралынх нь нэг хэсэг байхыг хүсдэг хэвээрээ ч үүрэг ба хариуцлага маань өөр болдог.

Шинэ Үеийн удирдагчдыг томилж, илгээснээр таны шинэ үүрэг зөвлөх, халамжлагч, сүнслэг хамтран зүтгэгч эсвэл найз нөхөр ч болж болох юм. Таны тэдэнтэй ямар харилцаатай байхыг мөн хэр олон давтамжтай уулзаж байхыг тэд өөрсдөө санаачлан шийдэх боломж, орон зайг тэдэнд үлдээх нь дээр гэж зөвлөмөөр байна. Тэднийг дэмжиж, туслахад үргэлж бэлэн гэдгээ мэдүүл. Хүссэн үедээ хэзээ ч тань руу хандаж байхыг урь. Энэ бүхэн тэднийг урагш ахихад маш том дэм болно.

Нэгэнт тэднийг томилж, илгээсэн бол та одоо дахиад шинэ Шинэ Үеийн удирдагч нартай холбогдох болсон гэсэн үг. Залуучуудыг хөгжүүлж өсгөх ажилд мэргэшихийнхээ хэрээр сурсан мэдсэнээ улам бүр баяжуулж батжуулсаар бай. Шинэ Үеийн удирдагчдыг бэлтгэх үйл явцын талаар 2Тимот 2:2-оос тодорхой харсанчлан, энэ бол таны өсгөж бэлтгэсэн хүмүүс танаас сурснаа бусдад зааж дамжуулж байх үед та ч бас сурсан зүйлсээ бусдад заасаар байх явдал гэдгийг санаарай. Та болон таны хувь нэмрээ оруулсан удирдагч нар яг л Паулын Тимотод зааварласаны адил бусдыг бэлтгэн хөгжүүлэх ажлыг тасралтгүй үргэлжлүүлсээр байвал эцэстээ удирдагчдыг хөгжүүлэх ажил зэрэг дэвшүүлэх хурдаар өсөх болно. Сүнслэг удирдагч хүн Шинэ Үеийн удирдагч дараагийн үеийн өөр нэг удирдагчийг халамжлахыг харахаас илүү сэтгэл хөдлөм зүйл байна гэж үү? Энэ бол томилж, илгээхийн оргил нь юм. Ийм гайхалтай өөрчлөлт шинэчлэлтийн үйл явцад гар бие оролцоно гэдэг ямар онцгой завшаан бэ? Шинэ Үеийн удирдагчдыг босгох энэхүү ерөөлт онцгой завшааны төлөө Эзэнд талархацгаая.

ЭРГЭЦҮҮЛЭМЖ

1. Таныг анх удирдагч болох нөөц бололцоотой нэгэн гэдгээ харуулах үед хамгийн их дэмжиж хүчирхэгжүүлсэн удирдагч хэн бэ? Таныг удирдагч болж чадна гэдэгтээ итгэлтэй болоход туслахын тулд тэдний ашигласан стратегиудаас хамгийн үр дүнтэй нь юу байсан бэ? Тэр удирдагчийн таны амьдралд үзүүлсэн нөлөөллийн талаар эргэцүүлэн бодох цаг гарга. Тэдний танд анх хөрөнгө оруулсан зүйлсээс цааш нь үржигдэн үр дүнгээ өгч байгаа зүйлсийг санаарай. Таны амьдралд туршлагатай өмнөх үеийн удирдагчийг зөвшөөрсөн Аавдаа талархаарай.



АГУУ ЗАХИРАМЖИЙГ БИЕЛҮҮЛЭХ ШИНЭ ҮЕИЙН УДИРДАГЧДЫГ ӨСГӨХ НЬ

2. Шинэ Үеийн удирдагч нартай “хувь нийлүүлэгч, хамтран зүтгэгч, түнш,” зэрэг үгсийг холбон ярих үед, мөн тэд удирдлагын үйл ажиллагаанд орцолцох хүсэлтэй байгааг нь сонсоод тэднийг стратегийн чанартай ажилд оролцуулж эхлэхэд тохирох ямар үйлчлэл, шинэ санаачилга таны санаанд орж байна вэ?

3. Залуу удирдагч нар танай байгууллагаас явж байгаа шалтгаан нь та тэднийг илгээж, тэдний очих гэж буй шинэ боломжийг баярлан тэмдэглэсэнтэй холбоотой юу эсвэл тэд бухимдаж, Бурхан тэдний зүрхэнд өгсөн зүйлсийг биелүүлэхийн тулд явахаас өөр аргагүй байдалд хүрснээс болдог уу? Ур чадварыг нь дутуу ашигласанаас эсвэл хаалттай удирдлагын соёлоос болоод явсан залуу удирдагч байгаа юу? Та тэдний араас холбогдож, босгон байгуулахын тулд юу хийж болох вэ? Та өөрөө суралцаж, өөрчлөгдөхийн тулд тэдний хэлэх зарим нэг заавар зөвлөгөөг сонсоход бэлэн үү?

ЗАЛБИРАЛ

Эзэн Есүс Христ минь, Та биднийг хүчирхэгжүүлдэг байсан одоо ч хүчирхэгжүүлж байгаагийн төлөө талархъя. Та анхны дагалдагч нарт дахиад олон зүйлийг зааж болох байсан ч Ариун Сүнсний үйлчлэлд үлдсэнийг нь даатган үлдээж, дагалдагчдыг мөн стратегийн ач холбогдолтой ажилд томилж, илгээсэнд талархъя. Есүс минь, та энэ дэлхийд ирж амиа өгснөөр бид бүгдээрээ таны дотор эрх чөлөөтэй, бялхсан амьдралыг эдэлж байгаадаа талархаж байна.

Агуу Захирамжийн удирдагч байх хувь тавилангаа биелүүлэхийн тулд хүн бүрт хэрэгтэй итгэл, тэнгэрлэг эрх мэдэл болон Ариун Сүнсний хүчийг бидэнд өгдөгт баярлалаа. Бид сайнмэдээний төлөө томилогдож, илгээгдсэндээ үнэхээр талархаж байна. Биднийг үргэлжлүүлэн хүчирхэгжүүлсээр байгаач. Тэгснээр бид таны замаар алхах бусад удирдагчдыг хүчирхэгжүүлж чадах юм.

Амэн.

70

ШААРДЛАГАТАЙ АРГА ХЭМЖЭЭ	ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

ДҮГНЭЛТ

Хэрэв энэ үеийнхэн ирэх үеийнхнээ үл тоож, доогуур үнэлэвэл юу болох вэ? Тэд магадгүй энэ дэлхийнхэний хараахан мэдээгүй байгаа түүхэн дэх хамгийн агуу үеийнхэн ч юм билүү? Яагаад би ингэж зоригтой хэлж чадаж байна гээч? Учир нь тэдэнд өөрсдийн цаг хугацаандаа Агуу захирамжийг гүйцээхэд нь хэрэг болох даяаршсан харилцаа холбоо ба техник технологи, бүтээлч чанар ба хүсэл тэмүүлэл, тэнгэрлэг эрх мэдэл ба хүч чадал бүрэн өгөгдсөн. Тэдний үеийнхэн энэ дэлхий дээрх сайн мэдээ хүрээгүй үлдсэн бүх овог аймагт сайнмэдээг бүрэн тараагдаж Бурханы хаанчлал бүрэн утгаараа биеллээ олохыг угтан харах онцгой үүрэгт томилогдсон ч байж болох юм. Энэ бол маш урт хугацааны боловч биелүүлэх боломжтой даалгавар юм.

Энэ алсын хараа ирээдүйтэй сайхан санагдах ч энэхүү мөрөөдлийг бодит болгоход тэдэнд өмнөх үеийн удирдагчдынх нь тусламж хэрэгтэй. Глобал Адванс нь Агуу Захирамжийн ирэх үеийн удирдагчдын өмгөөлөгч байх замыг сонгосон. Бид тэдний хэрэгцээг үнэлэж таныг Шинэ Үеийн удирдагчдыг амжилттай хөгжүүлэхэд тань туслах бодит эх сурвалж мэдээллээр таныг хангах үүргийг баяртайгаар гүйцэтгэж байна. Эдгээр долоон зарчмыг Есүс удирдагчдыг хөгжүүлэх үйлчлэлд ашигласан бөгөөд таны хувьд ч сайн хэрэгжинэ гэдэгт итгэж байна.

Та олон улсын хэмжээнд залуу удирдагч нар ямар үзэл бодолтой байгааг сонссон. Тэд халамжлуулахыг, мөн энэ дэлхийг Есүс Христийн хайраар өөрчлөх ажилд чуулган ба байгууллагынхаа хувь нийлүүлэгч, хамтран зүтгэгч нь байхыг хүсдэг гэдгээ илэрхийлсэн. Тэд дуу хоолойгоо сонсгож, соёлыг бүтээгч, хамтран зохиогч байхыг хүсдэг. Тэд Ариун Сүнсний тэдэнд даатгасан бүтээлч чанар, халуун хүсэл тэмүүллийг ашиглан чуулганы ирээдүйн дүр төрхийг бүтээхэд хувь нэмрээ оруулахыг хүсдэг. Тэд нийгмийн бүхий л зонхилох талбарт, сайнмэдээ хүрээгүй овог аймаг бүрт сайнмэдээг тодорхой, үр дүнтэй тунхаглахыг хүсдэг.

NEXTGEN RISING

71



АГУУ ЗАХИРАМЖИЙГ БИЕЛҮҮЛЭХ ШИНЭ ҮЕИЙН УДИРДАГЧДЫГ ӨСГӨХ НЬ

Удирдагч нөхөд минь, бид Шинэ Үеийн удирдагч нарыг дааж авсан агуу үүрэг даалгаваа биелүүлэхэд нь бэлтгэн тэдэнтэй холбогдож, тэднийг хүчигжүүлэх ёстой. Бид бүгдээрээ ирэх үеийнхнийхээ “Барнаб” байж чадна. Даян дэлхийн бүх чуулган ба байгууллагад үйлчилж байгаа өмнөх үеийн удирдагчдыг Шинэ Үеийн удирдагчдыг бэлтгэх энэхүү онцгой завшаантай ажилд нэгтгэцгээе. Бүгдээрээ хамтдаа тэднийг босон зогсч, Миссио Дэйн хувьд өөрсдийн байр сууриа эзлэхэд нь туслацгаая.

НОМ ЗҮЙ

Buchanan, M. (2006). The rest of God : restoring your soul by restoring Sabbath. Nashville, Tenn., W Pub. Group.

Clinton, J. R. (1988). The making of a leader. Colorado Springs, Colo., NavPress.

Crouch, A. (2008). Culture making : recovering our creative calling. Downers Grove, Ill., IVP Books.

Ford, L. (1991). Transforming leadership : Jesus' way of creating vision, shaping values & empowering change. Downers Grove, Ill., InterVarsity Press.

Merriam-Webster Inc. (2016). The Merriam-Webster dictionary. Springfield, Massachusetts, Merriam-Webster, Incorporated.

Nouwen, H. J. M. (1986). Reaching out : the three movements of the spiritual life. Garden City, N.Y., Image Books.

Stanley, P. D. and J. R. Clinton (1992). Connecting : the mentoring relationships you need to succeed in life. Colorado Springs, Colo., NavPress.

Thrall, B., et al. (1999). The ascent of a leader : how ordinary relationships develop extraordinary character and influence / Bill Thrall, Bruce McNicol, Ken McElrath ; foreword by Ken Blanchard. San Francisco, Calif., Jossey-Bass Publishers.

West, K. (2014). Spirit-filled Savior. Rockwall, Texas, Latitude GLC. 2016

Zondervan Publishing House (Grand Rapids Mich.) (2005). Holy Bible : New International Version. Grand Rapids, Mich., Zondervan.